Хөдөлмөр эрхлэлтийн түвшин		48.1		55.6		41.9
Хөдөлмөрийн дутуу ашиглалтын нийлмэл түвшин		15.7		16.0		15.4
Ажилгүйдлийн түвшин		9.5		10.0		8.9
ЦХХББХЭ болон ажилгүйдлийн нэгдсэн түвшин		9.9		10.5		9.3
Ажилгүй хүн болон БАХ-ний нэгдсэн түвшин		15.3		15.5		15.0
<u>Хөдөө</u>						
Ажиллах хүч	387 816	100.0	209 849	54.1	177 967	45.9
Ажиллагчид	367 364	100.0	198 384	54.0	168 980	46.0
Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр	2 461	100.0	1 018	41.4	1 443	58.6
Ажилгүй хүн	20 452	100.0	11 465	56.1	8 987	43.9
Ажиллах хүчнээс гадуурх хүн ам	188 042	100.0	75 771	40.3	112 271	59.7
Боломжит ажиллах хүч	14 179	100.0	6 343	44.7	7 836	55.3
Бусад ажиллах хүчнээс гадуурх хүн ам	173 863	100.0	69 428	39.9	104 435	60.1
Ажиллах хүчний оролцооны түвшин		67.3		73.5		61.3
Хөдөлмөр эрхлэлтийн түвшин		63.8		69.5		58.2
Хөдөлмөрийн дутуу ашиглалтын нийлмэл түвшин		9.2		8.7		9.8
Ажилгүйдлийн түвшин		5.3		5.5		5.0
ЦХХББХЭ болон ажилгүйдлийн нэгдсэн түвшин		5.9		5.9		5.9
Ажилгүй хүн болон БАХ-ний нэгдсэн түвшин		8.6		8.2		9.1

Тайлбар: -ЦХХББХЭ: Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгч.

Нийт ажиллах хүчний 68.4 хувь нь хот, суурин газарт, 31.6 хувь нь хөдөө орон нутагт амьдарч байна. Ажиллагчдыг хүйсээр авч үзэхэд хот, суурин газарт эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс 4.0 нэгж хувь, хөдөөд 8.0 нэгж хувиар, ажилгүй хүний хувьд хот, суурин газарт эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс 10.2 нэгж хувь, хөдөөд 12.2 нэгж хувиар тус тус илүү байна. Байршлын хувьд ижил хандлагатай байна.

Ажиллах хүчний оролцооны түвшин хамгийн өндөр байгаа нь Увс аймаг (71.9%), хамгийн бага байгаа нь Сэлэнгэ аймаг (43.1%) байна. Хөдөлмөр эрхлэлтийн түвшин хамгийн өндөр байгаа нь Увс аймаг (69.0%), хамгийн бага байгаа нь Сэлэнгэ аймаг (32.4%) байна.

Зураг 2.4. Ажиллах хүчний оролцооны болон хөдөлмөр эрхлэлтийн түвшин, аймгаар




### 2.1.1. АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ ТҮВШИН

Ажиллах хүчний оролцооны түвшин нь тухайн улсын хөдөлмөрийн насны хүн амын хөдөлмөр эрхлэх эсхүл ажлын байр хайх замаар хөдөлмөрийн зах зээлд идэвхтэй оролцож буй хувь хэмжээг илэрхийлдэг. Өөрөөр хэлбэл, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэх боломжтой ажиллах хүчний нийлүүлэлтийн хэмжээ хөдөлмөрийн насны хүн амтай харьцуулахад хэчнээн байгааг илэрхийлдэг. Иймд уг үзүүлэлт нь тухайн улс орны хүний нөөцийн хэмжээ болон бүтцийг судлах, мөн ажиллах хүчний хэтийн нийлүүлэлтийг тооцоолоход голлох үүрэгтэй үзүүлэлт юм. Энэхүү мэдээлэл нь хөдөлмөр эрхлэлтийн бодлого боловсруулах, хүлээгдэж буй хөдөлмөрийн насыг хүйсээр тооцох, ажиллах хүч болон тэтгэвэрт гарах хүн амын түвшнийг тооцох зэрэгт ашиглагдахаас гадна нийгмийн хамгааллын системийн санхүүгийн төлөвлөлтөд чухал ач холбогдолтой болж өгдөг. Мөн хүн амын бүлгүүд хөдөлмөрийн зах зээл дээр хэрхэн өөрчлөгдөж буйг ойлгоход ашиглагддаг. Ажиллах хүчний түвшин болон оролцооны хэв маяг нь хөдөлмөр эрхлэх боломжууд болон орлогын эрэлт хэрэгцээнээс шалтгаалдаг хэдий ч хүн амын тодорхой бүлэг хооронд ялгаатай байх талтай. Жишээлбэл, эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин бүх талаараа буюу насны бүлэг, гэр бүлийн байдал, боловсролын түвшний хувьд эрэгтэйчүүдийнхээс их ялгаатай байдаг. Түүнчлэн хот, хөдөөгийн хүн амын оролцооны түвшин ч гэсэн их зөрүүтэй байдаг.

Ажиллах хүчний 2021 оны судалгаагаар АХОТ улсын хэмжээнд 56.9 хувь, хот, суурин газарт 53.1 хувь, хөдөө орон нутагт 67.3 хувьтай байна. Хот, суурин газарт АХОТ нь хөдөө, орон нутгийнхаас 14.2 нэгж хувиар доогуур (эрэгтэйчүүдийнх 11.7 нэгж хувиар, эмэгтэйчүүдийнх 15.3 нэгж хувиар доогуур) байна.

Зураг 2.5. Ажиллах хүчний оролцооны түвшин, байршил, хүйсээр




Харин улсын хэмжээнд хүйсээрх АХОТ-ний ялгаатай байдлыг авч үзэхэд эмэгтэйчүүдийнх эрэгтэйчүүдийнхээс 15.3 нэгж хувиар бага (хотод 15.8 нэгж хувиар, хөдөөд 12.2 нэгж хувиар доогуур) байна.

### НАСНЫ БҮЛГЭЭР


Ажиллах хүчний оролцооны түвшний хүйсийн ялгааг авч үзвэл 15-19, 40-54 болон 60-аас дээш насны бүлэгт харьцангуй ойролцоо буюу 3.9-9.1 нэгж хувийн зөрүүтэй байна.

Зураг 2.6. Ажиллах хүчний оролцооны түвшний хүйсийн ялгаа, насны бүлгээр



Харин эмэгтэйчүүдийн АХОТ 20-39 болон 55-59 насны бүлэгт эрэгтэйчүүдийнхээс 15.2-29.1 нэгж хувиар бага байгаа нь тухайн насны эмэгтэйчүүдийн нөхөн үржихүй болон тэтгэвэрийн настай холбоотой юм.


Зураг 2.7. Ажиллах хүчний оролцооны түвшин, насны бүлэг, хүйсээр



АХОТ хот, суурин газарт 15-19 болон 35-39 насанд хамгийн ойр буюу 8.1-8.4 нэгж хувь, 60-64 насанд хамгийн их буюу 31.9 нэгж хувийн зөрүүтэй байна. Хөдөө орон нутагт өрхийн аж

ахуйд суурилсан хөдөлмөр эрхлэлт давамгайл байдгаас ажиллах хүчний оролцооны түвшин хот, суурин газрынхаас өндөр байна.


Зураг 2.8. Ажиллах хүчний оролцооны түвшин, насны бүлэг, байршлаар



### БОЛОВСРОЛЫН ТҮВШНЭЭР

Бакалаврын дээд болон түүнээс дээш боловсролын түвшинд ажиллах хүчний оролцооны түвшин өндөр буюу 75.3-89.2 хувь байна. Энэ үзүүлэлтийг хүйсээр авч үзэхэд доктор болон дипломын дээд боловсролын түвшнээс бусад түвшинд эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс илүү байна.


Зураг 2.9. Ажиллах хүчний оролцооны түвшин, боловсролын түвшнээр, хувиар



### ГЭРЛЭЛТИЙН БАЙДЛААР

АХОТ нь гэрлэлтийн байдлаас хэрхэн хамаарч байгааг авч үзвэл огт гэрлээгүй болон бэлэвсэн хүмүүсийн оролцооны түвшин харьцангуй бага буюу 27.0-38.8 хувьтай байна. Харин гэрлэсэн, гэр бүлээ цуцлуулсан болон тусгаарласан хүмүүс хөдөлмөрийн зах зээлд идэвхтэй оролцож байна.


Зураг 2.10. Ажиллах хүчний оролцооны түвшин, хүйс, гэрлэлтийн байдлаар



## 2.1.2. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТҮВШИН

Ажиллах хүчний 2021 оны судалгааны дүнгээр хөдөлмөр эрхлэлтийн түвшин улсын хэмжээнд 52.3 хувь, хөдөөт газарт 63.8 хувь буюу хот, суурин газрынхаас 15.7 нэгж хувиар их байна. Хүйсийн хувьд хөдөөд эрэгтэйчүүдийнх 13.9 нэгж хувиар, эмэгтэйчүүдийнх 16.3 нэгж хувиар өндөр байна.


Зураг 2.11. Хөдөлмөр эрхлэлтийн түвшин, байршил, хүйсээр



## НАСНЫ БҮЛГЭЭР


Хүн амын хөдөлмөр эрхлэлтийн түвшнийг насны бүлгээр нь авч үзэхэд 15-24 болон 55-аас дээш насны бүлэгт харьцангуй бага буюу 7.9-42.9 хувь, 25-54 насны бүлэгт өндөр буюу 65.8-76.3 хувь байна. Хөдөлмөр эрхлэлтийн түвшний ялгаа хүйсийн хувьд 40-54, 60-64 насны бүлэгт харьцангуй ойролцоо буюу 3.1-4.4 нэгж хувь, 30-34 болон 55-59 насны бүлэгт хамгийн өндөр буюу 24.7-27.1 нэгж хувийн зөрүүтэй байна.

Зураг 2.12. Хөдөлмөр эрхлэлтийн түвшин хүйс, насны бүлгээр



Байршил, насны бүлгээр авч үзэхэд хөдөлмөр эрхлэлтийн түвшин хотод 35-39 насны бүлэгт 74.1 хувь, хөдөө орон нутагт 45-49 насны бүлэгт 84.5 хувь байгаа нь хамгийн өндөр байна.


Зураг 2.13. Хөдөлмөр эрхлэлтийн түвшин, насны бүлэг, байршлаар



**БОЛОВСРОЛЫН ТҮВШНЭЭР**

Боловсролын түвшнээр авч үзэхэд бакалаврын дээд болон түүнээс дээш боловсролтой хүн амын ХЭТ хамгийн өндөр буюу 69.2-86.5 хувь байна. Энэ нь хүйсийн хувьд ч хадгалагдаж (эрэгтэй 80.1 хувь, эмэгтэй 93.0 хувь) байна. Хүйсээр авч үзэхэд дипломын дээд болон докторын боловсролын түвшинд эмэгтэйчүүд 3.4-12.9 нэгж хувиар илүү, бусад боловсролын түвшинд эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс 9.4-32.0 нэгж хувиар илүү байна. Мөн боловсролгүй болон бага боловсролын түвшинд хүйсийн ялгаа их байна.

Зураг 2.14. Хөдөлмөр эрхлэлтийн түвшин, боловсролын түвшнээр, хувиар






## ГЭРЛЭЛТИЙН БАЙДЛААР

Хөдөлмөр эрхлэлтийн түвшин гэрлэлтийн байдлаас хэрхэн хамаарч байгааг нийт 15 ба түүнээс дээш насны ажиллагчдын хувьд тооцон дараах зургаар харууллаа. Хүйсийн хувьд гэр бүл цуцалсан болон бэлэвсэн эмэгтэйчүүдийн ХЭТ эрэгтэйчүүдийнхээс их байгаа бол бусад гэрлэлтийн байдлын хувьд эрэгтэйчүүдийнх их байна. Түүнчлэн, огт гэрлээгүй болон гэрлэсэн эмэгтэйчүүдийн ХЭТ эрэгтэйчүүдийнхээс их ялгаатай буюу 11.2-23.2 нэгж хувиар бага байна.


Зураг 2.15. Хөдөлмөр эрхлэлтийн түвшин, гэрлэлтийн байдлаар



## 2.2. АЖИЛЛАХ ХҮЧНЭЭС ГАДУУРХ ХҮН АМ

Улсын хэмжээнд ажиллах хүчнээс гадуурх хүн амын 7.7 хувь нь боломжит ажиллах хүч байна. Харин энэ харьцаа Баян-Өлгий аймагт 23.8 хувь, Ховд аймагт 14.0 хувь, Дорнод аймагт 10.9 хувь байгаа нь улсын дунджаас харьцангуй өндөр байна. Ажиллах хүчнээс гадуурх хүн амыг байршлаар авч үзэхэд хотод 738.7 (79.7%) мянга байгаа бол хөдөөд 188.0 (20.3%) мянга байна. Улаанбаатар хотод ажиллах хүчнээс гадуурх хүн ам 499.8 (53.9%) мянга, тэдгээрээс боломжит ажиллах хүч 42.1 (8.4%) мянга, бусад ажиллах хүчнээс гадуурх хүн ам 457.7 (91.6%) мянга байна.

Зураг 2.16. Ажиллах хүчнээс гадуурх хүн ам, аймаг, хувиар



## Хүснэгт 2.2 Ажиллах хүчнээс гадуурх хүн амын бүтэц, насны бүлэг, дүнд эзлэх хувиар

Насны бүлэг	Ажиллах хүчнээс гадуурх хүн ам		Үүнээс, хувийн жингээр	
	Тоо	%	Боломжит ажиллах хүч	Бусад
Бүгд	926 788	100	7.7	92.3
15-19	185 083	20.0	2.6	97.4
20-24	98 574	10.6	9.7	90.3
25-29	49 742	5.4	16.9	83.1
30-34	58 731	6.3	15.3	84.7
35-39	51 282	5.5	16.0	84.0
40-44	39 567	4.3	20.7	79.3
45-49	43 619	4.7	24.3	75.7
50-54	47 333	5.1	13.9	86.1
55-59	90 619	9.8	3.2	96.8
60-64	96 288	10.4	2.7	97.3
65-69	67 416	7.3	0.5	99.5
70+	98 534	10.6	0.1	99.9

Ажиллах хүчнээс гадуурх хүн амыг насны бүлгээр авч үзвэл 15-19 (20.0%) насны залуучууд хамгийн өндөр хувийг эзэлж байгаа нь тэдний сургуульд хамрагдалттай холбоотой юм. Харин нийт ажиллах хүчнээс гадуурх хүн амын 26.2 хувийг ажил, хөдөлмөр эрхлэх боломжтой буюу 25-49 насныхан эзэлж байгаа бол тэдгээрийн 71.4 хувь нь эмэгтэйчүүд байна. Бүтцийн хувьд задлан харахад боломжит ажиллах хүчний 62.2 хувь нь 25-49 насныхан, 20.2 хувь нь 15-24 насныхан, 13.4 хувь нь 50-59 насныхан байсан бол бусад ажиллах хүчнээс гадуурх хүн амын 31.5 хувь нь 15-24 насныхан, 30.3 хувь нь 60 ба түүнээс дээш насныхан байна.

## Хүснэгт 2.3. Ажиллах хүчнээс гадуурх хүн амын бүтэц, шалтгаанаар, дүнд эзлэх хувиар

	Боломжит ажиллах хүч				Бусад ажиллах хүчнээс гадуурх хүн ам			
	Бүгд		Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд		Эрэгтэй	Эмэгтэй
	Тоо	Хувь			Тоо	Хувь		
Бүгд	71 40	100	34 978	36 431	855 379	100	311 564	543 815
Суралцдаг	4 526	6.3	1 911	2 615	240 248	28.1	107 717	132 531
Тэтгэвэрт гарсан	3 421	4.8	1 880	1 541	336 946	39.4	114 639	222 307
Өвчтэй	1 119	1.6	377	742	29 999	3.5	16 161	13 838
Хөгжлийн бэрхшээлтэй	2 391	3.3	1 201	1 190	46 785	5.5	26 393	20 392
Жирэмсэн, хүүхэд асарсан	7 122	10.0	612	6 510	105 936	12.4	1 869	104 067
Бусдыг асарсан	3 879	5.4	887	2 992	19 771	2.3	4 532	15 239
Тухайн жилд цэргээс халагдсан	160	0.2	160	-	369	-	369	-
Тухайн жилд сургууль төгссөн	958	1.3	233	725	3 024	0.4	1 187	1 837
Аав, ээж, гэр бүл, үр хүүхдээ дагаад	86	0.1	73	13	1 273	0.1	362	911
Хүүхдээ сургуульд сургахаар	1 325	1.9	-	1 325	4 839	0.6	195	4 644
Гадаадад амьдарч байгаад ирсэн	678	0.9	377	301	938	0.1	513	425
Цомхотголд орсон	1 257	1.8	1 257	-	1 469	0.2	1 055	414
Улирлын чанартай ажил хийдэг болохоор	4 653	6.5	3 888	765	5 422	0.6	4 698	724
Мэргэжил, дадлага туршлага байхгүй	7 946	11.1	4 138	3 808	10 361	1.2	6 175	4 186
Мэргэжилд тохирох ажил олдохгүй	2 195	3.1	845	1 350	4 102	0.5	1 499	2 603
Ажил хайгаад олдохгүй байгаа	13 277	18.6	7 077	6 200	4 156	0.5	1 888	2 268
Цалин бага учраас	171	0.2	171	-	1 602	0.2	641	961
Голчлон өрхийн хэрэгцээнд зориулан мал малладаг	469	0.7	352	117	11 336	1.3	6 179	5 157
Үүсээд байгаа цар тахалтай холбоотой	12 861	18.0	7 726	5 135	13 311	1.6	8 281	5 030
Бусад	2 915	4.1	1 813	1 102	13 492	1.6	7 211	6 281


Ажиллах хүчнээс гадуурх хүн амын 595.3 (64.2%) мянга нь өмнө нь ямар нэгэн хөдөлмөр эрхэлж байсан ба тэдгээрийн ихэнх нь буюу 242.2 (40.7%) мянга нь хамгийн сүүлд хийж байсан ажлаас тэтгэвэрт гарсан гэж хариулсан байна.

Зураг 2.17. Ажиллах хүчнээс гадуурх хүн ам, сүүлийн ажлаас гарсан шалтгаанаар, хувиар




Ажиллах хүчнээс гадуурх хүн амын 814.9 (87.9%) мянга нь сүүлийн 30 хоногт цалинтай ажил хайх, бизнес эрхлэх оролдлого хийгээгүй, ирээдүйд ямар нэгэн хөдөлмөр эрхлэхэд бэлэн биш болон ажил хийхийг хүсээгүй байна.

Зураг 2.18. Ажиллах хүчнээс гадуурх хүн амын бүтэц, хөдөлмөрийн зах зээлийн оролцоогоор, дүнд эзлэх хувиар




Сүүлийн 30 хоногт цалинтай ажил хайх, бизнес эрхлэх оролдлого хийгээгүй ажиллах хүчнээс гадуурх хүн амыг шалтгаанаар авч үзэхэд 26.4 хувь нь гэр бүлийн, 19.7 хувь нь үүсээд байгаа цар тахлын улмаас гэж хариулсан нь өндөр хувийг эзэлж байна.

Зураг 2.19. Сүүлийн 30 хоногт цалинтай ажил олох болон бизнес эрхлэх гэж оролдоогүй ажиллах хүчнээс гадуурх хүн ам, шалтгаан, дүнд эзлэх хувиар




Ажиллах хүчнээс гадуурх хүн амын ажилгүй байх үеийн орлогын гол эх үүсвэрийг судалж үзэхэд ихэвчлэн гэр бүлийн гишүүдийн цалин болон тэтгэврийн орлого байна.

Зураг 2.20. Ажиллах хүчнээс гадуурх хүн ам, ажилгүй байх үеийн орлогын гол эх үүсвэр, дүнд эзлэх хувиар



## III. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ



### 3.1. АЖИЛЛАГЧИД


Судалгааны дүнгээр улсын хэмжээнд ажиллах хүчний 1125.6 (91.9%) мянга нь ажиллагчид байгаагийн 592.8 (52.7%) мянга нь эрэгтэйчүүд, 532.8 (47.3%) мянга нь эмэгтэйчүүд байна. Ажиллагчдын 758.2 (67.4%) мянга нь хот суурин газар, 367.4 (32.6%) мянга нь хөдөө орон нутагт оршин суугаа бөгөөд ажиллагчдын тоо бүс нутгаар нэлээд ялгаатай байна.

Хүснэгт 3.1. Ажиллагчид, байршил, бүс, хүйсээр

Байршил/Бүс	Нийт		Хүйсээр			
	Тоо	%	Эрэгтэй		Эмэгтэй	
			Тоо	%	Тоо	%
Улсын дүн	1 125 591	100.0	592 805	100.0	532 786	100.0
Хот	758 227	67.4	394 421	66.5	363 806	68.3
Хөдөө	367 364	32.6	198 384	33.5	168 980	31.7
Баруун бүс	166 889	14.8	90 592	15.3	76 297	14.3
Хангайн бүс	220 247	19.6	113 211	19.1	107 036	20.1
Төвийн бүс	169 094	15.0	89 791	15.1	79 303	14.9
Зүүн бүс	93 555	8.3	49 268	8.3	44 287	8.3
Улаанбаатар	475 806	42.3	249 943	42.2	225 863	42.4

Ажиллагчдын 475.8 (42.3%) мянга нь Улаанбаатар хотод амьдарч байгаа бол авч үзэхэд Өвөрхангай аймагт 50.6 (4.5%) мянга, Увс аймагт 47.5 (4.2%) мянга, Хөвсгөл аймагт 47.3 (4.2%) мянга, Архангай аймагт 38.3 (3.4%) мянга, Ховд аймагт 36.1 (3.2%) мянга, Хэнтий аймагт 35.7 (3.2%) мянга, Төв аймагт 35.6 (3.2%) мянга нь байна.

Зураг 3.1. Ажиллагчид, аймаг, хүйсээр



## СҮҮЛИЙН 7 ХОНОГТ АЖЛЫН БАЙРАНДАА БАЙСАН ЭСЭХ

Нийт ажиллагчдаас сүүлийн 7 хоногт ажлын байрандаа тогтмол ажиллаж байгаа ажиллагчид 1046.4 (93.0%) мянга байсан бол ажлын байрандаа түр байхгүй ажиллагчид 79.2 (7.0%) мянга байна. Байршлын хувьд ажлын байрандаа түр эзгүй байгаа ажиллагчид хот суурин газарт 67.8 (8.9%) мянга, хөдөө орон нутагт 11.3 (3.1%) мянга байна. Аймгийн хувьд энэ үзүүлэлт хүн ам ихээр төвлөрсөн бүсэд харьцангуй өндөр хувьтай байна.

### Хүснэгт 3.2 Ажиллагчид, сүүлийн 7 хоногт ажлын байрандаа байсан эсэх, бүс, байршил

Байршил/Бүс	Бүгд		Сүүлийн 7 хоног ажлын байрандаа байгаа эсэх			
	Тоо	%	Ажлын байрандаа байгаа		Ажлын байрандаа түр байхгүй	
			Тоо	%	Тоо	%
Улсын дүн	1125 591	100.0	1046 419	100.0	79 172	100.0
Хот	758 227	67.4	690 390	66.0	67 837	85.7
Хөдөө	367 364	32.6	356 029	34.0	11 335	14.3
Баруун бүс	166 889	14.8	157 465	15.1	9 424	11.9
Хангайн бүс	220 247	19.6	210 473	20.1	9 774	12.3
Төвийн бүс	169 094	15.0	159 949	15.3	9 145	11.6
Зүүн бүс	93 555	8.3	90 448	8.6	3 107	3.9
Улаанбаатар	475 806	42.3	428 084	40.9	47 722	60.3

Сүүлийн 7 хоногт ажлын байрандаа түр байхгүй байгаа ажиллагчдыг шалтгаанаар авч үзвэл 41.4 (55.4%) мянга нь үүсээд байгаа цар тахлын улмаас, 12.3 (16.5%) мянга нь амралттай байсан, 6.1 (8.1%) мянга нь жирэмсний болон эцэг эх болсны амралттай гэж хариулсан хүмүүс өндөр хувийг эзэлж байна.


### Зураг 3.2. Ажиллагчид, сүүлийн 7 хоногт ажлын байрандаа түр байгаагүй ажиллагчид, шалтгаанаар, дүнд эзлэх хувиар



## НАСНЫ БҮТЦЭЭР

Ажиллагчдын 84.4 (7.5%) мянга нь 15-24 насныхан (боловсрол, сургалтын дараах хөдөлмөрийн зах зээлд шинээр орж байгаа залуус), 927.0 (82.3%) мянга нь 25-54 насныхан (ерөнхий ажиллах хүч), 96.5 (8.6%) мянга нь 55-64 насныхан (тэтгэвэрт гарахад ойрхон байгаа) болон 17.7 (1.6%) мянга нь 65 ба түүнээс дээш насныхан байна.

Зураг 3.3. Ажиллагчид, насны бүлгээр, хүйс, хот, хөдөөгөөр



### ГЭРЛЭЛТИЙН БАЙДАЛ

Олон улсын аргачлалын дагуу 15, түүнээс дээш насны ажиллагчдын гэрлэлтийн байдлыг гэрлэсэн/ батлуулсан, батлуулаагүй/, огт гэрлээгүй, тусгаарласан, цуцалсан, бэлэвсэн гэсэн 6 бүлгээр авч үзсэн. Судалгааны дүнгээр ажиллагчдын 75.6 хувь нь гэрлэсэн, 15.4 хувь нь огт гэрлээгүй, 4.2 хувь нь бэлэвсэн хүмүүс байна. Энэ хандлага байршлын хувьд ажиглагдаж байгаа ч хот, суурин газарт гэр бүлээ батлуулсан ажиллагчдын эзлэх хувийн жин хөдөөгөөс 7.4 нэгж хувиар бага, батлуулаагүй гэр бүлтэй ажиллагчдын эзлэх хувийн жин 4.4 нэгж хувиар илүү байгаа ялгаа ажиглагдаж байна.

Хүснэгт 3.3. Ажиллагчид, гэрлэлтийн байдал, хүйс, байршлаар


Гэрлэлтийн байдал	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Хот	Хөдөө
Огт гэрлээгүй	15.4	17.5	13.0	15.3	15.5
Гэрлэсэн					
- Батлуулсан	66.5	68.5	64.4	64.1	71.5
- Батлуулаагүй	9.1	9.8	8.3	10.5	6.1
Тусгаарласан	2.6	1.9	3.4	3.2	1.3
Цуцалсан	2.2	1.1	3.3	2.8	1.2
Бэлэвсэн	4.2	1.2	7.6	4.1	4.4
Дүн, %	100.0	100.0	100.0	100.0	100.0
15, түүнээс дээш насны ажиллагчид	1 125 591	592 805	532 786	758 226	367 365



## БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, ЭЗЭМШСЭН МЭРГЭЖИЛ


Улсын хэмжээнд арван хүн тутмын гурав нь бакалаврын болон дипломын дээд боловсролтой байна. Энэ хандлага эмэгтэй ажиллагчдын хувьд эрэгтэйчүүдийнхээс их буюу арван хүн тутмын дөрөв нь, эрэгтэйчүүдийн хувьд арван ажиллагч тутмын хоёр нь техникийн болон мэргэжлийн түвшний боловсролтой байна.

Зураг 3.4. Ажиллагчид, боловсролын түвшин, хүйсээр, дүнд эзлэх хувиар



Ажиллагчдын боловсролын түвшнийг хүйсээр авч үзэхэд техникийн болон мэргэжлийн, бүрэн дунд болон түүнээс доош боловсролтой ажиллагчдын хувьд эрэгтэйчүүдийн эзлэх хувь өндөр байгаа бол тусгай мэргэжлийн дунд болон түүнээс дээш боловсролтой ажиллагчдад эмэгтэйчүүд дийлэнх хувийг эзэлж байна.


Зураг 3.5. Ажиллагчид, боловсролын түвшин, хүйсээр, хувиар



Ажиллагчдын эзэмшсэн мэргэжлийг хүйсээр авч үзэхэд зэвсэгт хүчний ажил, мэргэжил, машин механизм, төхөөрөмжийн операторч, угсрагч, үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил үйлчилгээний мэргэжилтэй эрэгтэйчүүдийн эзлэх хувь өндөр байгаа бол

худалдаа, үйлчилгээний ажилтан, контор, үйлчилгээний ажилтан мэргэжилтэй эмэгтэйчүүд дийлэнх хувийг эзэлж байна.

Зураг 3.6. Ажиллагчид, эзэмшсэн ажил мэргэжлээр, хүйсээр, хувиар



Ажиллагчдын эзэмшсэн мэргэжлийг насны бүлгээр авч үзэхэд 15-24 насныхан (боловсрол, сургалтын дараах хөдөлмөрийн зах зээлд шинээр орж байгаа залуучууд) 1.8-11.0 хувь, 25-54 насныхан (ерөнхий ажиллах хүч) 75.8-92.8 хувь, 55-64 насныхан (тэтгэвэрт гарахад ойрхон байгаа) 1.0-15.9 хувь байгаа нь дийлэнх хувийг эзэлж байна.


Зураг 3.7. Ажиллагчид, эзэмшсэн мэргэжлээр, насны бүлэг, дүнд эзлэх хувиар



### ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН


Нийт ажиллагчдын 528.7 (47.0%) мянга нь шилжих хөдөлгөөнд (хүн амын суурьшлын өөрчлөлтөөр тодорхойлогдоно) оролцсон байна. Шилжин суурьшиж байгаа шилжигчдийн 361.1 (68.3%) мянга нь Улаанбаатар хотод гол төлөв хөдөө орон нутгаас шилжин ирэгсэд байна. Аймгаар авч үзэхэд гадаад шилжих хөдөлгөөн Орхон, Баян-Өлгий аймаг руу илүү давамгайлж байгаа бол Орхон, Баян-Өлгий, Төв, Дархан-Уул аймаг руу дотоод шилжих хөдөлгөөнд оролцогчид түлхүү байна.

Зураг 3.8. Ажиллагчид, шилжих хөдөлгөөнөөр, аймгаар, дүнд эзлэх хувиар




Дотоод шилжих хөдөлгөөнд оролцогчдын насны бүтцийн тархалтыг ажиглахад тэд ихэвчлэн залуу, хөдөлмөрийн насны хүн ам байна. Залуучуудыг шилжих хөдөлгөөнд оролцсон шалтгаанаар нь харахад ихэвчлэн амьдрах нөхцөлөө сайжруулахаар, орон байраа сайжруулах, өөрчлөхөөр, аав, ээж гэр бүл үр хүүхдээ дагаад, гэрлэсэн зэрэг шалтгаан илүү байна. Гадаад шилжих хөдөлгөөний хувьд 30-39 насныхан, 45-49 насныхан илүү байгаа нь залуучууд сургууль дамжаа төгссөн, амьдрах нөхцөлөө сайжруулахаар, орон байраа өөрчлөхөөр, аав ээж гэр бүл үр хүүхдээ дагаад явсан шалтгаанууд дийлэнх хувийг эзэлж байна.

Зураг 3.9. Ажиллагчид, шилжих хөдөлгөөнөөр, насны бүлэг, дүнд эзлэх хувиар



Шилжих хөдөлгөөнд оролцсон ажиллагчдын дийлэнх нь 5-аас дээш жилийн өмнө одоогийн байршилдаа шилжин ирсэн бөгөөд хүйсийн хувьд ойролцоо байна.

Зураг 3.10. Ажиллагчид, шилжих хөдөлгөөнд оролцсон хугацаагаар, хүйс, хувиар



### АЖИЛЛАГЧИД, ҮЙЛДЛИЙН ЧАДАМЖААР


Нийт ажиллагчдын 12.7 (1.1%) мянга нь үйлдлийн чадамжийн хувьд хүндрэлтэй болон чадамжгүй байна. Байршлаар авч үзэхэд хот суурин газар болон хөдөө орон нутагт ойролцоо байгаа бол хөдөө орон нутагт их хүндрэлтэй гэж хариулсан хүмүүс 6.7 (55.2%) мянга, огт чадваргүй гэж хариулсан хүмүүс 0.3 (62.5%) мянга байгаа нь хамгийн өндөр хувийг эзэлж байна. Бүсээр авч үзэхэд Баруун бүсэд 3.9 (30.6%) мянга байгаа нь хамгийн их, харин Улаанбаатар хотод 1.6 (12.7%) мянга, Төвийн бүсэд 2.2 (17.1%) мянга байгаа нь хамгийн бага хувийг эзэлж байна.

#### Хүснэгт 3.4. Ажиллагчид, үйлдлийн чадамжаар, байршил, бүсээр

Байршил/Бүс	Бүгд		Хөгжлийн бэрхшээлтэй ажиллагчид: үйлдлийн чадамжаар			
	Тоо	%	Тийм, их хүндрэлтэй		Тийм, огт чадваргүй	
			Тоо	%	Тоо	%
Улсын дүн	12 674	100.0	12 115	100.0	559	100.0
Хот	5 638	44.5	5 428	44.8	210	37.5
Хөдөө	7 036	55.5	6 687	55.2	349	62.5
Баруун бүс	3 870	30.6	3 854	31.8	16	2.9
Хангайн бүс	2 476	19.5	2 447	20.2	29	5.3
Төвийн бүс	2 170	17.1	1 941	16.0	229	41.1
Зүүн бүс	2 545	20.1	2 432	20.1	113	20.2
Улаанбаатар	1 612	12.7	1 441	11.9	171	30.5


Ажиллагчдыг насны бүлгээр авч үзэхэд 25-29 насны 171 (30.2%), 30-34 насны 113 (10.1%) хүн огт чадваргүй гэж хариулсан нь бусад насны бүлгээс хамгийн өндөр хувийг эзэлж байна (Зураг. 3.11).

Зураг 3.11. Ажиллагчид, үйлдлийн чадамжаар, насны бүлгээр, дүнд эзлэх хувиар



Үйлдлийн чадамжийн бэрхшээлтэй ажиллагчдыг хүйсээр авч үзэхэд эрэгтэйчүүд Ховд, Дархан-Уул, Дорноговь, Дорнод, Сүхбаатар, Өвөрхангай, Говь-Алтай аймагт өндөр хувийг эзэлж байгаа бол Сэлэнгэ, Архангай, Завхан, Увс, Баянхонгор аймагт эмэгтэйчүүдийн эзлэх хувь өндөр байна.

Зураг 3.12. Үйлдлийн чадамжийн бэрхшээлтэй ажиллагчид, аймаг, нийслэл, хүйсээр, хувиар



Эдгээр ажиллагчдыг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар авч үзэхэд ХАА, ойн аж ахуй, загас барилт, ан агнуурын салбарт 7.1 (56.2%) мянга, боловсруулах үйлдвэрлэлийн салбарт 1.1 (8.9%) мянга байгаа нь бусад салбарынхаас дийлэнх хувийг эзэлж байна.

Зураг 3.13. Үйлдлийн чадамжийн бэрхшээлтэй ажиллагчид, салбараар, дүнд эзлэх хувиар




### 3.2. АЖИЛЛАГЧДЫН ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА


#### ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САЛБАРААР

Ажиллагчдын 584.9 (52.0%) мянга нь үйлчилгээний, 291.7 (25.9%) мянга нь хөдөө аж ахуйн салбарт, 249.0 (22.1%) мянга нь аж үйлдвэр, барилгын салбарт ажиллаж байна.

Зураг 3.14. Ажиллагчид, насны бүлэг, салбараар, хувиар




Зураг 3.15. Ажиллагчид, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар, дүнд эзлэх хувиар



Ажиллагчдын салбарын ялгааг хүйсээр харуулахад, эрэгтэйчүүд уул уурхай, олборлолт (68.7%), тээвэр ба агуулахын үйл ажиллагаа (66.7%), барилга (57.2%), ХАА, ойн аж ахуйн, загас барилт, ан агнуур (13.2%), төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгааллын салбарт (11.0%) ажиллаж байгаа нь хамгийн өндөр хувийг эзэлж байгаа бол эмэгтэйчүүд хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа (67.0%), боловсрол (60.3%), зочид буудал, байр сууц болон нийтийн хоолны үйлчилгээний салбарт (45.6%) ажиллаж байгаа нь хамгийн өндөр хувийг эзэлж байна.

Ажиллагчдыг эдийн засгийн үйл ажиллагааны салбарын хувьд өндөр хувь эзэлж байгаа 10 салбарыг хүйсээр харуулав (Зураг 3.16).


Зураг 3.16. Ажиллагчид, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар хүйс, хувиар



Нийт ажиллагчдын 656.6 (58.3%) мянга нь хөдөө аж ахуйн бус салбарт цалин хөлстэй ажиллаж байгаа бөгөөд тэдгээрийн 321.6 (49.0%) мянга нь эрэгтэйчүүд, 335.0 (51.0%) мянга нь эмэгтэйчүүд байна.

Харин нийт ажиллагчдын 532.8 (47.3%) мянга нь эмэгтэй ажиллагчид, тэдний 335.0 (62.9%) мянга нь хөдөө аж ахуйн бус салбарт цалинтай хөдөлмөр эрхэлж байна. ХАА-н бус салбарт цалинтай ажиллаж буй 5 эмэгтэй тутмын нэг нь боловсролын салбарт ажиллаж байна.

Зураг 3.17. ХАА-н бус салбарт цалинтай ажиллагч эмэгтэйчүүд, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар, дүнд эзлэх хувиар



### АЖИЛ МЭРГЭЖЛЭЭР

Ажиллагчдын 287.5 (25.5%) мянга нь хөдөө аж ахуй, ой, загас агнуурын мэргэшсэн ажилтан, 198.3 (17.6%) мянга нь мэргэжилтэн, 174.1 (15.5%) мянга нь худалдаа, үйлчилгээний ажилтан, 123.7 (11.1%) мянга нь үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан, 99.5 (8.8%) мянга нь машин механизм, төхөөрөмжийн операторч, угсрагч, 84.7 (7.5%) мянга нь энгийн ажил, мэргэжлээр ажиллаж байна. Харин 38.2 (3.4%) мянга нь контор, үйлчилгээний ажилтан, 35.8 (3.2%) мянга нь техникч болон туслах, дэд мэргэжилтэн, 6.1 (0.5%) мянга нь зэвсэгт хүчний мэргэжлээр ажиллаж байна.




Зураг 3.18. Ажиллагчид, ажил мэргэжлийн ангиллаар, дүнд эзлэх хувиар




Ажиллагчдыг ажил мэргэжил, хүйсээр авч үзэхэд машин механизм, төхөөрөмжийн операторч, угсрагчаар ажиллагч эрэгтэйчүүд өндөр хувьтай, харин контор, үйлчилгээний ажилтнаар ажиллагч эмэгтэйчүүд илүү өндөр хувьтай байна.

Зураг 3.19. Ажиллагчид, ажил мэргэжлийн ангилал, хүйс, дүнд эзлэх хувиар




Ажиллагчдыг эрхэлж байгаа ажил мэргэжлийн ур чадварын түвшинд авч үзвэл дунд түвшний ур чадвар бүхий ажиллагчид 723.1 (64.2%) мянга байгаа нь хамгийн өндөр хувийг эзэлж байгаа бол 311.8 (27.7%) мянга нь өндөр түвшний ур чадвартай, 84.7 (7.5%) мянга нь бага түвшний ур чадвартай, 6.1 (0.5%) мянга нь аль нэгэн түвшний ангилалд ороогүй хүмүүс ажиллаж байна.

Зураг 3.20. Ажиллагчид, эрхэлж байгаа ажил мэргэжлийн ур чадварын түвшин, хүйсээр, хувиар



Насны бүлгээр авч үзэхэд бага ур чадвар бүхий түвшний ажиллагчид 35-39 насанд 15.0 (17.7%) мянга, дунд ур чадвар бүхий түвшний ажиллагчид 35-39 насанд 119.6 (16.5%) мянга, өндөр ур чадвар бүхий түвшний ажиллагчид 30-34 насанд 64.3 (20.6%) мянга байгаа нь хамгийн өндөр хувийг эзэлж байна.

Зураг 3.21. Ажиллагчид, эрхэлж байгаа ажил мэргэжлийн ур чадварын түвшин, насны бүлэг, хувиар




### АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГЫН ХАРИУЦЛАГЫН ХЭЛБЭРЭЭР

Нийт ажиллагчдын 284.0 (25.2%) мянга нь төрийн байгууллага (төсөвт, төрийн болон орон нутгийн өмчийн)-д, 561.5 (49.9%) мянга нь хувийн хэвшилд ажиллаж байна. Тухайлбал, нийт ажиллагчдын 363.3 (32.2%) мянга нь хувийн аж ахуйн нэгж байгууллага, 198.2 (17.6%) мянга нь хувийн бизнес буюу хувь хүн байна.

Хүснэгт 3.5. Ажиллагчид, аж ахуйн нэгж байгууллагын хариуцлагын хэлбэр, байршлаар

Хариуцлагын хэлбэр	Бүгд		Байршил			
	Тоо	%	Хот		Хөдөө	
			Тоо	%	Тоо	%
Төрийн өмчит аж ахуйн оролцоотой үйлдвэрийн газар	42 766	3.8	36 850	4.9	5 916	1.6
Орон нутгийн өмчит аж ахуйн оролцоотой үйлдвэрийн газар	12 064	1.1	7 214	1.0	4 850	1.3
Төсөвт байгууллага	229 144	20.4	178 885	23.5	50 259	13.7
Төрийн бус байгууллага (сүм, хийд)	9 475	0.8	8 499	1.1	976	0.3
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн газар	874	0.1	744	0.1	130	-
Хувийн аж ахуйн нэгж байгууллага	363 270	32.2	331 262	43.7	32 008	8.7
Хувийн бизнес буюу хувь хүн (ферм болон ХХК биш)	198 215	17.6	158 161	20.9	40 054	10.9
Өрхийн аж ахуй	269 783	24.0	36 612	4.8	233 171	63.5
Нийт	1 125 591	100.0	758 227	100.0	367 364	100.0

Зураг 3.22. Ажиллагчид, байгууллагын хариуцлагын хэлбэр, бүсээр, хувиар



### ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН СТАТУСААР

Ажиллагчдыг хөдөлмөр эрхлэлтийн статусаар авч үзэхэд гурван хүн тутмын нэг нь цалин хөлстэй ажиллагчгүй, зах зээлд чиглэсэн өрхийн аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгч, дөрвөн хүн тутмын нэг нь цалин хөлстэй түр ажиллагч байна. Түүнчлэн энэ харьцаа хүйсийн хувьд хадгалагдаж байна.


Хүснэгт 3.6. Ажиллагчид, хөдөлмөр эрхлэлтийн статус, хүйс, дүнд эзлэх хувиар

Статус	Бүгд		Эрэгтэй		Эмэгтэй	
	Тоо	%	Тоо	%	Тоо	%
Нийт ажиллагчид	1 125 591	100.0	592 805	100.0	532 786	100.0
Ажил олгогч:						
Аж ахуйн нэгж, байгууллагын ажил олгогч	21 093	1.9	14 195	2.4	6 898	1.3
Зах зээлд чиглэсэн өрхийн аж ахуйн нэгжийн ажил олгогч	20 714	1.8	12 122	2.0	8 592	1.6
Цалин хөлстэй ажиллагчгүй бие даасан ажиллагч:						
Цалин хөлстэй ажиллагчгүй аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаа эрхлэгч	10 510	0.9	3 993	0.7	6 517	1.2
Цалин хөлстэй ажиллагчгүй, зах зээлд чиглэсэн өрхийн аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгч	381 181	33.9	223 291	37.7	157 890	29.6
Гүйцэтгэх гэрээлэгч	2 961	0.3	1 364	0.2	1 597	0.3
Цалин хөлстэй ажиллагч:						
Цалин хөлстэй байнгын ажиллагч	362 540	32.2	174 856	29.5	187 684	35.2
Цалин хөлстэй түр ажиллагч	267 894	23.8	133 717	22.5	134 177	25.2
Цалин хөлстэй тохиолдлын ажиллагч	32 000	2.9	18 704	3.2	13 296	2.6
Цалин хөлстэй дагалдан ажилтан, мэргэшиж буй дадлагажигч ажилтан, дагалдан дадлагажигч	4 723	0.4	2 486	0.4	2 237	0.4
Хувь нэмрээ оруулагч гэр бүлийн гишүүн	16 912	1.5	7 170	1.2	9 742	1.8
Эдгээр статуст хамрагдаагүй ажиллагчид	5 063	0.4	907	0.2	4 156	0.8

Ажиллагчдын 255.3 (22.7%) мянга нь хөдөө аж ахуйн салбарт зах зээлд чиглэсэн хөдөө аж ахуйн мэргэшсэн ажилтан болон өрхийн хэрэгцээт амь зуулгын фермийн ажил мэргэжлээр (малчид) ажиллаж байна. Харин статусын хувьд цалин хөлстэй ажиллагчгүй, зах зээлд чиглэсэн өрхийн аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгч 381.2 мянган ажиллагчдын 224.6 (58.9%) мянга нь хөдөө аж ахуйн салбарт зах зээлд чиглэсэн хөдөө аж ахуйн мэргэшсэн ажилтан болон өрхийн хэрэгцээт амь зуулгын фермийн ажил мэргэжлээр (малчид) ажиллаж байна.

Нийт ажиллагчдын 7.4 (0.7%) мянга нь давхар хөдөлмөр эрхэлж байна. Тэдгээрийн 4.6 (61.6%) мянга нь эрэгтэйчүүд, 2.8 (38.4%) мянга нь эмэгтэйчүүд байна.

Зураг 3.23. Ажиллагчид, хөдөлмөр эрхлэлтийн статусаар, аймгаар



### ХУВИАРАА ХӨДӨЛМӨР ЭРХЛЭГЧИД

Нийт ажиллагчдын 205.8 (18.3%) мянга нь хувиараа хөдөлмөр эрхлэгчид байна. Тэдгээрийн 123.9 (60.2%) мянга нь эрэгтэйчүүд, 81.9 (39.8%) мянга нь эмэгтэйчүүд байна. Хувиараа хөдөлмөр эрхлэгчид Улаанбаатар хот болон Хэнтий, Увс, Баян-Өлгий, Ховд аймагт (4.1-49.0%) хамгийн өндөр хувийг эзэлж байна.

Зураг 3.24. Хувиараа хөдөлмөр эрхлэгчид, аймаг, хүйсээр, дүнд эзлэх хувиар



Хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар харахад бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар үйлчилгээний салбарт 71.0 (34.5%) мянга, ХАА, ойн загас барилт, ан агнуурын салбарт 30.6 (14.9%) мянга байгаа нь хамгийн өндөр хувийг эзэлж байна.

Зураг 3.25. Хувиараа хөдөлмөр эрхлэгчид, салбараар, дүнд эзлэх хувиар



### МАЛ АЖ АХУЙ

Нийт ажиллагчдын 255.9 (22.7%) мянга нь жилийн 4 улирлын туршид мал аж ахуй эрхэлж малын ашиг шим нь тэдний амьжиргааны эх үүсвэр нь болж байгаа иргэд буюу малчид байна. Малчдыг бүсээр авч үзэхэд Хангайн бүсэд хамгийн өндөр буюу 40.1 хувь, Улаанбаатар хот болон Зүүн бүсэд хамгийн бага буюу 0.3-11.6 хувийг эзэлж байна. Судалгааны дүнгээр нийт мал аж ахуй эрхлэгчдийн 1.0 (0.4%) мянга нь цалин хөлстэй туслах малчин, байршлын хувьд Зүүн бүсэд хамгийн их буюу 758 (74.0%) хүн, Хангайн бүсэд хамгийн бага буюу 53 (5.1%) хүн, харин Төвийн бүс болон Улаанбаатар хотод туслах малчин байхгүй байна.

Хүснэгт 3.7. Нийт ажиллагчид болон нийт малчид, байршил, бүсээр

Байршил/Бүс	Нийт ажиллагчид	%	Нийт малчин (үүнээс):		Туслах малчин	
			Тоо	%	Тоо	%
Улсын дүн	1125 591	100.0	255 865	100.0	1025	100.0
Хот	758 227	67.4	27 107	10.6	258	25.2
Хөдөө	367 364	32.6	228 758	89.4	767	74.8
Баруун бүс	166 889	14.8	65 509	25.5	214	20.9
Хангайн бүс	220 247	19.6	102 486	40.1	53	5.1
Төвийн бүс	169 094	15.0	57 510	22.5	-	-
Зүүн бүс	93 555	8.3	29 642	11.6	758	74.0
Улаанбаатар	475 806	42.3	718	0.3	-	-

### 3.3. АЖЛЫН ЦАГ


Улсын хэмжээнд ажиллагчдын долоо хоногт тогтмол ажилладаг үндсэн ажлын дундаж цаг 48 цаг байгаа бөгөөд хүйсийн хувьд эрэгтэйчүүдийнх 51 цаг, эмэгтэйчүүдийнх 45 цаг байна. Нийт ажиллагчдын 425.6 (37.8%) мянга нь 7 хоногт тогтмол 48 цагаас дээш цагаар ажиллаж байна.

Хүснэгт 3.8. Ажиллагчдын долоо хоногт тогтмол ажилладаг цаг, үндсэн ажлаар

Ажлын цаг	Нийт		Эрэгтэй		Эмэгтэй	
	Тоо	%	Тоо	%	Тоо	%
Нийт	1 125 591	100.0	592 805	100.0	532 786	100.0
1-14 цаг	3 728	0.3	1 807	0.3	1 921	0.4
15-29 цаг	16 850	1.5	5 026	0.9	11 824	2.2
30-34 цаг	8 167	0.7	2 642	0.4	5 525	1.0
35-39 цаг	22 430	2.0	8 728	1.5	13 702	2.6
40-48 цаг	648 844	57.7	292 407	49.3	356 437	66.9
48-аас дээш цаг	425 572	37.8	282 195	47.6	143 377	26.9

Ажиллагчдын үндсэн ажилдаа 7 хоногт тогтмол ажилладаг дундаж цагийг хөдөлмөр эрхлэлтийн статусын хувьд авч үзэхэд цалин хөлстэй ажиллагчгүй аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаа эрхлэгч 56 цаг, зах зээлд чиглэсэн өрхийн аж ахуйн нэгжийн ажил олгогч 55 цаг зарцуулж байгаа нь хамгийн өндөр байгаа бол цалин хөлстэй дагалдан ажилтан, мэргэшиж буй дадлагажигч ажилтан хамгийн бага буюу 43 цаг зарцуулж байна. Хүйсийн хувьд эдгээр статуст хамрагдаагүй эрэгтэй ажиллагчид хамгийн өндөр буюу 66 цаг байхад цалин хөлстэй ажиллагчгүй аж ахуй нэгж, байгууллагын үйл ажиллагаа эрхлэгч болон зах зээлд чиглэсэн өрхийн аж ахуйн нэгжийн ажил олгогч эмэгтэй ажилтны тус бүр 54 цаг байгаа нь хамгийн өндөр байна.

Зураг 3.26. Ажиллагчдын долоо хоногт тогтмол ажилладаг цаг, үндсэн ажлаар, хөдөлмөр эрхлэлтийн статусаар, хүйсээр



Нийт ажиллагчдын 28.7 (2.6%) мянга нь долоо хоногт тогтмол бага цагаар (долоо хоногт 35-аас бага цаг) ажиллаж байгаагаас дийлэнх нь хотод ажиллаж байна. Ажиллагчдыг эдийн засгийн үйл ажиллагааны үндсэн салбараар авч үзэхэд үйлчилгээний салбарт, хөдөлмөр эрхлэлтийн статусаар цалин хөлстэй ажиллагчгүй зах зээлд чиглэсэн өрхийн аж ахуй эрхлэгчид дийлэнх хувийг эзэлж байна.

Харин нийт ажиллагчдын 550.6 (48.9%) мянга нь долоо хоногт тогтмол урт цагаар (долоо хоногт 48-аас дээш цаг) ажиллаж байгаагаас дийлэнх нь хотод ажиллаж байна. Ажиллагчдыг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар авч үзэхэд хөдөө аж ахуйн салбарт, хөдөлмөр эрхлэлтийн статусаар цалин хөлстэй ажиллагчгүй, зах зээлд чиглэсэн өрхийн аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчид дийлэнх хувийг эзэлж байна.

### Хүснэгт 3.9. Үндсэн ажилдаа бага болон урт цагаар ажиллагчид, хүйс, салбар, хөдөлмөр эрхлэлтийн статусаар, дүнд эзлэх хувиар

Үзүүлэлтүүд	Нийт	Бага цагаар ажиллагчид (долоо хоногт 35 хүртэл цаг)		Урт цагаар ажиллагчид (долоо хоногт 48-аас дээш цаг)	
		Тоо	%	Тоо	%
Бүгд	1 125 591	28 747	100.0	550 634	100.0
Эрэгтэй	592 805	9 476	33.0	356 686	64.8
Эмэгтэй	532 786	19 271	67.0	193 948	35.2
Хот	758 227	15 605	54.3	334 436	60.7
Хөдөө	367 364	13 142	45.7	216 198	39.3
Үндсэн салбараар:					
Хөдөө аж ахуй	291 677	11 148	38.8	207 036	37.6
Аж үйлдвэр, барилга	248 987	3 625	12.6	138 358	25.1
Үйлчилгээний	584 927	13 974	48.6	205 240	37.3
Хөдөлмөр эрхлэлтийн статусаар:					
Аж ахуйн нэгж, байгууллагын ажил олгогч	21 093	489	1.7	13 748	2.5
Зах зээлд чиглэсэн өрхийн аж ахуйн нэгжийн ажил олгогч	20 714	507	1.8	16 306	3.0
Цалин хөлстэй ажиллагчгүй аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаа эрхлэгч	10 510	151	0.5	8 609	1.6
Цалин хөлстэй ажиллагчгүй, зах зээлд чиглэсэн өрхийн аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгч	381 181	18 218	63.4	263 973	47.9
Гүйцэтгэх гэрээлэгч	2 961	669	2.3	1 599	0.3
Цалин хөлстэй байнгын ажиллагч	362 540	2 574	9.0	104 988	19.1
Цалин хөлстэй түр ажиллагч	267 894	3 188	11.1	107 121	19.5
Цалин хөлстэй тохиолдлын ажиллагч	32 000	1 539	5.4	19 751	3.6
Цалин хөлстэй дагалдан ажилтан, мэргэшиж буй дадлагажигч ажилтан	4 723	94	0.3	764	0.1
Хувь нэмрээ оруулагч гэр бүлийн гишүүн	16 912	1 236	4.3	10 248	1.9
Эдгээр статуст хамрагдаагүй ажиллагчид	5 063	82	0.3	3 526	0.6

Ажиллагчдын тогтмол ажилладаг цагаараа ажилласан эсэхэд тийм гэж хариулсан нь 1027.3 (91.3%) мянга буюу дийлэнх хувийг эзэлж байгаа бол, ажлын цагаас бага ажилласан 86.5 (7.7%) мянга, ажлын цагаасаа илүү ажилласан 11.8 (1.0%) мянга байна.

Хүснэгт 3.10. Ажиллагчдын тогтмол ажилладаг цагаараа ажилласан эсэх

Байршил/Бүс	Бүгд		Тогтмол ажилдаг цагаараа ажилласан эсэх					
	Тоо	%	Тийм		Үгүй, ажлын цагаас илүү		Үгүй, ажлын цагаас бага	
			Тоо	%	Тоо	%	Тоо	%
Улсын дүн	1125 591	100.0	1027 342	100.0	11 791	100.0	86 458	100.0
Хот	758 227	67.4	684 220	66.6	5 874	49.8	68 133	78.8
Хөдөө	367 364	32.6	343 122	33.4	5 917	50.2	18 325	21.2
Баруун бүс	166 889	14.8	154 147	15.0	1 282	10.9	11 460	13.3
Хангайн бүс	220 247	19.6	211 055	20.5	1 715	14.6	7 477	8.6
Төвийн бүс	169 094	15.0	150 327	14.6	3 746	31.7	15 021	17.4
Зүүн бүс	93 555	8.3	84 987	8.4	1 625	13.8	6 943	8.0
Улаанбаатар	475 806	42.3	426 827	41.5	3 423	29.0	45 556	52.7

Зураг 3.27. Ажиллагчид, тогтмол ажилладаг цагаасаа илүү/дутуу ажилласан шалтгаанаар




Ажиллагчдыг сүүлийн 7 хоногт тогтмол ажлын цагаасаа илүү эсвэл дутуу ажилласан шалтгаанаар авч үзэхэд 48.3 (49.1%) мянга нь үүсээд байгаа цар тахлын улмаас, 11.8 (12.0%) мянга нь өдрийн чөлөө, амралт, жилийн чөлөө, тусгай чөлөө, 7.4 (7.6%) мянга нь улирлын чанартай ажил, 6.5 (6.6%) мянга нь ээлжийн ажил болон тогтмол бус уян хатан ажлын цагтай ажлаас шалтгаалсан гэх хариултууд дийлэнх хувийг эзэлж байна.

3.4. ЦАЛИН, ОРЛОГО

Судалгаагаар албан болон албан бус салбарт, өрхийн нэгжид ажиллаж байгаа бүх цалин хөлстэй ажиллагчдын цалингийн мэдээллийг гарт олгогдсон дүнгээр авсан болно. Эдийн засгийн бүх нэгжид ажиллаж буй цалинтай ажиллагчдын сарын дундаж цалин улсын хэмжээнд 905.8 мянга, Улаанбаатарт хамгийн өндөр буюу 963.8 мянга, хамгийн бага нь Баруун бүсэд 781.9 мянган төгрөг байна.



Зураг 3.28. Цалинтай ажиллагчдын сарын дундаж цалин, хүйс, бүсээр, мянган төгрөгөөр



Хүснэгт 3.11. Цалинтай ажиллагчдын нэг цагийн дундаж цалин, хүйсээр

Үзүүлэлт	Нэг цагийн дундаж цалин		
	Бүгд	Хот	Хөдөө
Улсын дундаж, мянган төгрөг	4.8	5.0	4.2
Эрэгтэй	5.2	5.3	4.5
Эмэгтэй	4.5	4.6	4.0
Жендэрт суурилсан цалингийн ялгаа (%)	13.5	13.2	11.1

Цалинтай ажиллагчдын цагийн дундаж цалин улсын хэмжээнд 4.8 мянга, эрэгтэйчүүдийнх 5.2 мянга, эмэгтэйчүүдийнх 4.5 мянган төгрөг байна. Жендэрт суурилсан цалингийн ялгаа улсын хэмжээнд 13.5 хувь байна. Энэ үзүүлэлт нь байршлын хувьд ялгаатай байна.


Судалгаагаар мөн хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн орлогын мэдээллийг асуусан ба тэдгээр ажиллагчдын сарын дундаж орлого улсын хэмжээнд 1.3 сая төгрөг байна. Бүсээр авч үзэхэд хамгийн өндөр нь Төвийн бүсэд 3.2 сая төгрөг, хамгийн бага нь Зүүн бүс 726.5 мянган төгрөг байна.

Зураг 3.29. Хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн сарын дундаж орлого, хүйс, бүсээр, мянган төгрөгөөр




Цалинтай ажиллагчдын сарын дундаж цалин хот суурин газарт 1006.5 мянган төгрөг, хөдөө орон нутагт 807.8 мянган төгрөг байна. Харин хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн хувьд сарын дундаж орлого нь хот суурин газарт 1443.5 мянган төгрөг, хөдөө орон нутагт 986.3 мянган төгрөг байна.

Зураг 3.30. Ажиллагчдын сарын дундаж цалин болон орлого, байршил, хүйсээр, мянган төгрөгөөр



Цалинтай ажиллагчдын сарын дундаж цалинг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар авч үзэхэд хамгийн өндөр нь уул уурхай, олборлолтын салбарт 1.5 сая төгрөг, үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагааны салбарт 1.4 сая төгрөг байна. Харин хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн сарын дундаж орлогыг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар авч үзэхэд, тээвэр ба агуулахын үйл ажиллагааны салбарт 2.5 сая төгрөг, удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны салбарт 1.8 сая төгрөг байгаа нь өндөр үзүүлэлттэй байна.

Зураг 3.31. Ажиллагчдын сарын дундаж цалин болон орлого, салбар, мянган төгрөгөөр



■ Хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн сарын дундаж орлого  
 ■ Цалинтай ажиллагчдын сарын дундаж цалин


### 3.5. 0-14 НАСНЫ ХҮҮХЭДТЭЙ ӨРХ ТОЛГОЙЛСОН ЭМЭГТЭЙ АЖИЛЛАГЧИД

Нийт ажиллагчдын 79.7 (7.1%) мянга нь 0-14 насны хүүхэдтэй өрх толгойлсон эмэгтэйчүүд байна. Тэдгээрийн 73.5 (92.3%) мянга нь 0-4 насны хүүхэдтэй, 5.9 (7.5%) мянга нь 5-9 насны хүүхэдтэй, 193 (0.2%) хүн нь 10-14 насны хүүхэдтэй эхчүүд байна. Байршлын хувьд 61.0 (76.5%) мянга нь хотод, 18.7 (23.5%) мянга нь хөдөө орон нутагт амьдарч байна.

Хүснэгт 3.12. Өрх толгойлсон, өрхөд 0-14 насны хүүхэдтэй эмэгтэй ажиллагчид, байршил, бүсээр

Байршил/Бүс	Өрх толгойлсон эмэгтэй ажиллагчид							
	Бүгд		(0-4 насны хүүхэдтэй)		(5-9 насны хүүхэдтэй)		(10-14 насны хүүхэдтэй)	
	Тоо	%	Тоо	%	Тоо	%	Тоо	%
Улсын дүн	79 657	100.0	73 527	100.0	5 937	100.0	193	100.0
Хот	60 949	76.5	56 300	76.6	4 456	75.1	193	100.0
Хөдөө	18 708	23.5	17 227	23.4	1 481	24.9	-	-
Баруун бүс	6 005	7.5	5 507	7.5	498	8.4	-	-
Хангайн бүс	15 661	19.7	14 546	19.8	1 115	18.8	-	-
Төвийн бүс	12 922	16.2	12 465	17.0	457	7.7	-	-
Зүүн бүс	6 975	8.8	6 244	8.5	538	9.1	193	100.0
Улаанбаатар	38 094	47.8	34 765	47.3	3 329	56.1	-	-

Зураг 3.32. Хүүхэдтэй өрх толгойлсон эмэгтэйчүүд, насны бүлэг, хувиар




Нийт хөдөлмөрийн насны эмэгтэйчүүдийн 0.5 (0.3%) мянга нь хүүхэдтэй өрх толгойлсон 20-24 насны эмэгтэйчүүд байна. Энэ үзүүлэлт нас ахих тусам нэмэгдэх хандлага харагдаж байна. Өрх толгойлсон эмэгтэйчүүдийн хувь нэмэгдэхэд гэр бүл салалт, нөхөр нь нас барсан, эцэг байх эрхээ шүүхийн шийдвэрээр хязгаарлуулсан гэх мэт шалтгаан нөлөөлсөн байх талтай юм.

Зураг 3.33. Өрх толгойлсон эмэгтэй ажиллагчид, боловсролын түвшнээр, дүнд эзлэх хувиар



Өрх толгойлсон эмэгтэй ажиллагчдын 15.9 (22.8%) мянга нь дипломын дээд болон бакалавр, 13.4 (19.2%) мянга нь техникийн болон мэргэжлийн, 12.2 (17.5%) мянга нь тусгай мэргэжлийн дунд боловсрол эзэмшсэн нь хамгийн өндөр хувийг эзэлж байгаа бол 6.0 (8.5%) мянга нь бүрэн дунд, 3.0 (4.3%) мянга нь боловсролгүй, 2.1 (2.9%) мянга нь магистр боловсролтой байгаа нь хамгийн бага хувийг эзэлж байна.


Зураг 3.34. Өрх толгойлсон эмэгтэй ажиллагчид, хөдөлмөр эрхлэлтийн статус, дүнд эзлэх хувиар



Өрх толгойлсон эмэгтэй ажиллагчдын 37.3 (38.7%) мянга нь цалин хөлстэй байнгын ажиллагч, 26.0 (26.9%) мянга нь цалин хөлстэй ажиллагчгүй, зах зээлд чиглэсэн өрхийн аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгч, 23.2 (24.1%) мянга нь цалин хөлстэй түр ажиллагчид байгаа нь хамгийн өндөр хувийг эзэлж байна.



## IV.ХӨДӨЛМӨРИЙН ДУТУУ АШИГЛАЛТ



#### 4.1. ХӨДӨЛМӨРИЙН ДУТУУ АШИГЛАЛТЫН ХЭМЖЭЭ, БҮТЭЦ


Судалгааны 2021 оны дүнгээр улсын хэмжээнд хөдөлмөр эрхлэлтийн хэрэгцээ бүрэн хангагдахгүй байгаа хөдөлмөрийн насны хүн ам буюу хөдөлмөрийн дутуу ашиглалт 177.3 мянга байгаагийн 99.8 (56.3%) мянга нь ажилгүй хүн, 71.4 (40.3%) мянган нь боломжит ажиллах хүч, 6.1 (3.4%) мянга нь цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгчид байна.

Хүснэгт 4.1. Хөдөлмөрийн дутуу ашиглалт, байршил, бүс, хүйсээр

Байршил/Бүс	Бүгд		Ажилгүй хүн		Боломжит ажиллах хүч		Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэлт	
	Тоо	%	Тоо	%	Тоо	%	Тоо	%
Хот	140 192	79.1	79 326	79.5	57 231	80.1	3 635	59.6
Хөдөө	37 091	20.9	20 452	20.5	14 178	19.9	2 461	40.4
Эрэгтэй	93 316	52.6	55 191	55.3	34 978	49.0	3 147	51.6
Эмэгтэй	83 967	47.4	44 587	44.7	36 431	51.0	2 949	48.4
Баруун бүс	36 107	20.4	15 880	15.9	15 831	22.2	4 396	72.1
Хангайн бүс	23 991	13.5	20 120	20.2	3 740	5.2	131	2.2
Төвийн бүс	24 515	13.8	18 505	18.5	5 773	8.1	237	3.9
Зүүн бүс	8 331	4.7	4 176	4.2	3 972	5.6	183	3.0
Улаанбаатар	84 339	47.6	41 097	41.2	42 093	58.9	1 149	18.8
Дүн, %		100.0		100.0		100.0		100.0
Улсын дүн	177 283		99 778		71 409		6 096	

Хөдөлмөрийн дутуу ашиглалтыг аймаг, нийслэлээр авч үзэхэд 84.3 (47.6%) мянга нь Улаанбаатар хотод байна.

Зураг 4.1. Хөдөлмөрийн дутуу ашиглалт, аймаг, нийслэл, хүнээр



#### ҮЙЛДЛИЙН ЧАДАМЖИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ХӨДӨЛМӨРИЙН ДУТУУ АШИГЛАЛТ

Хөдөлмөрийн дутуу ашиглалтын 3.9 (2.2%) мянга нь үйлдлийн чадамжийн бэрхшээлтэй иргэд байна. Хүйсийн хувьд ялгаа ажиглагдахгүй байгаа бол бүсийн хувьд Улаанбаатар хотод 2.1 (2.5%) мянга байгаа нь хамгийн өндөр, Баруун бүсэд 0.2 (0.7%) мянга байгаа нь хамгийн бага дүнтэй байна.




Хүснэгт 4.2. Үйлдлийн чадамжийн бэрхшээлтэй хөдөлмөрийн дутуу ашиглалтын бүлэг дэх хүн ам, бүс, хүйс, байршлаар, хүнээр

Нийт	Бүгд	Нийт ХДА-д эзлэх хувь	Дүнд эзлэх хувь
Улсын дүн	3 869	2.2	100.0
Эрэгтэй	2 178	2.3	49.9
Эмэгтэй	1 691	2.0	50.1
Хот	2 873	2.0	78.0
Хөдөө	996	2.7	22.0
Баруун бүс	239	0.7	19.4
Хангайн бүс	786	3.3	10.2
Төвийн бүс	579	2.4	13.0
Зүүн бүс	158	1.9	6.1
Улаанбаатар	2 107	2.5	51.3

Хөдөлмөрийн дутуу ашиглалтын бүлэгт хамрагдаж байгаа үйлдлийн чадамжийн бэрхшээлтэй иргэдийг насны бүлгээр авч үзэхэд 30-34 насны 1.1 (27.6%) мянга, 45-54 насны 1.3 (33.9%) мянга байгаа нь бусад насны бүлгээс хамгийн өндөр байна. Хүйсийн хувьд хамгийн их хувийг эзэлж байгаа насны бүлгийг авч үзэхэд, 30-34 насны бүлэгт эрэгтэйчүүд 0.5 (20.9%) мянга, эмэгтэйчүүд 0.6 (36.2%) мянга байна.

Зураг 4.2. Үйлдлийн чадамжийн бэрхшээлтэй хөдөлмөрийн дутуу ашиглалтын бүлэг дэх хүн ам, насны бүлэг, хүйс, дүнд эзлэх хувиар



### ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНИЙ БАЙДАЛ

Нийт хөдөлмөрийн дутуу ашиглалтын 21.8 (12.3%) мянга нь сүүлийн 5 жилд шилжих хөдөлгөөнд оролцсон, тэдгээрийн 55.0 хувь нь эрэгтэйчүүд, 45.0 хувь нь эмэгтэйчүүд байна. Мөн эдгээр хүн амын шилжих хөдөлгөөний урсгалыг авч үзэхэд 95.7 хувь нь дотоод, 4.3 хувь нь гадаад шилжих хөдөлгөөнд оролцсон байна.


Хүснэгт 4.3. Шилжих хөдөлгөөнд оролцсон хөдөлмөрийн дутуу ашиглалт, дотоод, гадаад урсгалаар

Хугацаагаар	Бүгд		Дотоод		Гадаад	
	Тоо	%	Тоо	%	Тоо	%
Бүгд	86 168	100.0	85 045	100.0	1 123	100.0
Сүүлийн 1 жил	2 836	3.3	2 679	3.2	157	14.0
Сүүлийн 2-5 жил	18 928	22	18 142	21.3	786	69.9
Сүүлийн 5-аас дээш жилийн өмнө	64 404	74.7	64 224	75.5	180	16.1

Сүүлийн 5 жилд дотоод шилжих хөдөлгөөнд оролцсон 15-29 насны залуучуудын ихэнх буюу 22.0-32.2 хувь нь сургууль, дамжаа төгсөөд шилжих болсон байна. Харин 25-54 насны хүн амын 24.4-100.0 хувь нь амьдрах нөхцөлөө сайжруулахаар, орон байраа өөрчлөхөөр шилжих хөдөлгөөнд оролцсон байна.

Сүүлийн 5 жилийн хувьд шилжих хөдөлгөөнд оролцсон хөдөлмөрийн дутуу ашиглалтын бүлэгт багтаж байгаа хүн амыг насны бүтцээр авч үзэхэд 20-29 насныхан хамгийн өндөр хувийг эзэлж байна. Нийт гадаад шилжих хөдөлгөөны хамгийн их буюу 67.1 хувийг 25-29 насныхан эзэлж байна.


Зураг 4.3. Шилжих хөдөлгөөнд оролцсон хөдөлмөрийн дутуу ашиглалт, дотоод, гадаад урсгал, насны бүлэг, дүнд эзлэх хувиар



### ХҮҮХЭДТЭЙ ӨРХ ТОЛГОЙЛСОН ЭМЭГТЭЙЧҮҮД

Хөдөлмөрийн дутуу ашиглалтын бүлэгт багтаж байгаа хүн амын 84.0 (47.4%) мянга нь эмэгтэйчүүд байгаагийн 15.0 (17.9%) мянга нь өрх толгойлсон, хүүхэдтэй эмэгтэйчүүд байна. Тэдгээр эмэгтэйчүүдийн 12.9 (86.2%) мянга нь 0-4 насны хүүхэдтэй, 2.1 (13.8%) мянга нь 5-9 насны хүүхэдтэй байна. Насны хувьд 8.0 (53.5%) мянга нь 30-44 насныхан байна. Хөдөлмөрийн дутуу ашиглалтын бүлэг дэх өрх толгойлсон эмэгтэйчүүдийн 8.5 (57.0%) мянга нь ажилгүй иргэн, 6.2 (41.2%) мянга нь боломжит ажиллах хүч, 0.3 (1.8%) мянга нь цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгчид байна.

Зураг 4.4. Хөдөлмөрийн дутуу ашиглалтын бүлэг дэх хүүхэдтэй өрх толгойлсон эмэгтэйчүүд, насны бүлэг, хувиар



## АЖИЛГҮЙ ХҮН

Хөдөлмөрийн дутуу ашиглалтын 99.8 (56.3%) мянга нь ажилгүй хүн байгаагийн 55.2 (55.3%) мянга нь эрэгтэйчүүд, 44.6 (44.7%) мянга нь эмэгтэйчүүд байна. Ажилгүй хүний 79.3 (79.5%) мянга нь хот, суурин газарт амьдарч байна.


Ажилгүй хүнийг бүс нутгаар авч үзвэл, 41.1 (41.2%) мянга нь Улаанбаатар хотод, 20.1 (20.2%) мянга нь Хангайн бүсэд, 18.5 (18.5%) мянга нь Төвийн бүсэд, 15.9 (15.9%) мянга нь Баруун бүсэд, 4.2 (4.2%) мянга нь Зүүн бүсэд ногдож байна. Нийт ажилгүй хүний 7.2 хувь нь Сэлэнгэ аймагт байгаа нь хамгийн өндөр, 0.8 хувь нь Төв аймагт байгаа нь хамгийн бага хувийг эзэлж байна.

Нийт ажилгүй хүнийг насны бүлгээр авч үзэхэд 18.2 хувийг 25-29, 15.5 хувийг 20-24 насны залуус эзэлж байна. Уг үзүүлэлт нас ахих тусам буурч, 55-59 насанд 3.3 хувьд хүрсэн байна.

Залуу хүмүүс, ялангуяа ажиллах хүчний эгнээнд шинээр элсэн орж буй хүмүүс ажилгүйдэлд илүүтэй өртөж байгаа нь насны бүлэг дэх ажилгүйчүүдийн тоо болон ажилгүйдлийн түвшин (дараагийн дэд бүлэгт)-ээс харагдаж байна.

Насны бүлэг дэх хүйсийн ялгааг авч үзэхэд 30-34, 65-69 насны бүлэгт эмэгтэйчүүдийн эзлэх хувь тухайн насны эрэгтэйчүүдийнхээс 12.9-81.9 нэгж хувиар илүү, бусад насны бүлэгт эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс 1.6-100.0 нэгж хувиар илүү байна.

Зураг 4.5. Ажилгүй хүн, насны бүлэг, хүйс, дүнд эзлэх хувиар




Ажилгүй арван хүн тутмын гурав нь техникийн болон мэргэжлийн, бараг хоёр нь дипломын дээд болон бакалаврын боловсролтой, мөн дөрвөн хүний нэг нь бүрэн дунд боловсролтой хүн байна. Харин ажилгүй хүний хувьд боловсролгүй болон бага боловсролтой хүний эзлэх хувь нэлээд бага буюу 4.8 хувь байна.

Хүснэгт 4.4. Ажилгүй хүн, боловсролын түвшин, хүйс, дүнд эзлэх хувиар

Боловсролын түвшин	Бүгд	Хүйсээр	
		Эрэгтэй	Эмэгтэй
Боловсролгүй	2.9	2.4	3.6
Бага	1.9	2.5	1.1
Суурь	10.0	12.7	6.6
Бүрэн дунд	19.5	17.7	21.8
Техникийн болон мэргэжлийн	25.0	30.5	18.1
Тусгай мэргэжлийн дунд	6.5	5.5	7.7
Дипломын дээд болон бакалавр	32.5	27.6	38.6
Магистр ба түүнээс дээш	1.7	1.1	2.5
Дүн, %	100.0	100.0	100.0
Улсын дүн	99 778	55 190	44 588

Ажилгүй хүний 24.6 (26.3%) мянга нь урт хугацаагаар буюу 12 сар, түүнээс дээш хугацаагаар хөдөлмөр эрхлээгүй, тухайн хугацаанд ажил хайж байгаа болон ажил хийх боломжтой байсан байна. Урт хугацааны ажилгүйдлийг хүйсээр авч үзэхэд эмэгтэйчүүдийн 33.2 хувь, эрэгтэйчүүдийн 20.3 хувийг эзэлж байна.

Зураг 4.6. Ажилгүй хүн, ажил хайсан, эхлүүлэхийг оролдсон хугацаа, хүйс, дүнд эзлэх хувиар



Ажилгүй хүнийг ажилгүй байгаа шалтгаанаар авч үзвэл 39.6 (39.7%) мянга нь ажил хайгаад олдохгүй байгаа, 15.5 (15.5%) мянга нь үүсээд байгаа цар тахлын улмаас, 8.4 (8.4%) мянга нь мэргэжил, дадлага туршлага байхгүй гэж хариулсан хүмүүс дийлэнх хувийг эзэлж байна.

Зураг 4.7. Ажилгүй хүн, ажилгүй байгаа шалтгаанаар, дүнд эзлэх хувиар



Зураг 4.8. Ажилгүй хүн, ажилгүй байгаа шалтгаанаар, хүйсээр, дүнд эзлэх хувиар



Ажилгүй хүний 76.4 (76.6%) мянга нь өмнө нь ямар нэгэн хөдөлмөр эрхэлж байсан бөгөөд өмнөх ажлаасаа гарсан шалтгаанаар нь авч үзвэл, 17.7 (23.2%) мянга нь өөрийн хүсэлтээр, 12.2 (16.0%) мянга нь түр ажлын байр байсан, 8.8 (11.6%) мянга нь хувийн, гэр бүлийн шалтгаантай, 8.7 (11.4%) мянга нь үүсээд байгаа цар тахлын улмаас гэсэн шалтгаантай хүмүүс хамгийн өндөр хувийг эзэлж байна.


Зураг 4.9. Ажилгүй хүн, өмнөх ажлаасаа гарсан шалтгаан, дүнд эзлэх хувиар



### БОЛОМЖИТ АЖИЛЛАХ ХҮЧ


Улсын хэмжээнд цалин хөлс, орлого олох зорилгоор ажил хайх эсвэл хийх нөхцөл нь бүрдвэл ажил хийхэд бэлэн байгаа хөдөлмөрийн насны хүн ам буюу боломжит ажиллах хүч 71.4 мянга байгаагийн 35.0 (49.0%) мянга нь эрэгтэйчүүд, 36.4 (51.0%) мянга нь эмэгтэйчүүд байна. Боломжит ажиллах хүчний 57.2 (80.1%) мянга нь хот, суурин газарт, 14.2 (19.9%) мянга нь хөдөө орон нутагт амьдарч байна. Боломжит ажиллах хүч бүс нутгаар нэлээд ялгаатай байгааг доорх зурагт харуулав. Нийт боломжит ажиллах хүч Улаанбаатар хотод 42.1 (58.9%) мянга, Баруун бүсэд хамгийн өндөр буюу 15.8 (22.2%) мянга, Хангайн бүсэд хамгийн бага буюу 3.7 (5.2%) мянган хүн байна.

Зураг 4.10. Боломжит ажиллах хүч, бүс, хүйсээр, дүнд эзлэх хувиар




Насны бүлэг, хүйсээр авч үзэхэд нийт боломжит ажиллах хүчний 44.6 хувийг 15-34 насны хүн ам, 51.1 хувийг 35-59 насны хүн ам эзэлж байна. Боломжит ажиллах хүч нас ахих тусам буурч, 60-аас дээш насанд 4.3 хувь болсон байна. Эндээс харахад дунд насныхан илүүтэй ажил хийх нөхцөл нь бүрдвэл ажил хийхэд бэлэн байгаа нь харагдаж байна. Боломжит ажиллах хүчийг хүйсээр авч үзэхэд 15-24 болон 30-34 насны бүлэгт эрэгтэйчүүдийн эзлэх хувь тухайн насны эмэгтэйчүүдийнхээс 0.8-7.0 нэгж хувиар бага байгаа бол 45-69 насны бүлэгт эрэгтэйчүүдийн эзлэх хувь тухайн насны эмэгтэйчүүдийнхээс 0.8-3.0 нэгж хувиар илүү байна.

Зураг 4.11. Боломжит ажиллах хүч, насны бүлэг, хүйс, дүнд эзлэх хувиар



Боломжит ажиллах хүчний 57.7 хувь нь тодорхой хэмжээний ажил мэргэжил эзэмших түвшний боловсролтой байна.

Зураг 4.12. Боломжит ажиллах хүч, боловсролын түвшин, хүйс, дүнд эзлэх хувиар




Боломжит ажиллах хүчний 20.0 (28.0%) мянга нь итгэл алдарсан ажил хайгчид байна. Итгэл алдарсан ажил хайгч гэж ажил хийх боломжтой байгаа ч хөдөлмөрийн зах зээлтэй холбоотой шалтгаанаар ажил хайгаагүй, ажлын байр хайж олох найдвараа алдсан хөдөлмөрийн насны хүн ам юм. Хөдөлмөрийн зах зээлтэй холбоотой гэдэг нь мэргэжил, дадлага туршлага байхгүйгээс тохирох ажлын байранд ажиллаж чадахгүй, хэтэрхий залуу, хөгшин байна гэсэн шалтгаанаар ажил олгогчдын шаардлагад нийцэхгүй байгааг олгоно.

Хүснэгт 4.5. Итгэл алдарсан ажил хайгчид, насны бүлэг, хүйсээр

Насны бүлэг	Бүгд		Эрэгтэй		Эмэгтэй	
	хүн	хувь	хүн	хувь	хүн	хувь
Бүгд	19 965	100.0	9 709	100.0	10 256	100.0
15-24	2 109	10.5	1 025	10.5	1 084	10.5
25-34	4 148	20.8	1 883	19.4	2 265	22.1
35-44	3 676	18.4	1 573	16.2	2 103	20.5
45-54	7 147	35.8	3 394	35.0	3 753	36.6
55-64	2 660	13.3	1 635	16.8	1 025	10.0
65-69	172	0.9	172	1.8	-	-
70+	53	0.3	27	0.3	26	0.3

Боломжит ажиллах хүчний ажилгүй байгаа шалтгааныг авч үзэхэд 13.3 (18.6%) мянга нь ажил хайгаад ч олдохгүй байгаа, 12.9 (18.0%) мянга нь үүсээд байгаа цар тахлын улмаас, 7.9 (11.1%) мянга нь мэргэжил, дадлага, туршлага байхгүй, 7.1 (10.0%) мянга нь жирэмсэн, хүүхэд асарсан гэх шалтгаан хамгийн өндөр хувийг эзэлж байна.

Зураг 4.13. Боломжит ажиллах хүч, ажилгүй байгаа шалтгаанаар, хүйс, дүнд эзлэх хувиар



Нийт боломжит ажиллах хүчний 66.8 (93.5%) мянга нь сүүлийн 30 хоногт цалинтай ажил болон бизнес эрхлэх гэж оролдоогүй хүн байгаа бөгөөд шалтгаанаар авч үзвэл, 16.1 (24.1%) мянга нь үүсээд байгаа цар тахлын улмаас, 11.7 (17.5%) мянга нь гэр бүлийн шалтгаанаар, 9.3 (13.9%) мянга нь ажил хайгаад залхсан, ажлын байр байхгүй гэж бодож байна гэж хариулсан хүмүүс хамгийн өндөр хувийг эзэлж байна.

Хүснэгт 4.6. Боломжит ажиллах хүч, сүүлийн 30 хоногт цалинтай ажил олох болон бизнес эрхлэх гэж оролдоогүй шалтгаан, байршил, дүнд эзлэх хувиар

Шалтгаан	Бүгд		Хот		Хөдөө	
	Тоо	%	Тоо	%	Тоо	%
Бүгд	66 754	100.0	53 062	100.0	13 692	100.0
Өмнөх ажил хайлтын үр дүнг хүлээж байна	1 079	1.6	937	1.8	141	1.0
Өмнөх ажлаас утасдахыг хүлээж байгаа	2 114	3.2	1 950	3.7	164	1.2
Улирлаас шалтгаалаад эхлэхийг нь хүлээж байгаа	2 681	4.0	2 021	3.8	660	4.8
Ажил хайгаад залхсан ажлын байр байхгүй гэж бодож байна	9 304	13.9	7 483	14.1	1 821	13.3
Ур чадварт тохирох ажил байхгүй туршлага байхгүй	4 592	6.9	3 633	6.8	958	7.0
Ажил олгогчдын зүгээс хэтэрхий залуу/хөгшин байна гэж үздэг	6 070	9.1	4 338	8.2	1 732	12.6
Суралцаж байсан, сургалтад хамрагдаж байгаа	5 055	7.6	4 239	8.0	816	6.0
Гэр бүлийн шалтгаанаар	11 661	17.5	8 460	15.9	3 201	23.4
Өрхийн хэрэгцээний ХАА-н болон загас үржүүлгийн ажилд туслахаар	2 179	3.3	83	0.2	2 096	15.3
Өвчтөн хөгжлийн бэрхшээлтэй	3 283	4.9	2 697	5.1	586	4.3
Бусад орлогын эх үүсвэртэй	248	0.4	126	0.2	122	0.9
Үүсээд байгаа цар тахлын улмаас	16 119	24.1	15 440	29.1	679	5.0
Бусад	2 369	3.5	1 655	3.1	716	5.2

Боломжит ажиллах хүчний 53.8 (75.4%) мянга нь өмнө нь хөдөлмөр эрхэлж байсан бөгөөд өмнөх ажлаасаа гарсан шалтгаанаар авч үзвэл, 12.3 (22.8%) мянга нь хувийн, гэр бүлийн шалтгаанаар, 10.0 (18.6%) мянга нь өөрийн хүсэлтээр, 7.4 (13.7%) мянга нь түр ажлын байр байсан, 3.4 (6.4%) мянга нь цомхотголд орсон гэсэн шалтгаан өндөр хувийг эзэлж байна.



Зураг 4.14. Өмнө нь хөдөлмөр эрхэлж байсан боломжит ажиллах хүч, хөдөлмөр эрхлэхээ больсон шалтгаанаар, дүнд эзлэх хувиар




#### ЦАГ ХУГАЦААНААС ХАМААРСАН БҮРЭН БУС ХӨДӨЛМӨР ЭРХЛЭГЧ

Хөдөлмөр эрхэлж буй ажиллагчийн ажлын цаг нь хуульд заасан босго цагаас бага, нэмэлт ажил хийх хүсэлтэй үед цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэлт бий болдог. Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгчид 2020 онд өмнөх оноос 2.9 дахин буурч 5.2 мянгад хүрсэн бол 2021 онд 1.2 дахин нэмэгдэж 6.1 мянгад хүрсэн байна.


Нийт ажиллагчдад эзлэх цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгчдийн хувь 2021 оны байдлаар 0.5 хувьтай байна. Энэ нь хөдөлмөрийн зах зээлд ажиллагчдын нийлүүлэлтийн дутуу ашиглалтыг харуулж байгаа ба ажилгүй хүнээс гадна тэр хэмжээний нөөц хөдөлмөрийн зах зээлд бий болж байгааг харуулж байна.

Зураг 4.15. Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгчид, хүйс, бүс, мянган хүнээр




Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгчид хүйсийн хувьд эрэгтэйчүүд илүү буюу 3.1 (51.6%) мянга байна. Дийлэнх нь буюу 4.4 (72.1%) мянга нь Баруун бүсэд, үүнээс Баян-Өлгий, Завхан аймагт хамгийн өндөр байна.

Зураг 4.16. Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгчид, хүйс, аймаг, дүнд эзлэх хувиар




Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгчдийг насны бүлгээр харахад 20-44 насныхан ихэнх буюу 4.6 (0.4%) мянга байна. Хүйсээр авч үзвэл 35-39 насны бүлэгт эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс 6.3 дахин их байгаа бол 25-29 насны бүлэгт 3.9 дахин бага байна.

Зураг 4.17. Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгчид, насны бүлэг, хүйс, хүнээр




Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгч таван хүн тутмын нэг нь дипломын болон бакалаврын дээд боловсролтой байгаа бол эмэгтэйчүүдийн хувьд гурван хүн тутмын нэг нь техникийн болон мэргэжлийн боловсролтой байна.

Зураг 4.18. Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгчид, боловсролын түвшин, хүйс, дүнд эзлэх хувиар




Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгчдийг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар авч үзэхэд 3.8 (62.3%) мянга нь үйлчилгээний, 1.5 (24.2%) мянга нь хөдөө аж ахуйн, 0.8 (13.5%) мянга нь аж үйлдвэр, барилгын салбарт ажиллаж байна.

Зураг 4.19. Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгчид, эдийн засгийн үйл ажиллагааны үндсэн салбар, хүйс, дүнд эзлэх хувиар




Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгчдийг ажил мэргэжлийн ангиллаар авч үзэхэд 1.9 (30.7%) мянга нь худалдаа, үйлчилгээний ажилтан, 1.3 (22.3%) мянга нь машин механизм, төхөөрөмжийн операторч, угсрагч мэргэжлийн хүмүүс байна.

Зураг 4.20. Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгчид, ажил мэргэжлийн ангилал, дүнд эзлэх хувиар



Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгч арван хүн тутмын долоо нь цалин хөлстэй ажиллагчгүй, зах зээлд чиглэсэн өрхийн аж ахуй эрхлэгч байна.

Зураг 4.21. Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгчид, хөдөлмөр эрхлэлтийн статус, хүйс, дүнд эзлэх хувиар




## 4.2. ХӨДӨЛМӨРИЙН ДУТУУ АШИГЛАЛТЫН ТҮВШИН

Хөдөлмөрийн дутуу ашиглалтыг үнэлэх дөрвөн үзүүлэлтийг 2021 оны байдлаар авч үзэхэд хөдөлмөрийн дутуу ашиглалтын нийлмэл түвшин 13.7 хувь, ажилгүйдлийн түвшин 8.1 хувь байна. Харин ажилгүй хүн болон боломжит ажиллах хүчний нэгдсэн түвшин 13.2 хувь, цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэлт болон ажилгүйдлийн нэгдсэн түвшин 8.6 хувь байна. Аймгаар авч үзэхэд, хөдөлмөрийн дутуу ашиглалтын түвшин Баян-Өлгий, Сэлэнгэ аймагт бусад аймгуудаас өндөр хувийг эзэлж байна.


Ажилгүйдлийн түвшнийг хүйсээр авч үзэхэд, эрэгтэйчүүдийнх 8.5 хувь, эмэгтэйчүүдийнх 7.7 хувь байна. Хот, суурин газрын хүн амын ажилгүйдлийн түвшин 9.5 хувь буюу улсын дунджаас 1.4 нэгж хувиар дээгүүр, харин хөдөө орон нутагт ажилгүйдлийн түвшин 5.3 хувь байгаа нь улсын дунджаас 2.8 нэгж хувиар доогуур байна. Ажилгүйдлийн түвшнийг бүсээр харахад, Төвийн бүсэд 9.9 хувь, Баруун бүсэд 8.7 хувь байгаа нь улсын дунджаас 0.5-1.7 нэгж хувиар дээгүүр байна.

Зураг 4.22. Хөдөлмөрийн дутуу ашиглалтын нийлмэл түвшин болон ажилгүйдлийн түвшин, аймаг, нийслэлээр




Хөдөлмөрийн дутуу ашиглалтын үзүүлэлтүүдийг 15-24 насны (боловсрол, сургалтын дараах хөдөлмөрийн зах зээлд шинээр орж байгаа залуучууд), 25-54 насны (ерөнхий ажиллах хүчний насныхан) болон 55-64 насны (тэтгэвэрт гарахад ойрхон байгаа), 65 ба түүнээс дээш насны бүлгээр харуулав (Зураг 4.23).

Зураг 4.23. Хөдөлмөрийн дутуу ашиглалтын түвшин, насны бүлэг, хувиар



Ажилгүйдлийн түвшнийг насны бүлгээр авч үзэхэд 15-19 (21.8%), 20-24 (18.5%) насны залуучуудын ажилгүйдлийн түвшин хамгийн өндөр, улсын дунджаас 10.4-13.7 нэгж хувиар дээгүүр байна.

Зураг 4.24. Ажилгүй хүн болон боломжит ажиллах хүчний нэгдсэн түвшин, ажилгүйдлийн түвшин, насны бүлэг, хүйсээр





## V. АЛБАН БУС ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ



ХАА-н бус  
салбарт  
ажиллагчдын  
178.1 мянга  
21.4%

Нийт  
ажиллагчдын  
464.0 мянга  
41.2%

## 5.1. АЛБАН БУС ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

Хөгжиж буй орнуудад хөдөө аж ахуйн салбар дахь албан бус хөдөлмөр эрхлэлтийг тодорхойлоход бэрхшээлтэй байдаг тул албан бус салбарт зөвхөн хөдөө аж ахуйн /ХАА-н/ бус чиглэлийн үйл ажиллагааг хамруулан тооцож байна. Иймд ОУХБ-аас улс орнуудын харьцуулагдах байдлыг хангах үүднээс эдгээр улс орнуудын хувьд “ХАА-н салбарыг оруулсан дүнгээрх албан бус хөдөлмөр эрхлэлтийг хамт зарлах”-ыг зөвлөмж болгосон. Манай улсын хувьд дээрх зөвлөмжийг мөрдлөг болгож байгаа бөгөөд энэхүү бүлэгт албан бус хөдөлмөр эрхлэлтийн хэмжээ, бүтцийг илэрхийлсэн статистикийн мэдээллийг улсын болон аймгийн түвшинд харуулав.

Улсын хэмжээнд нийт ажиллагчдын 291.7 (25.9%) мянга нь ХАА-н салбарт ажиллаж, тэдгээрийн 285.9 (98.0%) мянга нь албан бус хөдөлмөр эрхэлж байна. Хөдөлмөр эрхлэлтийн статусын хувьд цалин хөлстэй ажиллагчгүй, зах зээлд чиглэсэн өрхийн аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчид хамгийн өндөр буюу 250.0 (87.4%) мянга байна.

## Хүснэгт 5.1. Хөдөлмөр эрхлэгчид, статусаар, үйл ажиллагааны нэгжээр

Хөдөлмөр эрхлэлтийн статус	Бүгд	ХАА-н салбар					
		Албан бус хөдөлмөр эрхлэгчид			Албан хөдөлмөр эрхлэгчид		
		албан бус	албан	өрхийн нэгж	албан бус	албан	өрхийн нэгж
Нийт ажиллагч	1125.6	283.2	0.8	2.0	-	5.7	-
Аж ахуйн нэгж, байгууллагын ажил олгогч	21.1	-	-	-	-	1.7	-
Зах зээлд чиглэсэн өрхийн аж ахуйн нэгжийн ажил олгогч	20.7	6.9	-	-	-	0.4	-
Цалин хөлстэй ажиллагчгүй аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаа эрхлэгч	10.5	-	-	-	-	0.2	-
Цалин хөлстэй ажиллагчгүй, зах зээлд чиглэсэн өрхийн аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгч	381.2	248.2	-	1.7	-	0.9	-
Гүйцэтгэх гэрээлэгч	3.0	1.2	-	-	-	0.0	-
Цалин хөлстэй байнгын ажиллагч	362.5	3.3	0.3	-	-	1.3	-
Цалин хөлстэй түр ажиллагч	267.9	2.1	0.4	-	-	1.2	-
Цалин хөлстэй тохиолдлын ажиллагч	32.0	1.6	-	0.2	-	-	-
Цалин хөлстэй дагалдан ажилтан, мэргэшиж буй дадлагажигч ажилтан	4.7	-	-	-	-	-	-
Хувь нэмрээ оруулагч гэр бүлийн гишүүн	16.9	15.0	0.1	-	-	-	-
Эдгээр статуст хамрагдаагүй ажиллагчид	5.1	4.8	-	-	-	-	-



Хүснэгт 5.2. Хөдөлмөр эрхлэгчид, статуссаар, үйл ажиллагааны нэгжээр, үргэлжлэл

Хөдөлмөр эрхлэлтийн статус	Бүгд	ХАА-н бус салбар					
		Албан бус хөдөлмөр эрхлэгчид			Албан хөдөлмөр эрхлэгчид		
		албан бус	албан	өрхийн нэгж	албан бус	албан	өрхийн нэгж
Нийт ажиллагч	1125.6	116.6	60.0	1.5	-	655.6	0.2
Аж ахуйн нэгж, байгууллагын ажил олгогч	21.1	-	-	-	-	19.4	-
Зах зээлд чиглэсэн өрхийн аж ахуйн нэгжийн ажил олгогч	20.7	6.4	-	-	-	7.0	-
Цалин хөлстэй ажиллагчгүй аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаа эрхлэгч	10.5	-	-	-	-	10.3	-
Цалин хөлстэй ажиллагчгүй, зах зээлд чиглэсэн өрхийн аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгч	381.2	89.9	-	0.1	-	40.3	-
Гүйцэтгэх гэрээлэгч	3.0	1.2	-	-	-	0.6	-
Цалин хөлстэй байнгын ажиллагч	362.5	3.9	14.4	-	-	339.3	-
Цалин хөлстэй түр ажиллагч	267.9	5.9	29.5	0.2	-	228.5	0.2
Цалин хөлстэй тохиолдлын ажиллагч	32.0	8.6	14.3	1.2	-	6.0	-
Цалин хөлстэй дагалдан ажилтан, мэргэшиж буй дадлагажигч ажилтан	4.7	-	0.4	-	-	4.3	-
Хувь нэмрээ оруулагч гэр бүлийн гишүүн	16.9	0.6	1.2	-	-	-	-
Эдгээр статуст хамрагдаагүй ажиллагчид	5.1	-	0.2	-	-	-	-

Нийт ажиллагчдын 833.9 (74.1%) мянга нь ХАА-н бус салбарт ажиллаж, тэдгээрийн 178.1 (21.4%) мянга нь албан бус хөдөлмөр эрхэлж байна. Харин ХАА-н салбарын ажиллагчдыг оруулсан дүнгээр буюу нийт 1125.6 мянган ажиллагчдын 464.0 (41.2%) мянга нь албан бус хөдөлмөр эрхэлж байна. Өөрөөр хэлбэл, нийт ажиллагчдад албан бус хөдөлмөр эрхлэгчдийн эзлэх хувь ХАА-н бус салбарт 21.4 хувь, ХАА-н салбарыг оруулсан дүнгээр 41.2 хувь байна.

Хүснэгт 5.2. Албан бус хөдөлмөр эрхлэгчид, үйл ажиллагааны нэгжээр, хүйсээр


Үзүүлэлт	Бүгд		Эрэгтэй		Эмэгтэй	
	Тоо	%	Тоо	%	Тоо	%
НИЙТ АЖИЛЛАГЧ	1 125 591	-	592 805	-	532 786	-
Албан бус хөдөлмөр эрхлэгч, ХАА-н салбарыг оруулсан	464 010	41.2	274 851	46.4	189 159	35.5
Албан салбарт	60 759	13.1	33 339	12.1	27 420	14.5
Албан бус салбарт	399 781	86.2	239 297	87.1	160 484	84.8
Өрхийн нэгжид	3 470	0.7	2 215	0.8	1 255	0.7
Хөдөө аж ахуйн бус салбарт Ажиллагч	833 915	74.1	427 736	72.2	406 179	76.2
Албан бус хөдөлмөр эрхлэгч, ХАА-н салбарыг оруулаагүй	178 072	21.4	114 241	26.7	63 831	15.7
Албан салбарт	59 950	33.7	32 818	28.7	27 132	42.5
Албан бус салбарт	116 627	65.5	80 431	70.4	36 196	56.7
Өрхийн нэгжид	1 495	0.8	992	0.9	503	0.8

Улсын хэмжээнд ХАА-н бус салбарт албан бус хөдөлмөр эрхлэгчдийн 114.2 (64.2%) мянга нь эрэгтэйчүүд, 63.8 (35.8%) мянга нь эмэгтэйчүүд байна. ХАА-н бус салбарт ажиллагчдад

албан бус хөдөлмөр эрхлэгчдийн эзлэх хувийн жинг хүйсээр авч үзэхэд, эрэгтэйчүүдийнх 26.7 хувь, эмэгтэйчүүдийнх 15.7 хувь байгаа нь эрэгтэйчүүдэд эмэгтэйчүүдээс илүү албан бус хөдөлмөр эрхэлж байгааг харуулж байна. Гэсэн хэдий ч эмэгтэйчүүд албан бус эдийн засагт эмзэг буюу далд хэлбэрээр оролцож өрх гэрийн ажлаа хийх, гэрийн үйлчлэгч эсвэл гэр бүлийн ажилд цалин хөлсгүйгээр хувь нэмэр оруулах нь эрэгтэйчүүдээс илүү их байдаг. Түүнчлэн, хөдөлмөрийн зах зээл дэх эмэгтэйчүүдийн оролцоо бага байх тусам нийт эмэгтэй ажиллагчдын албан бус хөдөлмөр эрхлэлтийн эзлэх хувь бага байна.


ХАА-н бус салбарт албан бус хөдөлмөр эрхлэгчдийн 158.6 (89.1%) мянга нь хот, суурин газарт, 19.4 (10.9%) мянга нь хөдөө орон нутагт амьдарч байна. Харин ХАА-н салбарын ажиллагчдыг оруулсан дүнгээр буюу нийт ажиллагчдын хувьд, албан бус хөдөлмөр эрхлэгчдийн 190.8 (41.1%) мянга нь хот, суурин газарт, 273.1 (58.9%) мянга нь хөдөө орон нутагт амьдарч байна. Энэ нь манай орны онцлог болох өрхийн аж ахуйд суурилсан нүүдлийн мал аж ахуй эрхэлдэгтэй холбоотой.

Зураг 5.1. Албан бус хөдөлмөр эрхлэгчид, хүйс, байршлаар




ХАА-н бус салбарт ажиллагчдад албан бус хөдөлмөр эрхлэгчдийн эзлэх хувь хот, суурин газарт 22.0 хувь байгаа нь хөдөө орон нутгийнхаас 4.5 нэгж хувиар их байна.

Зураг 5.2. Ажиллагчдад албан бус хөдөлмөр эрхлэгчдийн эзлэх хувь, хүйс, байршлаар



Харин аймгаар авч үзэхэд Ховд аймагт ХАА-н бус салбарт ажиллагч таван хүн тутмын хоёр нь, Баян-Өлгий, Өвөрхангай аймагт арван хүн тутмын гурав нь албан бус хөдөлмөр эрхэлж байна.


Зураг 5.3. ХАА-н бус салбарт ажиллагчдад албан бус хөдөлмөр эрхлэгчдийн эзлэх хувь, аймгаар



### НАСНЫ БҮЛЭГ


Албан бус хөдөлмөр эрхлэгч (ХАА-н салбарыг оруулсан, оруулаагүй адилхан) таван хүн тутмын дөрөв нь 25-54 насны хүн ам (ерөнхий ажиллах хүч) байна.

Зураг 5.4. Албан бус хөдөлмөр эрхлэгчид, насны бүлгээр, мянган хүнээр



ХАА-н бус салбарт ажиллагч 15-19 насны хоёр ажиллагч тутмын нэг нь, 60-64 насны арван ажиллагч тутмын гурав нь албан бус хөдөлмөр эрхэлж байна. Мөн 20-54 насны 5 ажиллагч тутмын нэг нь албан бус хөдөлмөр эрхэлж байна. Эндээс харахад улсын хэмжээнд ахмад настан (55-аас дээш нас) болон залуучууд (15-19 нас)-ын албан бус хөдөлмөр эрхлэлтийн түвшин өндөр байна.

Зураг 5.5. Ажиллагчдад албан бус хөдөлмөр эрхлэгчдийн эзлэх хувь, насны бүлгээр



### БОЛОВСРОЛЫН ТҮВШИН

Хөдөө аж ахуйн бус салбарт албан бус хөдөлмөр эрхлэгчдийн 64.3 (36.1%) мянга нь техникийн болон мэргэжлийн, 40.7 (22.9%) мянга нь дипломын болон бакалаврын дээд, 38.4 (21.5%) мянга нь бүрэн дунд боловсролтой байна.

Хүснэгт 5.3. Албан бус хөдөлмөр эрхлэлт, боловсролын түвшнээр, хувиар

Боловсролын түвшин	Албан бус хөдөлмөр эрхлэгчид, ХАА-н салбар орсон		Албан бус хөдөлмөр эрхлэгчид, ХАА-н бус салбарт	
	Дүнд эзлэх хувийн жин	Нийт ажиллагчдад эзлэх хувь	Дүнд эзлэх хувийн жин	Нийт ажиллагчдад эзлэх хувь
БҮГД	100.0	41.2	100.0	21.4
Боловсролгүй	8.3	92.0	2.8	61.4
Бага	10.7	95.3	1.9	61.1
Суурь	22.5	82.3	8.6	41.0
Бүрэн дунд	20.8	55.9	21.5	33.9
Техникийн болон мэргэжлийн	22.2	39.3	36.1	28.9
Тусгай мэргэжлийн дунд	4.2	30.6	5.9	19.5
Дипломын болон бакалаврын дээд	11.2	14.0	22.9	11.3
Магистр	0.1	2.1	0.3	1.8

Ажиллагчдын боловсролын түвшин буурах тусам албан бус хөдөлмөр эрхлэлт өссөн нь нийт ажиллагчдад албан бус хөдөлмөр эрхлэгчдийн эзлэх хувийн жингийн өсөлтөөс харагдаж байна.

### ГЭРЛЭЛТИЙН БАЙДАЛ

ХАА-н бус салбарт албан бус хөдөлмөр эрхлэгчдийг гэрлэлтийн байдлаар авч үзэхэд 72.7 хувь нь гэрлэсэн, 16.2 хувь нь огт гэрлээгүй байна.


#### Хүснэгт 5.4. Албан бус хөдөлмөр эрхлэлт, гэрлэлтийн байдлаар, хувиар

Гэрлэлтийн байдал	Албан бус хөдөлмөр эрхлэгчид, ХАА-н салбар орсон		Албан бус хөдөлмөр эрхлэгчид, ХАА-н бус салбарт	
	Дүнд эзлэх хувийн жин	Нийт ажиллагчдад эзлэх хувь	Дүнд эзлэх хувийн жин	Нийт ажиллагчдад эзлэх хувь
БҮГД	100.0	41.2	100.0	21.4
Огт гэрлээгүй	15.8	42.3	16.2	22.6
Гэрлэсэн- Батлуулсан	68.2	42.2	61.5	20.3
Гэрлэсэн- Батлуулаагүй	7.8	35.5	11.2	23.4
Тусгаарласан	2.0	32.4	3.8	25.5
Цуцалсан	1.8	34.5	2.7	22.9
Бэлэвсэн	4.4	42.7	4.6	23.2

#### ҮЙЛДЛИЙН ЧАДАМЖ


ХАА-н бус салбарт албан бус хөдөлмөр эрхэлж буй ажиллагчдын 2.2 (1.2%) мянга нь үйлдлийн чадамжийн бэрхшээлтэй иргэд байна. Тэдгээрийн 2.1 (94.0%) мянга нь эрэгтэйчүүд, 0.1 (6.0%) мянга нь эмэгтэйчүүд байна.

Зураг 5.6. Үйлдлийн чадамжийн бэрхшээлтэй иргэдийн албан бус хөдөлмөр эрхлэлт, хүйсээр, дүнд эзлэх хувиар



ХАА-н бус салбарт ажиллаж буй үйлдлийн чадамжийн бэрхшээлтэй 5.5 мянган иргэдийн 2.2 (39.2%) мянга нь албан бус хөдөлмөр эрхэлж байна. Уг үзүүлэлтийг хүйсээр авч үзвэл эрэгтэйчүүдийнх 53.2 хувь, эмэгтэйчүүдийнх 7.6 хувь байна.


Зураг 5.7. Үйлдлийн чадамжийн бэрхшээлтэй ажиллагчдад албан бус хөдөлмөр эрхлэгчдийн эзлэх хувь



#### ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨНИЙ БАЙДАЛ

ХАА-н бус салбарт албан бус хөдөлмөр эрхэлж байгаа ажиллагчдын 23.1 (13.0%) мянга нь сүүлийн 5 жилд, 5.8 (3.3%) мянга нь сүүлийн 1 жилд дотоод шилжих хөдөлгөөнд орсон байна. Сүүлийн 5 жилийн хугацаанд шилжих хөдөлгөөнд орсон ажиллагчдын 63.9 хувь нь эрэгтэйчүүд, 36.1 хувь нь эмэгтэйчүүд байгаа бол сүүлийн 1 жилийн хугацаанд оролцогчдын 58.1 хувь нь эрэгтэйчүүд, 41.9 хувь нь эмэгтэйчүүд байна.


Зураг 5.8. Дотоод шилжих хөдөлгөөнд оролцсон ажиллагчдад албан бус хөдөлмөр эрхлэгчдийн эзлэх хувь



### ӨРХ ТОЛГОЙЛСОН 0-14 НАСНЫ ХҮҮХЭДТЭЙ ЭМЭГТЭЙЧҮҮД

ХАА-н бус салбарт албан бус хөдөлмөр эрхэлж байгаа ажиллагчдын 6.6 (3.7%) мянга нь өрх толгойлсон 0-14 насны хүүхэдтэй эмэгтэйчүүд байна. Тэдгээрийн 3.0 (45.7%) мянга нь хоёр хүүхэдтэй, 1.7 (26.%) мянга нь гурван хүүхэдтэй, 1.6 (24.4%) мянга нь нэг хүүхэдтэй, 0.2 (3.4%) мянга нь дөрвөн хүүхэдтэй байна.

Зураг 5.9. Өрх толгойлсон 0-14 насны хүүхэдтэй эмэгтэйчүүдийн албан бус хөдөлмөр эрхлэлт, гэрлэлтийн байдал, хүүхдийн тоогоор



## 5.2. АЛБАН БУС ХӨДӨЛМӨР ЭРХЛЭГЧДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ

### ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БУЙ НЭГЖ

Эдийн засгийн үйл ажиллагаа явуулж буй нэгжийн хувьд албан бус сектор, өрхийн нэгжид төдийгүй албан секторт ч албан бус хөдөлмөр эрхлэлт байсаар байна. ХАА-н бус салбарт албан бус хөдөлмөр эрхлэгчдийн 65.5 хувь нь албан бус нэгжид, 33.7 хувь нь албан нэгжид, 0.8 хувь нь эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж буй өрхийн нэгжид ажиллаж байна.


Хүснэгт 5.5. Албан бус хөдөлмөр эрхлэгчид, үйл ажиллагааны нэгж, хүйс, байршлаар

Үйл ажиллагааны нэгж	Нийт			Хот			Хөдөө		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Албан бус хөдөлмөр эрхлэгчид, ХАА-н салбар орсон									
БҮГД	464.0	274.9	189.1	190.9	122.5	68.4	273.1	152.4	120.7
Албан салбарт	60.7	33.3	27.4	55.7	30.7	25.0	5.0	2.6	2.4
Албан бус салбарт	399.8	239.3	160.5	132.9	90.2	42.7	266.9	149.1	117.8
Өрхийн нэгжид	3.4	2.2	1.2	2.2	1.5	0.7	1.2	0.7	0.5
Албан бус хөдөлмөр эрхлэгчид, ХАА-н бус салбарт									
БҮГД	178.1	114.2	63.8	158.6	102.9	55.7	19.4	11.3	8.1
Албан салбарт	60.0	32.8	27.1	55.5	30.5	24.9	4.5	2.3	2.2
Албан бус салбарт	116.6	80.4	36.2	101.8	71.5	30.3	14.8	8.9	5.9
Өрхийн нэгжид	1.5	0.9	0.5	1.4	0.9	0.5	0.1	0.1	-

## ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН СТАТУСААР


Улсын хэмжээнд ХАА-н бус салбарт албан бус хөдөлмөр эрхлэгчдийн 50.5 хувь нь цалин хөлстэй ажиллагчгүй зах зээлд чиглэсэн өрхийн аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгч, 44.0 хувь нь цалин хөлстэй ажиллагчид байна.

Зураг 5.10. Албан бус хөдөлмөр эрхлэгчид, хөдөлмөр эрхлэлтийн статус, дүнд эзлэх хувиар



ХАА-н бус салбарт ажиллаж буй гэр бүлийн гишүүдэд хувь нэмрээ оруулагчид нь бүгд албан бус хөдөлмөр эрхлэгчид байна. Харин гүйцэтгэх гэрээлэгч, цалин хөлстэй ажиллагчгүй, зах зээлд чиглэсэн өрхийн аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчдийн болон цалин хөлстэй тохиолдлын ажиллагчдын 67.6-80.2 хувь нь албан бус хөдөлмөр эрхэлж байна.

Зураг 5.11. Ажиллагчдад албан бус хөдөлмөр эрхлэгчийн эзлэх хувь, хөдөлмөр эрхлэлтийн статусаар



### ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САЛБАРААР

ХАА-н бус салбарт албан бус хөдөлмөр эрхлэгчдийг эдийн засгийн үйл ажиллагааны үндсэн салбараар авч үзэхэд үйлчилгээний салбарт 61.1 хувь, аж үйлдвэр, барилгын салбарт 38.9 хувь нь ажиллаж байна. Тухайлбал, 46.0 (25.8%) мянга нь бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар, үйлчилгээний, 35.0 (19.6%) мянга нь барилгын, 30.0 (16.9%) мянга нь боловсруулах үйлдвэрлэлийн, 27.0 (15.2%) мянга нь тээвэр ба агуулахын үйл ажиллагааны салбарт ажиллаж байна.

Зураг 5.12. Албан бус хөдөлмөр эрхлэгчид, эдийн засгийн үйл ажиллагааны салбар, дүнд эзлэх хувиар



Үйлчилгээний бусад үйл ажиллагааны болон тээвэр ба агуулахын үйл ажиллагааны салбарт ажиллагч хоёр ажиллагч тутмын нэг, барилга болон боловсруулах үйлдвэрлэлийн салбарт ажиллагч таван ажиллагч тутмын хоёр, бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар, үйлчилгээний мөн зочид буудал, байр сууц болон нийтийн хоолны үйлчилгээний салбарт ажиллагч арван ажиллагч тутмын гурав нь албан бус хөдөлмөр эрхэлж байна.



Зураг 5.13. Ажиллагчдад албан бус хөдөлмөр эрхлэгчийн эзлэх хувь, салбараар



### АЖИЛ МЭРГЭЖЛЭЭР

ХАА-н бус салбарт албан бус хөдөлмөр эрхлэгчдийн 60.5 (34.0%) мянга нь үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан, 51.5 (28.9%) мянга нь худалдаа, үйлчилгээний ажил эрхэлсэн нь дийлэнх хувийг эзэлж байна. Хүйсээр авч үзвэл үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажил эрхлэгчдийн 45.6 (40.0%) мянга нь эрэгтэйчүүд, харин худалдаа, үйлчилгээний ажил эрхлэгчдийн 36.0 (56.5%) мянга нь эмэгтэйчүүд байгаа нь дийлэнх хувийг эзэлж байна.

Харин суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч мэргэжлээр 31.1 (17.5%) мянга нь ажилласан бөгөөд албан бус хөдөлмөр эрхэлж байгаа эрэгтэйчүүдийн 30.4 (26.6%) мянга нь энэ ажил мэргэжлээр ажилласан байна.

Хүснэгт 5.6. Албан бус хөдөлмөр эрхлэлт, ажил мэргэжлийн ангиллаар

Ажил мэргэжил	Албан бус хөдөлмөр эрхлэгчид, ХАА-н салбар орсон		Албан бус хөдөлмөр эрхлэгчид, ХАА-н бус салбарт	
	Дүнд эзлэх хувийн жин	Нийт ажиллагчдад эзлэх хувь	Дүнд эзлэх хувийн жин	Нийт ажиллагчдад эзлэх хувь
БҮГД	100.0	41.2	100.0	21.4
Менежер	0.6	3.6	1.6	3.7
Мэргэжилтэн	0.8	2.0	2.2	2.0
Техникч болон туслах, дэд мэргэжилтэн	0.7	9.2	1.7	8.7
Контор, үйлчилгээний ажилтан	0.3	3.6	0.8	3.6
Худалдаа, үйлчилгээний ажилтан	11.1	29.7	28.9	29.6
Хөдөө аж ахуй, ой, загас агнуурын ажилтан	61.4	99.1	0.4	62.9
Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажил	13.2	49.0	33.9	49.0
Суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч	6.8	31.7	17.5	31.6
Энгийн ажил, мэргэжил	5.1	28.2	13.0	27.7

Дараах зургаар ХАА-н бус салбарт албан бус хөдөлмөр эрхэлж байгаа ажиллагчдыг эрхэлж буй ажил мэргэжил болон хүйсээр харвал хандлага ХАА-н салбарыг оруулсан дүнгээрх албан бус хөдөлмөр эрхлэгчдийн хувьд хадгалагдаж байна.

Зураг 5.14. ХАА-н бус салбарт албан бус хөдөлмөр эрхлэгчид, ажил мэргэжил, хүйсээр, дүнд эзлэх хувь



АЖЛЫН ЦАГ

ХАА-н бус салбарт албан бус хөдөлмөр эрхэлж буй ажиллагчдын долоо хоногийн тогтмол ажилладаг цагийн дундаж нь 50 цаг, жинхэнэ ажилласан цагийн дундаж 45 цаг байна. Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн 14.6 хувь нь тогтмол ажлын цагаас нь бага цагаар (жинхэнэ ажилласан цаг нь), 0.7 хувь нь их цагаар ажилласан байна. ХАА-н бус салбарт албан бус

хөдөлмөр эрхэлж буй ажиллагчдын 86.7 (48.7%) мянга нь 7 хоногт тогтмол 48 цагаас дээш цагаар ажиллаж байна.

**Хүснэгт 5.7. Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн ажлын цаг, үндсэн ажлаар, тогтмол болон жинхэнэ ажилласан цагаар, дүнд эзлэх хувиар**

Ажлын цаг	Албан бус хөдөлмөр эрхлэгчид, ХАА-н салбар орсон		Албан бус хөдөлмөр эрхлэгчид, ХАА-н бус салбарт	
	Тогтмол	Жинхэнэ	Тогтмол ажлын	Жинхэнэ
	ажлын цаг	ажилласан цаг	цаг	ажилласан цаг
НИЙТ	100.0	100.0	100.0	100.0
0	-	4.0	-	9.3
1-14	0.7	1.2	0.9	1.8
15-29	2.7	3.5	2.8	3.8
30-34	1.1	1.3	1.9	2.3
35-39	4.2	4.2	3.4	3.3
40-48	30.0	27.7	42.3	37.6
48-аас дээш цаг	61.3	58.1	48.7	41.9

**ЦАЛИН, ОРЛОГО**

ХАА-н бус салбарт албан бус хөдөлмөр эрхэлж буй ажиллагчдын 43.2 хувь нь цалин хөлстэй үйл ажиллагаа эрхэлсэн бол 48.6 хувь нь хувиараа хөдөлмөр эрхлэгчид байна. Судалгаагаар албан болон албан бус салбарт, өрхийн нэгжид ажиллаж байгаа бүх цалин хөлстэй ажиллагчдын цалингийн мэдээллийг гарт олгогдсон дүнгээр авсан болно. ХАА-н бус салбарт цалин хөлстэй ажиллаж буй албан бус хөдөлмөр эрхлэгчдийн сарын дундаж цалин улсын хэмжээнд 728.1 мянган төгрөг, тэдгээрийн 59.4 хувь нь улсын дунджаас доогуур цалин хөлстэй байна. Харин ХАА-н бус салбарт хувиараа хөдөлмөр эрхэлж буй албан бус хөдөлмөр эрхлэгчдийн сарын дундаж орлого улсын хэмжээнд 853.3 мянган төгрөг, тэдгээрийн 57.9 хувь нь улсын дунджаас доогуур орлоготой байна.

ХАА-н бус салбарт албан бус хөдөлмөр эрхэлж буй цалин хөлстэй ажиллагчдын ихэнх нь 501.0-700.9 (28.2%) мянган төгрөгийн цалинтай байна. Харин ХАА-н бус салбарт хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн сарын орлогын эзлэх хувь 301.0-500.9 (22.4%) мянган төгрөг байна.

**Хүснэгт 5.8. Албан бус хөдөлмөр эрхлэгчид, сарын цалин, орлого бүлгээр, дүнд эзлэх хувиар**

Цалин, орлогын бүлэг	Албан бус хөдөлмөр эрхлэгчид, ХАА-н салбар орсон		Албан бус хөдөлмөр эрхлэгчид, ХАА-н бус салбарт	
	Цалин хөлстэй ажиллагчид	Хувиараа хөдөлмөр эрхлэгчид	Цалин хөлстэй ажиллагчид	Хувиараа хөдөлмөр эрхлэгчид
	НИЙТ	100.0	100.0	100.0
300.9 хүртэл	9.6	36.0	6.5	10.4
301.0-500.9	26.4	19.7	24.5	22.4
501.0-700.9	26.1	13.0	28.2	16.1
701.0-900.9	18.4	9.4	20.0	11.0
901.0-1100.9	6.7	9.3	7.0	17.9
1101.0-1600.9	10.3	6.8	11.2	13.6
1601.0-2100.9	1.6	2.8	1.7	5.0
2101.0-3000.9	0.4	1.6	0.4	2.4
3001 болон түүнээс дээш	0.5	1.4	0.5	1.2


ХАА-н бус салбарт цалин хөлстэй албан бус хөдөлмөр эрхлэгчдийн сарын дундаж цалинг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар авч үзэхэд хамгийн өндөр буюу уул уурхай, олборлолтын салбарт 1.3 сая төгрөг байна. Хувиараа хөдөлмөр эрхэлж буй албан бус хөдөлмөр эрхлэгчдийн сарын дундаж орлогын хувьд авч үзэхэд санхүүгийн болон даатгалын үйл ажиллагааны салбарт 1.5 сая төгрөг, удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны салбарт 1.1 сая төгрөг байна.

**Хүснэгт 5.9. Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн сарын дундаж цалин, орлого, салбараар, мянган төгрөг**

Эдийн засгийн салбар	Хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн сарын дундаж орлого	Цалин хөлстэй ажиллагчдын сарын дундаж цалин
УЛСЫН ДУНДАЖ	853.3	728.7
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	348.4	419.9
Уул уурхай, олборлолт	717.5	1279.7
Боловсруулах үйлдвэрлэл	802.0	609.0
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	700.0	592.0
Усан хангамж; бохир ус зайлуулах систем, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	594.0	550.0
Барилга	987.5	956.0
Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ	821.7	629.6
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	918.9	1057.0
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	546.1	582.1
Мэдээлэл, холбоо	1020.6	761.1
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	1525.6	617.6
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	-	700.0
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	1027.8	877.2
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	1147.2	507.0
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	-	227.7
Боловсрол	200.0	559.8
Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	828.7	554.5
Урлаг, үзвэр, тоглоом наадам	1000.0	646.2
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	762.3	529.7
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа	-	561.6

## VI. ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛ ДЭХ ЗАЛУУЧУУДЫН ОРОЛЦОО

Залуу ажиллагчид, ажил мэргэжлийн ангилал, дүнд эзлэх хувиар



### 6.1. ЗАЛУУЧУУДЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ

Олон улсын хөдөлмөрийн байгууллагаас “залуучууд” гэдэг нэр томъёонд 15-24 насны хүмүүсийг, “ерөнхий хөдөлмөрийн насанд хүрэгсэд” гэдэгт 25 ба түүнээс дээш насны хүн амыг хамруулдаг.

Зураг 6.1. 15-24 насны залуучуудын хөдөлмөрийн зах зээл дэх оролцоо



Судалгааны дүнгээр хөдөлмөрийн насны хүн амын 388.0 (18.0%) мянга нь 15-24 насны залуучууд байгаагийн 191.7 (49.4%) мянга нь эрэгтэй, 196.4 (50.6%) мянга нь эмэгтэйчүүд байна. Эдгээр залуучуудын 104.5 (26.9%) мянга нь ажиллах хүч, 283.7 (73.1%) мянга нь ажиллах хүчнээс гадуурх хүн ам байна. Ажиллах хүчний 84.4 (80.8%) мянга нь ажиллагчид, 20.0 (19.2%) мянга нь ажилгүй хүн байна.


Хүснэгт 6.1. Залуу ажиллагчид, байршил, бүс, хүйсээр

Байршил / Бүс	Дүн		Хүйсээр			
	Тоо	%	Эрэгтэй		Эмэгтэй	
			Тоо	%	Тоо	%
Хот	50 298	59.6	30 522	57.4	19 776	63.4
Хөдөө	34 061	40.4	22 658	42.6	11 403	36.6
Баруун бүс	14 974	17.8	9 594	18.0	5 380	17.3
Хангайн бүс	15 705	18.6	10 167	19.1	5 538	17.8
Төвийн бүс	12 721	15.1	8 696	16.4	4 025	12.9
Зүүн бүс	6 703	7.9	3 636	6.8	3 067	9.8
Улаанбаатар	34 255	40.6	21 086	39.7	13 169	42.2
Дүн, %		100.0		100.0		100.0
Улсын дүн	84 359		53 180		31 179	

Нийт ажиллагчдын 84.4 (7.5%) мянга нь 15-24 насны залуучууд байна. Үүнээс хүйсийн хувьд 63.0 хувь нь эрэгтэйчүүд, 37.0 хувь нь эмэгтэйчүүд байна. Харин залуу ажиллагчдын 59.6 хувь нь хотод, 40.4 хувь нь хөдөөд амьдарч байна. Бүсийн хувьд Улаанбаатар хотыг оруулахгүйгээр Хангайн, Баруун болон Төвийн бүсэд залуучуудын хөдөлмөр эрхлэлт өндөр, Зүүн бүсэд харьцангуй бага буюу (7.9%) байна. Улаанбаатар хотыг оруулахгүйгээр


аймгуудын хувьд харьцуулахад (15.1%-18.6%) залуучуудын хөдөлмөр эрхлэлт өндөр болон бага байгаа байдлыг бүсийн ялгаатай байдлаар Зураг 6.2-т харуулав.

Зураг 6.2. Залуу ажиллагчид, бүс, аймаг, хүйсээр



Залуучуудын хөдөлмөр эрхлэлт өндөр байгаа бүсүүдийг аймгаар задлан харахад Хангайн бүсээс Өвөрхангай, Баруун бүсээс Увс, Баян-Өлгий, Ховд, Төвийн бүсээс Төв, Зүүн бүсээс Хэнтий аймгуудад залуучуудын хөдөлмөр эрхлэлт тухайн бүсийнхээ бусад аймгуудаас өндөр байна.

Зураг 6.3. Залуу ажиллагчид, аймгаар, нийт ажиллагчдад эзлэх хувиар



Улсын хэмжээнд нийт ажиллагчдын 7.5 хувийг 15-24 насныхан эзэлж байна. Аймгийн түвшинд авч үзэхэд Говьсүмбэр, Хэнтий, Дорноговь, Өмнөговь, Өвөрхангай аймгуудад 0.3-1.4 нэгж хувиар, Баянхонгор, Говь-Алтай, Увс аймагт 2.2 нэгж хувиар, Дундговь аймагт 2.7 нэгж хувиар, Баян-Өлгий аймагт 4.1 нэгж хувиар тус тус улсын дунджаас дээгүүр байна.

## БОЛОВСРОЛЫН ТҮВШНЭЭР

Залуу ажиллагчдын хувьд арван хүн тутмын гурав нь дипломын болон бакалаврын дээд мөн гурав нь бүрэн дунд боловсролтой, таван хүн тутмын нэг нь техникийн болон мэргэжлийн боловсролтой залуучууд байгаа бол 1.8 хувь нь боловсролгүй байна.

### Хүснэгт 6.2. Залуу ажиллагчид, боловсролын түвшин, хүйсээр

Боловсролын түвшин	Бүгд		Эрэгтэй		Эмэгтэй	
	Тоо	%	Тоо	%	Тоо	%
Боловсролгүй	1 482	1.8	1 410	2.7	72	0.2
Бага	1 999	2.4	1 515	2.8	484	1.6
Суурь	12 216	14.5	9 677	18.2	2 539	8.1
Бүрэн дунд	20 743	24.6	12 737	24.0	8 006	25.7
Техникийн болон мэргэжлийн	18 933	22.4	12 977	24.4	5 956	19.1
Тусгай мэргэжлийн дунд	3 211	3.8	2 154	4.1	1 057	3.4
Дипломын болон бакалаврын дээд	25 476	30.1	12 583	23.6	12 893	41.3
Магистр	299	0.4	127	0.2	172	0.6
Дүн, %		100.0		100.0		100.0
Улсын дүн	84 359		53 180		31 179	

Хүйсийн хувьд харахад, эрэгтэй залуу ажиллагчдын хамгийн өндөр буюу 24.4 хувь нь техникийн болон мэргэжлийн боловсролтой байгаа бол хамгийн бага буюу 2.7 хувь нь боловсролгүй байна. Харин эмэгтэй залуу ажиллагчдын хувьд хамгийн өндөр буюу 41.3 хувь нь дипломын болон бакалаврын дээд боловсролтой байгаа бол хамгийн бага буюу 0.2 хувь нь боловсролгүй байна. Эндээс залуу эмэгтэй ажиллагчид боловсрол өндөртэй нь харагдаж байна.

### Зураг 6.4. Залуу ажиллагчид, боловсролын түвшин, хүйс, дүнд эзлэх хувиар




## ЭЗЭМШСЭН МЭРГЭЖИЛ

Залуу ажиллагчдын эзэмшсэн мэргэжлийг хүйсээр авч үзвэл, суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч, зэвсэгт хүчний ажил, мэргэжил, үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан, ХАА, ой, загас агнуурын мэргэшсэн мэргэжилтэй эрэгтэйчүүдийн эзлэх хувь өндөр байгаа бол контор, үйлчилгээний ажилтан, менежер, худалдаа, үйлчилгээний мэргэжилтэй эмэгтэйчүүд ихэнх хувийг эзэлж байна.



Зураг 6.5. Залуу ажиллагчид, эзэмшсэн мэргэжил, хүйс, дүнд эзлэх хувиар



### ГЭРЛЭЛТИЙН БАЙДАЛ

Залуу ажиллагчдыг гэрлэлтийн байдлаар авч үзэхэд 21.1 хувь нь гэрлэсэн, 1.4 хувь нь тусгаарласан, 1.8 хувь нь цуцалсан, 0.2 хувь нь бэлэвсэн бол 75.5 хувь нь огт гэрлээгүй байна.


Хүснэгт 6.3. Залуу ажиллагчид, гэрлэлтийн байдал, хүйс, дүнд эзлэх хувиар

Гэрлэлтийн байдал	Бүгд		Эрэгтэй		Эмэгтэй	
	Тоо	%	Тоо	%	Тоо	%
Огт гэрлээгүй	63 678	75.5	43 705	82.2	19 973	64.1
Гэрлэсэн- Батлуулсан	9 703	11.5	4 671	8.8	5 032	16.1
Гэрлэсэн- Батлуулаагүй	8 134	9.6	4 535	8.5	3 599	11.6
Тусгаарласан	1 157	1.4	-	-	1 157	3.7
Цуцалсан	1 496	1.8	269	0.5	1 227	3.9
Бэлэвсэн	191	0.2	-	-	191	0.6
Дүн, %		100.0		100.0		100.0
Залуу ажиллагчид	84 359		53 180		31 179	

### ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН СТАТУСААР

Залуу ажиллагчдыг хөдөлмөр эрхлэлтийн статусаар харахад нийт ажиллагчдын 53.4 (63.3%) мянга нь цалин хөлстэй ажиллагч, 22.9 (27.1%) мянга нь цалин хөлстэй ажиллагчгүй, зах зээлд чиглэсэн өрхийн аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгч байна.

Зураг 6.6. Залуу ажиллагчид, хөдөлмөр эрхлэлтийн статус, дүнд эзлэх хувиар



Залуучуудыг боловсролын түвшин, хөдөлмөр эрхлэлтийн статусаар уялдуулан харахад бага боловсролтой таван хүн тутмын гурав нь цалин хөлстэй ажилтангүй бие даасан ажиллагч байгаа бол магистрын боловсролтой залуус бүгд цалин хөлстэй ажиллагч байна.


Зураг 6.7. Залуу ажиллагчид, хөдөлмөр эрхлэлтийн статус, боловсролын түвшин, дүнд эзлэх хувиар



## АЖИЛ МЭРГЭЖЛЭЭР

Хөдөлмөр эрхэлсэн залуу ажиллагчдыг ажил мэргэжлийн ангиллаар нь гаргаж харуулав (Зураг 6.12). Залуу ажиллагчдын 27.1 (32.1%) мянга нь хөдөө аж ахуй, ой, загас агнуурын ажил хийж байгаа нь нийт залуу ажиллагчдын дунд хамгийн их хувийг эзэлж байна.

Зураг 6.8. Залуу ажиллагчид, ажил мэргэжлийн ангилал, дүнд эзлэх хувиар




Зураг 6.9. Залуу ажиллагчид, ажил мэргэжил, хүйс, дүнд эзлэх хувиар



Залуу ажиллагчдын эрхэлж байгаа ажил мэргэжлийн ур чадварын түвшний хувьд 10 ажиллагч тутмын 7 нь дунд түвшний ур чадвар бүхий ажил мэргэжлээр ажиллаж байна. Харин өндөр ур чадвар бүхий түвшний ажил мэргэжлээр ажиллаж байгаа залуу ажиллагчид 19.8 хувийг эзэлж байна.

Зураг 6.10. Залуу ажиллагчид, эрхэлж байгаа ажил мэргэжлийн ур чадварын түвшнээр




### ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САЛБАРААР

Залуу ажиллагчдын 32.2 хувь (эрэгтэйчүүдийн 34.9%, эмэгтэйчүүдийн 27.6%) нь хөдөө аж ахуйн салбарт ажиллаж байгаа нь бусад салбараас хамгийн өндөр түвшинд хэвээр байна. Харин аж үйлдвэр, барилгын салбарт 25.7 хувь (эрэгтэйчүүдийн 33.2%, эмэгтэйчүүдийн 12.8%) нь, үйлчилгээний салбарт 42.2 хувь (эрэгтэйчүүдийн 31.9%, эмэгтэйчүүдийн 59.6%) нь ажиллаж байна.


Эдийн засгийн дэд салбарын хувьд авч үзэхэд, 11.4 (13.5%) мянга нь барилгын салбарт, 8.1 (9.7%) бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар үйлчилгээний салбарт, 5.4 (6.4%) мянга нь боловсруулах үйлдвэрийн салбарт, 4.7 (5.6%) мянга нь зочид буудал, байр сууц болон нийтийн хоолны үйлчилгээний салбарт, 4.5 (5.3%) мянга нь боловсролын салбарт ажиллаж байгаа нь бусад салбарынхтай харьцуулахад харьцангуй өндөр хувьтай байна.

Зураг 6.11. Залуу ажиллагчид, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангилал, дүнд эзлэх хувиар



Ажиллагчдыг хүйсээр ангилж үзэхэд эдийн засгийн үйл ажиллагааны салбарын онцлогоос хамаарч нэлээд ялгаатай байна. Тухайлбал, цахилгаан, хий, уур, агааржуулалт; тээвэр, агуулахын үйл ажиллагаа; удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа; уул уурхай, олборлолт; урлаг үзвэр тоглоом наадам; барилгын салбарт ажиллагчдын 85.2-100.0 хувь нь эрэгтэйчүүд байхад усан хангамж, бохир ус зайлуулах систем, хог, хаягдлын менежмент; боловсрол; боловсрол; зочид буудал, байр сууц болон нийтийн хоолны үйлчилгээ; хүний эрүүл мэнд ба нийгмийн хамгааллын үйл ажиллагаа; үйлчилгээний бусад үйл ажиллагаа; салбарт ажиллагчдын 68.4-100 хувь нь эмэгтэйчүүд байна.


Зураг 6.12. Залуу ажиллагчид, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангилал, хүйс, дүнд эзлэх хувиар



Нийт ажиллагчдад залуучуудын эзлэх хувийг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар авч үзэхэд уул уурхай, олборлолт; ХАА, ойн аж ахуйн, загас барилт, ан агнуур; санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа; зочид буудал, байр сууц болон нийтийн хоолны үйлчилгээ; барилга; мэдээлэл, холбооны салбарт улсын дунджаас дээгүүр буюу 7.5-14.6 хувийг эзэлж, хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа; усан хангамж, бохир ус зайлуулах систем,

хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа; цахилгаан, хий, уур, агааржуулалт; удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа; төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал; мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа; боловсрол; урлаг, үзвэр, тоглоом наадам; хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа; бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар үйлчилгээ; боловсруулах үйлдвэрлэл; үйлчилгээний бусад салбар; тээвэр ба агуулахын үйл ажиллагааны салбарт улсын дунджаас доогуур буюу 1.5-7.2 хувийг эзэлж байна.

Зураг 6.63. Нийт ажиллагчдад 15-24 насны залуу ажиллагчдын эзлэх хувь, салбараар



### МАЛЧИД БОЛОН ХУВИАРАА ХӨДӨЛМӨР ЭРХЛЭГЧИД


Судалгааны дүнгээр нийт залуу ажиллагчдын 24.8 (29.4%) мянга нь малчид (эрэгтэйчүүд 68.7%, эмэгтэйчүүд 31.3%), 5.4 (6.4%) мянга нь хувиараа хөдөлмөр эрхлэгчид (эрэгтэйчүүд 76.0%, эмэгтэйчүүд 24.0%) байна. Залуу малчдын 23.1 (92.9%) мянга нь хөдөө орон нутагт байгаа бол хувиараа хөдөлмөр эрхлэгч залуучуудын 3.4 (62.1%) мянга нь хот, суурин газарт байна.

Хүснэгт 6.4. Малчид болон хувиараа хөдөлмөр эрхлэгч залуучууд, байршил, бүс, хувиар

Байршил / Бүс	Бүгд		Малчид		Хувиараа хөдөлмөр эрхлэгчид	
	Тоо	%	Тоо	%	Тоо	%
Хот	50 298	59.6	4 365	20.6	766	8.4
Хөдөө	34 061	40.4	16 832	79.4	8 306	91.6
Баруун бүс	14 974	17.8	6 105	28.7	1 966	21.7
Хангайн бүс	15 706	18.6	6 911	32.6	3 896	42.9
Төвийн бүс	12 721	15.1	4 760	22.5	1 709	18.8
Зүүн бүс	6 704	7.9	2 280	10.8	1 330	14.7
Улаанбаатар	34 255	40.6	1 141	5.4	171	1.9
Дүн, %		100.0		100.0		100.0
Улсын дүн	84 359		21 197		9 072	

Залуу малчид Хөвсгөл, Увс, Өвөрхангай, Архангай аймгуудад, харин хувиараа хөдөлмөр эрхлэгч залуучууд Хэнтий, Баян-Өлгий, Завхан, Өвөрхангай, аймгуудад хамгийн өндөр хувийг эзэлж байна.

Зураг 6.74. Малчид болон хувиараа хөдөлмөр эрхлэгч залуучууд, аймаг, дүнд эзлэх хувиар



### СҮҮЛИЙН 7 ХОНОГТ АЖЛЫН БАЙРАНДАА БАЙСАН ЭСЭХ


Сүүлийн 7 хоногт ажлын байрандаа тогтмол ажиллаж байгаа ажиллагчдын тоо нийт залуу ажиллагчдын 78.8 (93.4%) мянга байсан бол ажлын байрандаа түр байхгүй байсан залуу ажиллагчид 5.5 (6.6%) мянга байна. Байршлын хувьд хот, суурин газарт ажлын байрандаа байгаа залуу ажиллагчид 46.2 (58.5%) мянга, хөдөө орон нутагт 32.7 (41.5%) мянга байна. Ажлын байрандаа түр эзгүй байгаа ажиллагчид хот суурин газарт 4.1 (75.1%) мянга, хөдөө орон нутагт 1.4 (24.9%) мянга байна. Аймгийн хувьд энэ үзүүлэлт хүн ам ихээр төвлөрсөн бүсэд харьцангуй өндөр хувьтай байна.

Хүснэгт 6.5. Залуу ажиллагчид, сүүлийн 7 хоногт ажлын байрандаа байсан эсэх, байршил, бүсээр

Байршил/Бүс	Бүгд		Сүүлийн 7 хоног ажлын байрандаа байгаа эсэх			
			Ажлын байрандаа байгаа		Ажлын байрандаа түр байхгүй	
	Тоо	%	Тоо	%	Тоо	%
Улсын дүн	84 359	100.0	78 832	100.0	5 527	100.0
Хот	50 298	59.6	46 150	58.5	4 148	75.1
Хөдөө	34 061	40.4	32 682	41.5	1 379	24.9
Баруун бүс	14 974	17.8	13 810	17.5	1 164	21.0
Хангайн бүс	15 706	18.6	15 314	19.4	392	7.1
Төвийн бүс	12 721	15.1	12 135	15.4	586	10.6
Зүүн бүс	6 703	7.9	6 102	7.7	601	10.9
Улаанбаатар	34 255	40.6	31 471	39.8	2 784	50.4

Залуу ажиллагчдын 5.5 мянга нь сүүлийн 7 хоногт хөдөлмөр эрхлээгүй ч буцаж хийхээр хүлээгдэж байгаа тогтмол эрхэлдэг ажилтай, тэдгээрийн 4.9 (88.6%) мянга нь цалин хөлстэй эсвэл бизнесийн үйл ажиллагаа эрхэлдэг, 0.6 (11.4%) мянга нь өрх, гэр бүлийн бизнест тусалдаг байна. Цалин, хөлстэй эсвэл хувийн бизнес эрхэлдэг 4.9 мянган залуу ажиллагчдын хувьд тухайн хугацаанд ажлаа хийгээгүй шалтгааныг авч үзэхэд 2.2 (45.0%) мянга нь үүсээд байгаа цар тахалтай холбоотой, 0.9 (18.6%) мянга нь жирэмсний болон эцэг эх болсны амралттай байсан гэж хариулсан нь дийлэнх хувийг эзэлж байна.

Зураг 6.85. Сүүлийн 7 хоногт ажиллаагүй ч буцаж хийхээр хүлээгдэж байгаа цалин хөлс, орлого олох ажилтай залуу ажиллагчид, сүүлийн 7 хоногт ажиллаагүй шалтгаанаар





## АЖЛЫН ЦАГ


Залуу ажиллагчдын долоо хоногийн тогтмол ажилладаг цагийн дундаж нь 49, сүүлийн 7 хоногт ажилласан залуучуудын жинхэнэ ажилласан цагийн дундаж мөн 49 цаг байна. Залуу ажиллагчдын 6.2 хувь нь тогтмол ажлын цагаас нь бага цагаар (жинхэнэ ажилласан цаг нь), 0.6 хувь нь их цагаар ажилласан байна. Залуу ажиллагчдын 38.3 мянга (45.5%) нь 7 хоногт тогтмол 48 цагаас дээш цагаар ажиллаж байна.

Хүснэгт 6.6. Залуу ажиллагчдын ажлын цаг, үндсэн ажлаар, хүйс, дүнд эзлэх хувиар, тогтмол болон жинхэнэ ажилласан цагаар, дүнд эзлэх хувиар

Ажлын цаг	Тогтмол ажилласан цаг		Жинхэнэ ажилласан цаг	
	Тоо	%	Тоо	%
Нийт	84 359	100.0	84 359	100.0
0 цаг	-	-	4 047	4.8
1-14 цаг	448	0.5	749	0.9
15-29 цаг	1 958	2.3	2 205	2.6
30-34 цаг	580	0.7	613	0.7
35-39 цаг	1 709	2.0	1 889	2.2
40-48 цаг	41 347	49.0	38 712	45.9
48-аас дээш цаг	38 317	45.5	35 144	42.9

Залуу ажиллагчдын үндсэн ажилдаа 7 хоногт тогтмол ажилладаг дундаж цагийг хөдөлмөр эрхлэлтийн статусын хувьд авч үзвэл зах зээлд чиглэсэн өрхийн аж ахуйн нэгжийн ажил олгогч 53 цаг ажиллаж байгаа нь хамгийн их байгаа бол аж ахуй нэгж, байгууллагын ажил олгогч болон гүйцэтгэх гэрээлэгч 40 цаг ажиллаж байгаа нь хамгийн бага байна.

Зураг 6.96. Залуу ажиллагчдын долоо хоногт тогтмол ажилладаг үндсэн ажлын дундаж цаг, хөдөлмөр эрхлэлтийн статусаар



Хүснэгт 6.7. Үндсэн ажилдаа бага болон урт цагаар ажиллагч залуучууд, хүйс, үндсэн салбар, хөдөлмөр эрхлэлтийн статус, нийт дүнд эзлэх хувиар

Үзүүлэлтүүд	Нийт залуу ажиллагчид	Богино цагаар ажиллагчид (долоо хоногт 35 хүртэл цаг)		Урт цагаар ажиллагчид (долоо хоногт 48-аас дээш цаг)	
		Тоо	%	Тоо	%
		Бүгд	84 359	2 985	3.5
Эрэгтэй	53 180	1 110	2.1	33 977	63.9
Эмэгтэй	31 179	1 875	6.0	12 612	40.5
Хот	50 298	1 534	3.0	25 411	50.5
Хөдөө	34 061	1 451	4.3	21 178	62.2
Үндсэн салбараар:					
Хөдөө аж ахуйн	27 151	1 331	4.9	18 780	69.2
Үйлдвэрлэлийн	21 642	163	0.8	14 673	67.8
Үйлчилгээний салбар	35 566	1 492	4.2	13 136	36.9
Хөдөлмөр эрхлэлтийн статусаар:					
Аж ахуйн нэгж, байгууллагын ажил олгогч	592	-	-	-	-
Цалин хөлстэй ажиллагчгүй, зах зээлд чиглэсэн өрхийн аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгч	22 885	-	-	372	-
Гүйцэтгэх гэрээлэгч	133	-	-	-	-
Цалин хөлстэй байнгын ажиллагч	23 429	1 440	6.3	16 174	70.7
Цалин хөлстэй түр ажиллагч	22 891		0.0	17	12.8
Цалин хөлстэй тохиолдлын ажиллагч	6 303	68	0.3	8 635	36.9
Цалин хөлстэй дагалдан ажилтан, мэргэшиж буй дадлагажигч ажил	790	570	2.5	13 747	60.1
Хувь нэмрээ оруулагч гэр бүлийн гишүүн	6 639	388	6.2	3 174	50.4
Эдгээр статуст хамрагдаагүй ажиллагчид	697	-	-	54	6.8


Нийт залуу ажиллагчдын 3.0 мянга (3.5%) нь долоо хоногт тогтмол бага цагаар (долоо хоногт 35-аас бага цаг) ажиллаж байгаагийн байршлын хувьд хотод, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар авч үзэхэд үйлчилгээний салбарт, цалин хөлстэй байнгын ажиллагч дийлэнх нь байна. Харин нийт залуу ажиллагчдын 46.3 мянга (55.2%) нь долоо хоногт тогтмол урт цагаар (долоо хоногт 48-аас дээш цаг) ажиллаж байгаагийн байршлын хувьд хотод, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар авч үзэхэд хөдөө аж ахуйн салбарт, хөдөлмөр эрхлэлтийн статусаар цалин хөлстэй байнгын ажиллагч дийлэнх нь байна.

Хүснэгт 6.8. Залуу ажиллагчид тогтмол ажилладаг цагаараа ажилладаг эсэх

Байршил/Бүс	Бүгд		Тогтмол ажилладаг цагаараа ажилласан эсэх					
			Тийм		Үгүй, ажлын цагаас илүү		Үгүй, ажлын цагаас бага	
	Тоо	%	Тоо	%	Тоо	%	Тоо	%
Улсын дүн	84 359	100.0	78 675	100.0	468	100.0	5 216	100.0
Хот	50 299	59.6	46 017	58.5	52	11.1	4 230	81.1
Хөдөө	34 060	40.4	32 658	41.5	416	88.9	986	18.9
Баруун бүс	14 973	17.7	13 963	17.7	149	31.8	861	16.5
Хангайн бүс	15 706	18.6	15 504	19.7	49	10.5	153	2.9
Төвийн бүс	12 721	15.1	11 267	14.3	270	57.7	1 184	22.7
Зүүн бүс	6 704	7.9	6 176	7.9	0	0.0	528	10.1
Улаанбаатар	34 255	40.6	31 765	40.4	0	0.0	2 490	47.6

Залуу ажиллагчдын тогтмол цагаараа ажилладаг эсэхэд тийм гэж хариулсан 78.7 (93.3%) мянга байгаа нь дийлэнх хувийг эзэлж байгаа бол ажлын цагаас бага ажилладаг 5.2 (6.2%) мянга, ажлын цагаасаа илүү ажилладаг 0.5 (0.6%) мянган залуу ажиллагчид байна.

Зураг 6.17. Залуу ажиллагчдын тогтмол ажилладаг цагаасаа илүү, дутуу ажилласан шалтгаанаар




Сүүлийн 7 хоногт ажлын цагаасаа илүү, дутуу ажилласан залуу ажиллагчдыг шалтгаанаар нь авч үзэхэд 2.3 (41.3%) мянга нь, үүсээд байгаа цар тахлын улмаас, 1.3 (22.0%) мянга нь өдрийн чөлөө, амралт, жилийн чөлөө, тусгай чөлөөний улмаас, 0.5 (8.9%) мянга нь хувь хүн болон гэр бүлийн шалтгаан гэр бүлийн үүрэг хариуцлагаас, 0.3 (5.9%) мянга нь улирлын чанартай ажлаас гэж хариулсан иргэд дийлэнх хувийг эзэлж байна.

### ЦАЛИН, ОРЛОГО


Судалгаагаар албан болон албан бус салбарт, өрхийн нэгжид ажиллаж байгаа бүх цалин хөлстэй ажиллагчдын цалингийн мэдээллийг гарт олгогдсон дүнгээр авсан болно. Эдийн засгийн бүх нэгжид ажиллаж буй цалинтай залуу ажиллагчдын сарын дундаж цалин улсын хэмжээнд 773.6 мянган төгрөг, Хангайн бүсийн хувьд хамгийн өндөр буюу 836.3 мянга, бага нь Зүүн бүсэд ббб.3 мянган төгрөг байна.

Зураг 6.108. Цалинтай залуу ажиллагчдын сарын дундаж цалин, хүйс, бүсээр




Улсын хэмжээнд хувиараа хөдөлмөр эрхлэгч залуучуудын сарын дундаж орлого 819.7 мянга, залуу малчдын сарын дундаж орлого 523.6 мянган төгрөг байна. Бүсээр авч үзэхэд хувиараа хөдөлмөр эрхлэгч залуучуудын сарын дундаж орлого хамгийн өндөр нь Баруун бүсэд 737.4 мянга, хамгийн бага нь Зүүн бүсэд 600.1 мянган төгрөг байна. Харин залуу малчдын сарын дундаж орлого хамгийн өндөр нь Төвийн бүсэд 913.6 мянга, хамгийн бага нь Зүүн бүсэд 260.1 мянган төгрөг байна.

Зураг 6.19. Хувиараа хөдөлмөр эрхлэгч болон малчин залуучуудын сарын дундаж орлого, бүсээр



Цалинтай залуу ажиллагчдын сарын дундаж цалин хот, суурин газарт 785.2 мянган төгрөг, хөдөө орон нутагт 712.9 мянган төгрөг, хувиараа хөдөлмөр эрхлэгч залуучуудын хувьд сарын дундаж орлого нь хот, суурин газарт 997.0 мянган төгрөг, хөдөө орон нутагт 552.5 мянган төгрөг байна. Харин залуу малчдын сарын дундаж орлого хот, суурин газарт 474.8 мянган төгрөг, хөдөө орон нутагт 527.2 мянган төгрөг байна.

Зураг 6.110. Залуу ажиллагчдын сарын дундаж цалин болон орлого, хүйс, хот, хөдөөгөөр



## 6.2. ЗАЛУУЧУУДЫН ХӨДӨЛМӨРИЙН ДУТУУ АШИГЛАЛТ


Судалгааны дүнгээр нийт хөдөлмөрийн дутуу ашиглалтын 35.5 (42.0%) мянга нь 15-24 насны залуучууд байгаагийн 18.2 (51.4%) мянга нь эрэгтэй, 17.3 (48.6%) мянга нь эмэгтэй байна. Эдгээр залуучуудын 20.0 (56.5%) мянга нь ажилгүй, 14.5 (40.8%) мянга нь боломжит ажиллах хүч, 1.0 (2.8%) мянга нь цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгчид байна.

Хүснэгт 6.9. Залуучуудын хөдөлмөрийн дутуу ашиглалт, хүйс, байршил, бүсээр

Байршил / Бүс	Бүгд		Хүйсээр			
	Тоо	%	Эрэгтэй		Эмэгтэй	
			Тоо	%	Тоо	%
Хот	26 786	75.5	14 032	77.0	12 754	73.9
Хөдөө	8 685	24.5	4 189	23.0	4 496	26.1
Баруун бүс	9 562	27.0	4 778	26.2	4 784	27.7
Хангайн бүс	5 749	16.2	2 213	12.1	3 536	20.5
Төвийн бүс	4 146	11.7	2 210	12.2	1 936	11.3
Зүүн бүс	2 054	5.7	949	5.3	1 105	6.4
Улаанбаатар	13 960	39.3	8 071	44.3	5 889	34.2
Дүн, %		100.0		100.0		100.0
Улсын дүн	35 471		18 221		17 250	


Хөдөлмөрийн дутуу ашиглалтын нийлмэл түвшин 15-24 насны залуучуудын хувьд 29.8 хувь буюу улсын дунджаас 2.2 дахин их байна.

Зураг 6.121. Залуучуудын хөдөлмөрийн дутуу ашиглалтын түвшин, насны бүлэг, хувиар




15-24 насны ажилгүйчүүдийн хувьд 7.0 (34.8%) мянга нь өмнө нь хөдөлмөр эрхэлж байсан бөгөөд өмнөх ажлаасаа гарсан шалтгаанаар нь авч үзвэл, 2.6 (37.3%) мянга нь түр ажлын байр байсан, 1.7 (24.2%) мянга нь өөрийн хүсэлтээр, 0.6 (8.3%) мянга нь цалин хөлс тохирохгүй, 0.5 (6.5%) мянга нь суралцах болсон учраас гэсэн шалтгаантай хүмүүс хамгийн өндөр хувийг эзэлж байна.

Зураг 6.132. 15-24 насны ажилгүй хүн, өмнөх ажлаасаа гарсан шалтгаан, дүнд эзлэх хувиар




Нийт цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгчдийн 1.0 (16.3%) мянга нь 15-24 насны залуучууд байна. Бүсээр авч үзэхэд баруун бүсэд хамгийн их буюу 78.7 хувь, төвийн бүсэд хамгийн бага буюу 4.1 хувь нь байна.



Зураг 6.143. 15-24 насны цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгчид, бүс, дүнд эзлэх хувиар

15-24 насны цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгчдийг эдийн засгийн салбарын ангиллаар авч үзэхэд, 0.6 (62.4%) мянга нь үйлчилгээний, 0.4 (35.8%) мянга нь хөдөө аж ахуйн, 0.02 (1.8%) мянга нь аж үйлдвэл, барилгын салбарт ажиллаж байна.

Зураг 6.154. 15-24 насны цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгчид, эдийн засгийн үйл ажиллагааны үндсэн салбар, хүйс, дүнд эзлэх хувиар



Нийт боломжит ажиллах хүчний 14.5 (20.2%) мянга нь 15-24 насныхан байгаагийн 6.7 (46.1%) мянга нь эрэгтэйчүүд, 7.8 (53.9%) мянга нь эмэгтэйчүүд байна.


15-24 насны боломжит ажиллах хүчний 78.4 хувь нь хот, суурин газарт, 21.6 хувь нь хөдөөд байна. Энэ насны боломжит ажиллах хүчний 7.0 (61.6%) мянга нь Улаанбаатар хотод, 3.8 (18.4%) мянга нь Баруун бүсэд байгаа нь хамгийн өндөр бол Төвийн бүсэд хамгийн бага буюу 0.8 (5.7%) мянга нь ногдож байна.

Хүснэгт 6.10. 15-24 насны боломжит ажиллах хүч, хүйс, байршил, бүсээр

Байршил/Бүс	Бүгд		Боломжит ажиллах хүч			
			Эрэгтэй		Эмэгтэй	
	Тоо	%	Тоо	%	Тоо	%
Хот	11 143	78.4	5 065	78.1	6 078	78.7
Хөдөө	3 312	21.6	1 595	21.9	1 717	21.3
Баруун бүс	3 779	18.4	1 872	19.7	1 907	17.3
Хангайн бүс	1 825	9.5	699	8.3	1 126	10.5
Төвийн бүс	837	5.7	262	4.9	575	6.3
Зүүн бүс	1 059	4.8	234	4.5	825	5.1
Улаанбаатар	6 955	61.6	3 593	62.6	3 362	60.8
Дүн, %		100.0		100.0		100.0
Улсын дүн	14 455		6 660		7 795	

15-24 насны боломжит ажиллах хүчний 13.2 мянга буюу 91.2 хувь нь сүүлийн 30 хоногт цалин, хөлстэй ажил хайгаагүй, бизнес эрхлэх оролдлого хийгээгүй ч ажил хийх боломжтой байна. Тэдгээр хүн амын цалинтай ажил хайх эсвэл бизнес эрхлэх ямар нэгэн оролдлого хийгээгүй шалтгааныг дараах зургаар харууллаа.

Зураг 6.165. Сүүлийн 30 хоногт ажил хайгаагүй боломжит ажиллах хүч, хайгаагүй шалтгаан, дүнд эзлэх хувиар



Харин 15-24 насны боломжит ажиллах хүчний 1.2 мянга буюу 8.2 хувь нь судалгаа явагдсан лавлагаа 7 хоног буюу тухайн хугацаанаас хойших 14 хоногт ажил хийхэд бэлэн биш байсан байна. Тэдгээр хүн амын 0.8 мянга (71.5%) нь гэр бүлийн шалтгаанаар ажил хийхэд бэлэн биш гэсэн шалтгаантай нь хамгийн өндөр хувийг эзэлж байна.

15-24 насны боломжит ажиллах хүчийг хөдөлмөрийн зах зээлд идэвхтэй оролцохгүй байгаа шалтгаанаар нь авч үзэхэд, суралцдаг 4.4 (30.7%) мянга, үүсээд байгаа цар тахлын улмаас 2.8 (19.4%) мянга, ажил хайгаад олдохгүй байгаа 1.9 (13.3%) гэсэн нь ихэнх хувийг эзэлж байна.

Зураг 6.176. 15-24 насны боломжит ажиллах хүч, ажилгүй байгаа шалтгаан, дүнд эзлэх хувиар



## БОЛОВСРОЛЫН ТҮВШНЭЭР


Залуучуудын хөдөлмөрийн дутуу ашиглалтын хувьд арван хүн тутмын гурав нь дипломын болон бакалаврын дээд, дөрвөн хүн тутмын нэг нь бүрэн дунд, таван хүн тутмын нэг нь техникийн болон мэргэжлийн боловсролтой залуучууд байгаа бол 2.5 хувь нь боловсролгүй байна.

### Хүснэгт 6.11. Залуучуудын хөдөлмөрийн дутуу ашиглалт, боловсролын түвшин, хүйсээр

Боловсролын түвшин	Бүгд		Хүйсээр			
			Эрэгтэй		Эмэгтэй	
	Тоо	%	Тоо	%	Тоо	%
Боловсролгүй	900	2.5	17	0.1	883	5.1
Бага	458	1.3	333	1.8	125	0.7
Суурь	4 399	12.4	2 947	16.2	1 452	8.4
Бүрэн дунд	9 877	27.8	5 425	29.8	4 452	25.8
Техникийн болон мэргэжлийн	7 070	19.9	4 668	25.6	2 402	13.9
Тусгай мэргэжлийн дунд	1 253	3.6	626	3.4	627	3.7
Дипломын болон бакалаврын дээд	11 514	32.5	4 205	23.1	7 309	42.4
Дүн, %		100.0		100.0		100.0
Улсын дүн	35 471		18 221		17 250	

Хүйсээр харахад, 15-24 насны эрэгтэйчүүдийн хувьд хөдөлмөрийн дутуу ашиглалт хамгийн өндөр буюу 29.8 хувь нь бүрэн дунд боловсролтой байгаа бол 0.1 хувь нь боловсролгүй байна. Харин эмэгтэйчүүдийн хувьд хөдөлмөрийн дутуу ашиглалтын хувьд хамгийн өндөр буюу 42.4 хувь нь дипломын болон бакалаврын дээд боловсролтой байгаа бол 0.7 хувь нь бага боловсролтой байна.

### Зураг 6.187. Залуучуудын хөдөлмөрийн дутуу ашиглалт, боловсролын түвшин, хүйс, дүнд эзлэх хувиар



## ЭЗЭМШСЭН МЭРГЭЖИЛ

Залуучуудын хөдөлмөрийн дутуу ашиглалтыг эзэмшсэн мэргэжлийн хувьд авч үзвэл хоёр хүн тутмын нэг нь энгийн ажил мэргэжилтэй, дөрвөн хүн тутмын нэг нь мэргэжилтэн байна.



Зураг 6.28. Залуучуудын хөдөлмөрийн дутуу ашиглалт, эзэмшсэн мэргэжил, дүнд эзлэх хувиар



Хүйсээр авч үзвэл, зэвсэгт хүчний ажил, мэргэжил; машин механизм, төхөөрөмжийн операторч, угсрагч; энгийн ажил мэргэжил; үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажил мэргэжилтэй эрэгтэйчүүдийн эзлэх хувь өндөр байгаа бол менежер; худалдаа, үйлчилгээний ажилтан; контор, үйлчилгээний мэргэжилтэй эмэгтэйчүүдийн эзлэх хувь өндөр байна.

Зураг 6.29. Залуучуудын хөдөлмөрийн дутуу ашиглалт, эзэмшсэн мэргэжил, хүйс, дүнд эзлэх хувиар



### ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЭГҮЙ, БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРТ ХАМРАГДААГҮЙ ЗАЛУУЧУУД


Залуучуудын ажилгүйдлийн түвшний үзүүлэлт нь залуучуудын хөдөлмөрийн зах зээлийн нөхцөл байдлын талаарх зарим мэдээллийг илэрхийлнэ. Өөрөөр хэлбэл эдгээр тоо мэдээлэл нь залуучуудад тулгарч буй асуудлыг бүрэн илэрхийлж чадахгүй бөгөөд шийдвэр гаргах үйл явцад үүнээс дэлгэрэнгүй, бодитой мэдээлэл шаардлагатай. Харин хөдөлмөр эрхлээгүй, боловсрол, сургалтад хамрагдаагүй байгаа залуучуудын талаарх үзүүлэлт нь ажилгүй залуучууд гэхээсээ илүүтэйгээр хөдөлмөрийн зах зээлд шинээр орж ирэх боломжтой ажиллах хүчний нөөцийн хэмжүүр болж өгдөг. Үүнд ажил хайхаас шантарсан

залуучууд болон хөгжлийн бэрхшээлтэй, гэр орныхоо ажилд тусалдаг гэх зэрэг бусад олон шалтгаанаар ажиллах хүчнээс гадуур байгаа залуучууд хамрагдана.

Тиймээс ч Тогтвортой хөгжлийн зорилгын “2030 он гэхэд хөдөлмөр эрхлээгүй, боловсрол, сургалтаас гадуур байгаа залуучуудын эзлэх хувийг үлэмж хэмжээгээр бууруулах” гэж авч үзсэн бөгөөд 8.6 дугаар Зорилтын хэрэгжилтийг 8.6.1 буюу “15-24 насны хөдөлмөр эрхлээгүй, боловсрол, сургалтаас гадуур байгаа залуучуудын эзлэх хувь” гэсэн шалгуур үзүүлэлтээр тооцно. Уг үзүүлэлт нь хөдөлмөр эрхэлдэггүй, сургуульд суралцдаггүй 15-24 насны залуучууд тухайн насны хүн амын хэдэн хувийг эзэлж буйг илэрхийлнэ.


Судалгааны дүнгээр 15-24 насны нийт 388.0 мянган залуучууд байгаагийн 69.7 (18.0%) мянга нь тухайн хугацаанд хөдөлмөр эрхлээгүй болон боловсрол, сургалтын хөтөлбөрт хамрагдаагүй залуучууд байна. Бүс нутгаар авч үзэхэд эдгээр залуучуудын 49.5 хувь нь Улаанбаатар хотод байгаа бол 5.5 хувь нь Зүүн бүсэд байна.

Зураг 6.190. 15-24 насны хөдөлмөр эрхлээгүй, боловсрол, сургалтад хамрагдаагүй залуучууд, бүс, дүнд эзлэх хувиар



Улсын түвшин хөдөлмөр эрхлээгүй, боловсрол, сургалтад хамрагдаагүй байгаа залуучуудын тухайн насны хүн амд эзлэх хувь 18.0 хувь, эрэгтэйчүүдийнх 17.4 хувь, эмэгтэйчүүдийнх 18.6 хувь байна. Уг үзүүлэлтийг боловсролын түвшнээр зурагт 6.38-д харууллаа

Зураг 6.201. 15-24 насны хөдөлмөр эрхлээгүй, боловсрол, сургалтад хамрагдаагүй байгаа залуучуудын эзлэх хувь, боловсролын түвшин, хүйсээр



Хөдөлмөр эрхлээгүй, боловсрол, сургалтад хамрагдаагүй 15-24 насны залуучуудын 95.5 хувь нь боловсролтой, үүнээс 52.8 хувь нь мэргэжил эзэмших түвшний боловсролтой байна. Тухайлбал 29.5 хувь нь дээд боловсролтой, 23.3 хувь нь техникийн болон мэргэжлийн, тусгай мэргэжлийн дунд боловсролтой залуучууд байна. Харин бүрэн дунд боловсролтой залуучууд 31.9 хувь нь байна.

## VII. АЖИЛЛАХ ХҮЧНИЙ УЛИРЛЫН ХЭЛБЭЛЗЭЛ

Тус судалгааны нэг зорилго нь хүн амын хөдөлмөрийн зах дээл дэх оролцооны талаарх мэдээллийг улирлаар цуглуулан үндэсний хэмжээнд болон хот, хөдөөгийн түвшинд судлан тогтоох явдал юм. Энэ зорилгын хүрээнд нийт түүврийн хэмжээг 4 улирлаар бүлэглэн тэнцүү хувааж, түүврийн сонголтыг 3 сар тутам буюу улирал бүрээр хангалттай хэмжээнд хийсэн болно. Нэг улиралд 3480 өрхийг түүвэрлэн хамруулж, нийт дөрвөн улирлын тоо мэдээг нэгтгэн үндсэн үзүүлэлтүүдийг тооцсон бөгөөд улирал тус бүрээр гаргасан үндсэн үзүүлэлтүүдийн үр дүнг энэхүү бүлэгт танилцуулж байна. Судалгаанд нийт 13920 өрхийн 47196 гишүүдийг хамруулж, судалгааны мэдээллийг 2021 оны 1 дүгээр сараас 2021 оны 12 дугаар сарыг дуустал хугацаанд 4 улирлаар цуглуулав.

### 7.1. ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛ ДЭХ ОРОЛЦОО

Судалгааны тооцооноос ажиглахад ажилгүй хүн болон боломжит ажиллах хүчин 1, 2-р улиралд өндөр байсан бол, 3, 4-р улиралд ажиллах хүчний эгнээнд нэгдсэн байна. Тухайлбал, ажиллагчид 1 дүгээр улиралд 1156.1 мянган байсан бол 4 дүгээр улиралд өсөж 1226.5 мянга болсон байна. Үүнийг дагаад ажилгүй хүн 1 дүгээр улиралд 101.2 мянга байсан бол 4 дүгээр улиралд 99.4 мянга хүрч, боломжит ажиллах хүч 1 дүгээр улиралд 108.8 мянга байсан бол 4 дүгээр улиралд 99.4 мянга болж тус тус буурсан байна. Ингэснээр 4 дүгээр улиралд хөдөлмөрийн дутуу ашиглалтын түвшин 1 дүгээр улирлаас 5.2 хувиар буурч 11.9 хувь болсон байна.


Монгол Улсад 2020 оны 12-р сард хэрэгжүүлсэн цар тахлаас сэргийлэх хатуу хөл хорио, хязгаарлалтын арга хэмжээ нь 2021 оны 1-р улирлын хөдөлмөр эрхлэлтийн эрэлтийг бууруулахад нөлөөлсөн бол Засгийн Газраас хязгаарлалтын арга хэмжээг сулруулснаар 2-р улиралд хөдөлмөр эрхлэлт илүү эрчимтэй сэргэх боломжийг олгосон байх магадлалтай.

#### Хүснэгт 7.1. Хөдөлмөр эрхлэлтийн үзүүлэлтүүд, улирлаар

Үндсэн үзүүлэлтүүд	2021-I	2021-II	2021-III	2021-IV
Ажиллах хүч, мянган хүн	1 156.1	1207.0	1226.8	1226.5
Ажиллагчид	1 054.9	1105.7	1135.9	1127.1
Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгч	6.3	2.8	8.3	6.8
Ажилгүй хүн	101.2	101.3	90.9	99.4
Ажиллах хүчнээс гадуурх хүн ам, мянган хүн	949.7	917.0	893.8	878.2
Боломжит ажиллах хүч	108.8	71.8	54.2	45.1
Бусад ажиллах хүчнээс гадуурх хүн ам	840.9	845.1	839.6	833.1
Ажиллах хүчний оролцооны түвшин, %	54.9	56.8	57.9	58.3
Хөдөлмөр эрхлэлтийн түвшин, %	50.1	52.1	53.6	53.6
Хөдөлмөрийн дутуу ашиглалтын нийлмэл түвшин, %	17.1	13.8	12.0	11.9
Ажилгүйдлийн түвшин, %	8.8	8.4	7.4	8.1
Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэлт болон ажилгүйдлийн нэгдсэн түвшин, %	9.3	8.6	8.1	8.7
Ажилгүй хүн болон боломжит ажиллах хүчний нэгдсэн түвшин, %	16.6	13.5	11.3	11.4

Ажиллах хүчний оролцооны түвшин 1 дүгээр улиралд хамгийн бага буюу 54.9 хувь, 4 дүгээр улиралд хамгийн өндөр буюу 58.3 хувьтай байна.


Зураг 7.1. Ажиллах хүчний оролцооны түвшин, хүйсээр, хувь, улирлаар



## 7.2. АЖИЛЛАГЧИД


15 ба түүнээс дээш насны хүн амын хөдөлмөр эрхлэлтийн түвшнийг байршлаар авч үзвэл, хөдөө, орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин хотын хөдөлмөр эрхлэлтийн түвшнээс 12.5-20.2 хувиар өндөр байна. Хөдөлмөр эрхлэлтийн түвшин улсын хэмжээнд 1 дүгээр улиралд хамгийн бага буюу 50.1 хувь байсан бол 3 болон 4 дүгээр улиралд 3.5 хувиар өсөж хамгийн их буюу 53.6 хувь болсон байна. Хүйсээр харвал, эрэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин улсын дундаж түвшнээс их (6.3-8.2 хувиар), эмэгтэйчүүдийн хувьд улсын дундаж түвшнээс бага (5.6-7.1 хувиар) байна. Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин 2 дугаар улиралд хамгийн их буюу 15.3 хувийн зөрүүтэй байна.

Зураг 7.2. Хөдөлмөр эрхлэлтийн түвшин, байршил, хүйс, хувиар, улирлаар




Хүн амын хөдөлмөр эрхлэлтийн хандлагыг улирлаар, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар нь харвал, хөдөө аж ахуйн салбарын ажиллагчид 1-р улирлаас 4-р улирлын хооронд 4.5-12.4 мянган хүнээр буурсан, 2-р улиралд хамгийн их хэлбэлзэлтэй буюу 12.4 мянгаар буурсан байна. Үйлдвэрлэлийн салбарын ажиллагчид 2-р улиралд хамгийн их буюу 39.7 мянгаар өсөж, 4-р улиралд өмнөх улирлаас 18.9 мянгаар буурсан байна. Харин үйлчилгээний салбарын ажиллагчдын тоо 1-р улирлаас 4-р улиралд тогтвортой өссөн байна. Тус салбарын ажиллагчдын өсөлт 2-3-р улиралд хамгийн ихээр буюу 35.0 мянган ажиллагчаар өсжээ. Үүнээс харахад хавар, зун буюу 2, 3 дугаар улиралд ажиллагчид өсөж байгаа нь улирлын чанартай хөдөлмөр эрхлэлттэй холбоотой. Улирлын шинж чанартай ажлын байр бий болдогтой холбоотойгоор иргэд хөдөлмөрийн зах зээлд идэвхтэй оролцож, ажиллах хүчнээс гадуурх хүн амаас ажиллагч эсвэл ажилгүй иргэдийн эгнээнд шилжих хандлага байна.

Зураг 7.3. Ажиллагчид, эдийн засгийн үйл ажиллагааны үндсэн салбар, мянган хүн, улирлаар



Ажиллагчдыг эрхэлж буй ажил мэргэжлээр нь авч үзэхэд, хөдөө аж ахуй, ой, загас агнуурын мэргэшсэн ажилтан болон мэргэжилтнээр ажилладаг ажиллагчид дийлэнх хувийг эзэлж байна. Хамгийн өндөр хэлбэлзэл 3-р улиралд гарч хөдөө аж ахуй, ой, загас агнуурын мэргэшсэн ажилтны эзлэх хувь өмнөх улирлаас 18.3 нэгж хувиар буурч, энгийн ажил, мэргэжил өмнөх улирлаас 16.9 нэгж хувиар, мэргэжилтэн өмнөх улирлаас 20.1 нэгж хувиар тус тус өссөн байна. Худалдаа, үйлчилгээний ажилтны эзлэх хувь 1, 2-р улиралд 15.4 хувьтай тогтмол байсан бол 3-р улиралд 9.2 нэгж хувиар буурч, үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажлын эзлэх хувь 1-р улирлаас 2-р улирлын хороонд өсөж, 3-4-р улиралд буурсан байна. Менежерийн эзлэх хувь 1-р улиралд 5.7 хувь байсан бол, 2-р улиралд эзлэх хувь өсөж 6.9 хувь болж, 3-р улиралд эзлэх хувь буураад 2.0 хувь болж өөрчлөгдсөн бол 4-р улиралд 7.7 хувь болж өссөн байна. Контор, үйлчилгээний ажилтны эзлэх хувь 1-р улиралд 3.7 хувь байсан бол 2, 3-р улиралд буурч 1.0 хувьд хүрсэн бол, 4-р улиралд 3.0 хувь болсон байна.

Зураг 7.4. Ажиллагчид, ажил мэргэжил, дүнд эзлэх хувь, улирлаар



Ажиллагчдыг хөдөлмөр эрхлэлтийн статусаар авч үзвэл, цалин хөлстэй ажиллагчгүй зах зээлд чиглэсэн өрхийн аж ахуй эрхлэгч, цалин хөлстэй байнгын болон түр ажиллагчийн бүлэг дийлэнх байна. Хөдөлмөр эрхлэлтийн статусын хувьд нийт ажиллагчдад эзлэх хувиар харьцуулбал, цалин хөлстэй байнгын ажиллагч 2-р улиралд өмнөх улирлаас 3.1 нэгж хувиар өсөж, 3-р улиралд өмнөх улирлаас 1.0 нэгж хувиар буурчээ. Цалин хөлстэй түр ажиллагчийн


эзлэх хувь 2-р улиралд 2.9 нэгж хувиар буурч, 3-р улиралд өмнөх улирлаас 2.7 нэгж хувиар өссөн байна.

### Хүснэгт 7.2. Ажиллагчид, хөдөлмөр эрхлэлтийн статус, дүнд эзлэх хувь, улирлаар

Статус	2021-I	%	2021-II	%	2021-III	%	2021-IV	%
Нийт ажиллагчид, мян.хүн	1054.9	100.0	1105.7	100.0	1135.9	100.0	1127.1	100.0
Ажил олгогч:								
Аж ахуйн нэгж, байгууллагын ажил олгогч	19.4	1.8	20.2	1.8	22.1	1.9	21.2	1.9
Зах зээлд чиглэсэн өрхийн аж ахуйн нэгжийн ажил олгогч	20.8	2.0	22.2	2.0	18.7	1.6	19.3	1.7
Цалин хөлстэй ажиллагчгүй бие даасан ажиллагч:								
Цалин хөлстэй ажиллагчгүй аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаа эрхлэгч	7.9	0.8	12.3	1.1	9.7	0.9	11.3	1.0
Цалин хөлстэй ажиллагчгүй, зах зээлд чиглэсэн өрхийн аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгч	366.2	34.7	383.3	34.7	382.8	33.7	370.2	32.8
Гүйцэтгэх гэрээлэгч	2.0	0.2	3.5	0.3	4.2	0.4	2.6	0.2
Цалин хөлстэй ажиллагч:								
Цалин хөлстэй байнгын ажиллагч	320.5	30.3	369.6	33.4	367.9	32.4	366.9	32.6
Цалин хөлстэй түр ажиллагч	257.8	24.4	238.1	21.5	275.2	24.2	277.2	24.6
Цалин хөлстэй тохиолдлын ажиллагч	26.2	2.5	31.3	2.8	32.2	2.8	35.6	3.2
Цалин хөлстэй дагалдан ажилтан, мэргэшиж буй дадлагажигч ажилтан, дагалдан дадлагажигчид	8.4	0.8	4.0	0.4	3.0	0.3	3.2	0.3
Хувь нэмрээ оруулагч гэр бүлийн гишүүн	18.9	1.8	15.9	1.4	16.1	1.4	16.0	1.4
Эдгээр статуст хамрагдаагүй ажиллагчид	7.0	0.7	5.3	0.5	4.1	0.4	3.6	0.3

Тухайн хугацаанд буюу сүүлийн долоо хоногт ажиллаагүй ч буцаж хийхээр хүлээгдэж, ажлын байр нь хадгалагдаж байгаа, цалин, хөлс, орлого олох зорилгоор ажил эрхэлдэг ажиллагчид эхний хоёр улиралд 10.1-11.5 хувийг эзэлж байсан бол 3, 4-р улиралд буурч 6.6-2.8 хувь болсон байна. Эдгээр ажиллагчдыг эдийн засгийн салбараар нь харвал, 1-р улиралд хөдөө аж ахуйн салбарт 10.2 мянга, үйлдвэрлэлийн салбарт 36.1 мянга, үйлчилгээний салбарт 50.2 мянга байсан бол 2-р улиралд ХАА-н салбарт 37.5 нэгж хувь, үйлдвэрлэлийн салбарт 10.7 нэгж хувиар тус тус буурсан бол үйлчилгээний салбарт 50.2 нэгж хувиар өссөн байна. 3-р улиралд ХАА-н салбарт өмнөх улирлаас 29.9 нэгж хувь өсөж, үйлчилгээний салбарт 47.0 нэгж хувь, үйлдвэрлэлийн салбарт 41.0 нэгж хувиар буурсан байна. 4-р улиралд бүх салбар өмнөх улирлаас 27.3-69.1 нэгж хувийн бууралттай гарч ажлын байрандаа түр хугацаагаар байхгүй байсан ажиллагчид ХАА-н салбарт 4.4 мянга, үйлдвэрлэлийн салбарт 12.4 мянга, үйлчилгээний салбарт 13.8 мянга болжээ.

### Зураг 7.5. Ажиллагчид, сүүлийн 7 хоногт ажилласан эсэх, хувь, улирлаар




Ажлын байрандаа түр хугацаагаар байхгүй байсан ажиллагчдыг шалтгаанаар нь авч үзвэл, амралттай байсан, үүсээд байгаа цар тахлын улмаас гэсэн хоёр шалтгаан хамгийн их улирлын хэлбэлзэлтэй байна. Амралттай байсан гэсэн шалтгаантай ажиллагчид 1-р улиралд 3.9 хувиас 2-р улиралд 10.9 хувь, 3-р улиралд 45.3 хувьд хүрээд 4-р улиралд буурч 15.5 хувь болсон байна. Харин үүсээд байгаа цар тахлын улмаас ажлын байрандаа түр хугацаагаар байхгүй байсан ажиллагчид 1-р улирлын 59.9 хувиас 2-р улиралд 78.1 хувь болон өсөж, 3-р улиралд 28.2 хувь, 4-р улиралд 15.1 хувь болон буурчээ.

**Хүснэгт 7.3. Ажлын байрандаа түр хугацаагаар байхгүй байсан ажиллагчдыг шалтгаанаар**

Шалтгаан	2021-I	2021-II	2021-III	2021-IV
Ажлын шинж байдлаас хамаарч ээлжийн ажил болон уян хатан цагаар ажилласан	7.8	1.1	4.4	20.1
Амралттай байсан	3.9	10.9	45.3	15.5
Өвчин осол гэмтэлд өртсөн	2.8	0.9	3.0	9.2
Жирэмсний болон эцэг эх болсны амралттай	9.2	6.1	9.3	9.9
Эхийн чөлөөтэй	0.4	-	2.0	0.9
Боловсрол, сургалтын чөлөөтэй	-	-	0.2	-
Бусад хувийн амралттай (гэр бүлдээ анхаарах зэрэг)	2.9	1.0	1.9	5.8
Түр зуур ажил хаялт, үйлчлүүлэгчдэд үзүүлэх хөнгөлөлт, ажлын завсарлага авсан	0.2	-	0.1	2.5
Цаг агаар муу, байгалийн гамшигтай	-	-	-	0.2
Хөдөлмөрийн маргаан үүссэн	-	-	-	8.0
Улирлын чанартай ажил хийдэг	0.8	0.1	-	6.1
Үүсээд байгаа цар тахлын улмаас	59.9	78.1	28.2	15.1
Бусад	12.2	1.7	5.5	6.7
Нийт	100	100	100	100

Хувиараа хөдөлмөр эрхлэгчид болон малчдыг улирлаар харвал, хувиараа хөдөлмөр эрхлэгчид 1-р улиралд хамгийн бага 180.8 мянга байсан бол 3 дугаар улиралд хамгийн их буюу 222.5 мянга болсон байна. Хувиараа хөдөлмөр эрхлэгчид 4-р улиралд 188.1 мянга болж буурсан ч 1-р улирлаас их байна. Малчид 1-р улиралд хамгийн их буюу 264.5 мянга байсан бол 2-р улирлаас буурч 3-р улиралд хамгийн бага буюу 237.6 мянга болжээ. Харин 4 дүгээр улиралд эргэж өсөн 262.6 мянга болсон байна. Өвөл, хаврын улиралд малчдын тоо өсөж, зун, намрын улиралд буурсан байна.

**Зураг 7.6. Хувиараа хөдөлмөр эрхлэгч, малчид, мянган хүн ,улирлаар**



Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн улирлын хэлбэлзлийг авч үзэхэд, 2, 3-р улиралд бусад улирлаас их байна (хөдөө аж ахуйн салбарыг оруулсан, оруулаагүй аль аль нь). Тухайлбал, 2021 оны 1-р улиралд ХАА-н салбарын ажиллагчдыг оруулсан дүнгээрх албан бус хөдөлмөр




эрхлэгчид 458.6 мянга байсан бол 2-р улиралд 459.9 мянга, 3-р улиралд 462.8 мянган болон өсөж, 4-р улиралд 446.8 мянга болж буурчээ. Хүйсээр авч үзвэл, бүх улиралд эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс их байсан бол уг ялгаа 4 дүгээр улиралд 20.6 нэгж хувьд хүрч ихэссэн байна.

#### Хүснэгт. 7.4. Албан бус хөдөлмөр эрхлэгч, хүйсээр, мянган хүн, улирлаар

Хүйс	2021-I	%	2021-II	%	2021-III	%	2021-IV	%
ХАА-н салбар орсон дүнгээр:								
Эрэгтэй	267.2	58.3	272.4	59.2	273.8	59.2	269.3	60.3
Эмэгтэй	191.4	41.7	187.5	40.8	189.0	40.8	177.5	39.7
Нийт	458.6		459.9		462.8		446.8	
ХАА-н салбар ороогүй дүнгээр:								
Эрэгтэй	101.7	61.6	112.9	63.9	120.4	65.2	112.2	65.7
Эмэгтэй	63.5	38.4	63.7	36.1	64.2	34.8	58.6	34.3
Нийт	165.2		176.5		184.6		170.8	

Албан бус хөдөлмөр эрхлэгчдийг эдийн засгийн салбараар харвал, ХАА-н салбарт 1-р улиралд 293.4 мянга байсан бол 2-р улиралд өмнөх улирлаас 10.1 мянга, 3-р улиралд өмнөх улирлаас 5.2 мянга, 4-р улиралд өмнөх улирлаас 2.2 мянган хүнээр тус тус буурсан байна. Үйлчилгээний салбарт эхний улиралд 106.2 мянга байсан албан бус хөдөлмөр эрхлэгчид 2-р улиралд 6.9 мянган хүнээр буурч, 3-р улиралд өмнөх улирлаас эргэн 10.8 мянган хүнээр өсөж 110.2 мянга, 4-р улиралд 110.8 мянга болсон байна.

#### Зураг 7.7. Албан бус хөдөлмөр эрхлэгч, эдийн засгийн салбараар, мянган хүн, улирлаар



Ажиллагчдын тогтмол ажлын цагаар ажилласан эсэхийг харвал 1-р улиралд ажиллагчдын 88.4 хувь, 2-р улиралд 86.2 хувь, 3 дугаар улиралд 93.9 хувь, 4-р улиралд 96.3 хувь нь тогтмол ажлын цагаар ажилласан бол ажлын цагаас бага цагаар ажилласан ажиллагчдын хувь 1-р улиралд 10.4 хувь байснаас 2-р улиралд 12.3 хувь болон өссөн хэдий ч 3, 4-р улиралд дараалан буурч 2.9 хувьд хүрсэн байна.

#### Хүснэгт 7.5. Ажиллагчид тогтмол ажилладаг цагаараа ажилласан эсэх, хувь, улирлаар

	2021-I	2021-II	2021-III	2021-IV
Тийм	88.4	86.2	93.9	96.3
Үгүй, ажлын цагаас илүү ажилласан	1.2	1.5	0.7	0.8
Үгүй, ажлын цагаас бага ажилласан	10.4	12.3	5.4	2.9
Нийт	100.0	100.0	100.0	100.0

Тогтмол ажлын цагаасаа их эсвэл бага цагаар ажилласан ажиллагчдыг шалтгаанаар нь харвал 1 болон 2 дугаар улиралд цар тахлын шалтгаан (43.6%-72.0%), 3 дугаар улиралд

өдрийн чөлөө, амралт, жилийн чөлөө, тусгай чөлөөтэй гэсэн шалтгаан (36.0%), 4 дүгээр улиралд улирлын чанартай ажлын шалтгаан (19.5%) хамгийн их хувийг эзэлж байна.

Хүснэгт 7.6. Ажиллагчид тогтмол ажлын цагаасаа их, бага цагаар ажилласан шалтгаан, хувь, улирлаар

Шалтгаан	2021-I	2021-II	2021-III	2021-IV
Ээлжийн ажил болон тогтмол бус уян хатан ажлын цагтай ажлаас шалтгаалсан хувьсах ажлын цагтай учраас	11.4	2.5	3.8	11.8
Гэрээний нөхцөлтэй холбоотой ажлын цагаас шалтгаалан (хагас цагийн ажил, төрийн албаны ажил)	0.6	0.3	1.0	1.6
Сүүлийн өдрүүдэд ажлын ачаалал нэмэгдсэн	6.0	5.0	4.6	11.5
Өндөр орлоготой тул	0.3	0.0	0.0	0.0
Өдрийн чөлөө, амралт, жилийн чөлөө, тусгай чөлөө	4.4	7.7	37.3	7.3
Хувь хүн болон гэр бүлийн шалтгаан гэр бүлийн үүрэг хариуцлага	5.5	2.3	1.1	9.9
Өвчин гэмтэл гэх мэт	5.4	2.0	3.7	7.1
Үйлчлүүлэгч болон захиалгын бууралт түүхий эд эрчим хүчний дутагдал гэх мэт	5.5	1.7	2.4	2.2
Сургууль болон сургалт	0.0	0.0	0.7	0.0
Хөдөлмөрийн маргаан	0.0	0.0	0.0	0.0
Ажил эхлэх ажил дуусах ажил өөрчлөгдөх	1.2	0.2	0.9	3.5
Улирлын чанартай ажил	9.2	1.9	10.8	20.2
Цаг агаар муу байгалийн гамшгийн нөлөө	2.4	2.1	0.8	2.1
Үүсээд байгаа цар тахлын улмаас	43.7	71.4	28.3	17.2
Бусад	4.5	2.9	4.4	5.5
Нийт	100	100	100	100

### 7.3. ХӨДӨЛМӨРИЙН ДУТУУ АШИГЛАЛТ

Хөдөлмөрийн дутуу ашиглалтын үзүүлэлтүүдийг улирлаар авч үзэхэд, боломжит ажиллах хүч 1-р улиралд 108.8 мянга байсан бол 2-р улиралд 71.8 мянга, 3-р улиралд 54.2 мянга, 4-р улиралд 45.1 мянган хүн болж дараалан буурсан нь хамгийн их хэлбэлзэлтэй байна.

Хүснэгт 7.7. Хөдөлмөрийн дутуу ашиглалт, мянган хүн, улирлаар

Үзүүлэлт	2021-I	2021-II	2021-III	2021-IV
Нийт хөдөлмөрийн дутуу ашиглалт	216.3	175.9	153.4	151.3
Ажилгүй хүн	101.2	101.3	90.9	99.4
Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгч	6.3	2.8	8.3	6.8
Боломжит ажиллах хүч	108.8	71.8	54.2	45.1

Хөдөлмөрийн дутуу ашиглалтын түвшнүүдийг авч үзэхэд, 1-р улиралд хамгийн өндөр түвшинд буюу хөдөлмөрийн дутуу ашиглалтын нийлмэл түвшин 17.1 хувь, ажилгүйдлийн түвшин 8.8 хувь, цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэлт болон ажилгүйдлийн нэгдсэн түвшин 9.3 хувь, ажилгүй хүн болон боломжит ажиллах хүчний нэгдсэн түвшин 16.6 хувь байсан бол 3 дугаар улиралд хамгийн бага түвшинд буюу хөдөлмөрийн дутуу ашиглалтын нийлмэл түвшин 12.0 хувь, ажилгүйдлийн түвшин 7.4 хувь, цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэлт болон ажилгүйдлийн нэгдсэн түвшин 8.1 хувь, ажилгүй хүн болон боломжит ажиллах хүчний нэгдсэн түвшин 11.3 хувь болсон байна.

Зураг 7.8. Хөдөлмөрийн дутуу ашиглалт, хувь, улирлаар




Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгчдийг эдийн засгийн салбараар нь авч үзвэл, улирлын хэлбэлзэл голлон хөдөө аж ахуй, ойн аж ахуйн, загас барилт, ан агнуур, боловсруулах үйлдвэрлэл, бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар үйлчилгээ, тээвэр ба агуулахын үйл ажиллагааны салбарт гарсан байна.

Хүснэгт 7.8. Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгчид, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар, дүнд эзлэх хувь, улирлаар

Эдийн засгийн салбар	2021-I	2021-II	2021-III	2021-IV
ХАА, ойн аж ахуйн, загас барилт, ан агнуур	25.8	30.5	12.2	35.6
Уул уурхай, олборлолт	-	4.0	1.2	-
Боловсруулах үйлдвэрлэл	21.2	9.7	7.0	4.1
Барилга	-	-	6.2	-
Бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар үйлчилгээ	15.7	15.0	44.0	41.8
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	26.3	24.2	22.7	16.0
Зочид буудал, байр сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	-	-	3.7	-
Мэдээлэл, холбоо	1.6	-	-	-
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын	-	1.3	-	-
Боловсрол	4.2	4.0	1.2	-
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	3.2	11.4	0.8	2.5
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа	2.0	-	-	-
<b>Нийт</b>	<b>100</b>	<b>100</b>	<b>100</b>	<b>100</b>


Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгчид 2021 оны 1-р улиралд нийт ажиллагчдын 6.3 мянга (0.6%), 2-р улиралд 2.8 мянга (0.3%), 3-р улиралд 8.3 мянга (0.7%), 4-р улиралд 6.8 мянга (0.6%) байжээ. Байршлаар харвал нийт дүнд эзлэх хувийн улирлын хэлбэлзэл өндөр байна. Нийт дүнд эзлэх хувиар, хүйсээр харвал 2-р улиралд хот суурин газрын эрэгтэйчүүд хамгийн их 67.1 хувь байхад 3-р улиралд хөдөө, орон нутгийн эмэгтэйчүүд хамгийн их 68.3 хувь байна.

Зураг 7.9. Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгчид, байршлаар, хүйсээр, дүнд эзлэх хувиар, улирлаар



Ажилгүй хүний тоог хүйсээр нь авч үзвэл, эрэгтэйчүүд 2 дугаар улиралд өмнөх улирлаас 11.5 нэгж хувь, 3-р улиралд өмнөх улирлаас 9.3 нэгж хувь буурч, 4-р улиралд өмнөх улирлаас 16.8 нэгж хувиар өссөн бол эмэгтэйчүүд 2 дугаар улиралд өмнөх улирлаас 17.0 нэгж хувиар өсөж, 3 дугаар улиралд өмнөх улирлаас 11.2 нэгж хувиар буурч, 4 дүгээр улиралд эргэн 1.0 нэгж хувиар өсжээ.

Зураг 7.10. Ажилгүй хүн, хүйсээр, мянган хүн, улирлаар




Ажилгүй хүний ажилгүй байгаа шалтгааныг хүйсээр харвал эрэгтэйчүүдийн хувьд ажил хайгаад олдохгүй байгаа (32.9-42.7%), үүсээд байгаа цар тахлын улмаас (15.6-24.1%), мэргэжил дадлага туршлагагүй (7.1-11.7%) гэсэн шалтгаан өндөр хувь эзэлж байгаа бол эмэгтэйчүүдийн хувьд ажил хайгаад олдохгүй байгаа (37.7-49.0%), үүсээд байгаа цар тахлын улмаас (8.1-14.3%), жирэмсэн, хүүхэд асарсан (10.8-12.4%) шалтгаан давамгайлж байна. Ажил хайгаад олдохгүй байгаа гэсэн шалтгаанаар нийт ажилгүй хүний тоонд эзлэх хувь 1-р улиралд эрэгтэйчүүд 57.8 хувь, эмэгтэйчүүд 42.2 хувь байсан бол эрэгтэйчүүд 2-р улиралд 45.2 хувь болон буураад, 3-р улиралд 48.7 хувь, 4-р улиралд 53.8 хувь болон өссөн бол эмэгтэйчүүд 2-р улиралд 54.8 хувь болж өсөөд, 3-р улиралд 51.3 хувь, 4-р улиралд 46.2 хувь болон буурсан байна.

Хүснэгт 7.9. Ажилгүй иргэдийн ажилгүй байгаа шалтгаан, хүйсээр, дүнд эзлэх хувь, улирлаар

Шалтгаан	Эрэгтэй				Эмэгтэй			
	2021-I	2021-II	2021-III	2021-IV	2021-I	2021-II	2021-III	2021-IV
Суралцдаг	1.4	1.9	0.1	-	4.1	-	1.4	-
Тэтгэвэрт гарсан	1.6	2.0	3.3	0.1	1.2	-	0.5	-
Өвчтэй	0.4	-	0.8	0.4	2.3	0.8	0.5	0.4
Хөгжлийн бэрхшээлтэй	0.1	0.2	-	0.3	0.3	0.4	0.5	0.5
Жирэмсэн, хүүхэд асарсан	-	-	0.4	-	11.2	12.4	10.8	11.0
Бусдыг асарсан	-	2.6	-	2.5	1.8	2.0	3.3	3.4
Тухайн жилд цэргээс халагдсан	1.0	1.7	0.4	-	-	-	-	-
Тухайн жилд сургууль төгссөн	1.8	2.4	3.5	4.0	1.5	5.1	7.4	3.0
Хүүхдээ сургуульд сургахаар	-	-	4.0	-	1.6	0.6	6.0	1.4
Гадаадад амьдарч байгаад ирсэн	1.1	1.3	2.5	0.4	1.6	-	-	0.5
Байгууллага татан буугдсан	-	-	1.4	2.3	1.9	5.0	-	0.5
Цомхотголд орсон	1.5	1.7	4.1	2.1	1.6	0.4	0.8	0.1
Улирлын чанартай ажил хийдэг болохоор	8.9	9.4	1.4	7.8	2.3	1.4	0.2	1.4
Мэргэжил, дадлага туршлага байхгүй	11.7	7.1	8.7	10.4	7.1	4.2	5.5	11.4
Мэргэжилд тохирох ажил олдохгүй	6.5	6.8	8.4	7.9	3.5	4.2	10.5	7.5
Ажил хайгаад олдохгүй байгаа	42.7	36.9	32.9	33.9	45.1	49.0	38.7	37.7
Цалин бага учраас	2.0	4.8	1.4	8.7	0.6	-	1.2	4.4
Үүсээд байгаа цар тахлын улмаас	16.3	19.5	24.1	15.6	11.4	14.3	13.0	8.1
Бусад	3.1	1.7	2.7	3.6	0.8	0.3	-	8.9
Нийт	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0

Боломжит ажиллах хүчний бүтцийг улирлаар авч үзэхэд, ажил хайгаагүй ч хийх боломжтой хүн ам 106.1-40.8 мянга байсан нь нийт боломжит ажиллах хүчний 90.6-99.1 хувийг эзэлж байна.

Зураг 7.11. Боломжит ажиллах хүчний бүтэц, мянган хүн, улирлаар



Ажил, бизнес эрхлэх боломжтой болбол хийхийг хүсэж буй ч ажил хайгаагүй боломжит ажиллах хүчний сүүлийн 30 хоногт ажил хайгаагүй шалтгааныг улирлаар авч үзвэл, гэр бүлийн шалтгаанаар, үүсээд байгаа цар тахлын улмаас гэсэн шалтгаан нийт шалтгааны өндөр хувийг эзэлж байна. 1-р улиралд ажил хайгаад залхсан ажлын байр байхгүй гэж бодож байгаа иргэд 14.9 хувийг эзэлж байсан бол 2, 3-р улиралд 5.9-4.9 хувьд хүртэл буурч, 4-р улиралд 8.6 хувь болсон байна. Үүсээд байгаа цар тахлын улмаас гэсэн шалтгаан 1-р улиралд 24.2 хувийг эзэлж байсан бол дараагийн улирлуудад дараалан буурч 22.4-14.5 хувьд хүрч буурсан бол гэр бүлийн шалтгаанаар ажил хайгаагүй иргэдийн тоо 1-р улиралд нийт шалтгааны 18.9 хувийг эзэлж байгаад дараагийн улирлуудад 24.1-35.2 хувьд хүрч өссөн байна.

Хүснэгт 7.10. Сүүлийн 30 хоногт цалинтай ажил олох болон бизнес эрхлэх оролдлого хийхгүй байгаа шалтгаан, дүнд эзлэх хувь, улирлаар

Шалтгаан	2021-I	2021-II	2021-III	2021-IV
Өмнөх ажил хайлтын үр дүнг хүлээж байна	1.7	1.1	0.8	-
Өмнөх ажлаас утасдахыг хүлээж байгаа	2.0	1.5	4.6	1.1
Улирлаас шалтгаалаад эхлэхийг нь хүлээж байгаа	3.5	3.8	-	4.1
Ажил хайгаад залхсан ажлын байр байхгүй гэж бодож байна	14.9	5.9	4.9	8.6
Ур чадварт тохирох ажил байхгүй туршлага байхгүй	6.6	2.9	4.5	3.2
Ажил олгогчдын зүгээс хэтэрхий залуу/хөгшин байна гэж үздэг	4.3	7.9	7.1	8.4
Суралцаж байсан сургалтад хамрагдаж байгаа	8.4	11.7	5.8	8.1
Гэр бүлийн шалтгаанаар	18.9	24.1	33.8	35.2
Өрхийн хэрэгцээний ХАА-н болон загас үржүүлгийн ажилд туслахаар	3.4	9.7	8.1	-
Өвчтөн хөгжлийн бэрхшээлтэй	8.7	7.2	10.5	12.2
Бусад орлогын эх үүсвэртэй	0.2	-	-	1.0
Үүсээд байгаа цар тахлын улмаас	24.2	22.4	14.7	14.5
Бусад	3.4	1.9	5.1	3.5
Нийт	100.0	100.0	100.0	100.0

Сүүлийн 30 хоногт цалинтай ажил олох болон бизнес эрхлэх оролдлого хийгээгүй шалтгаануудыг байршлаар харьцуулан харахад, ажил олгогчдын зүгээс хэтэрхий залуу эсвэл хөгшин байна гэж үздэг, өрхийн хэрэгцээний ХАА болон загас үржүүлгийн ажилд

туслах гэсэн шалтгаануудын эзлэх хувь хөдөө орон нутагт улирлын хэлбэлзэл ихтэй. Харин хот суурин газарт гэр бүлийн шалтгаан болон үүсээд байгаа цар тахлын улмаас гэсэн шалтгаануудын эзлэх хувь улирлын хэлбэлзэл ихтэй байна.

Хүснэгт 7.11. Сүүлийн 30 хоногт цалинтай ажил олох болон бизнес эрхлэх оролдлого хийхгүй байгаа шалтгаан, байршлаар, дүнд эзлэх хувь, улирлаар

Шалтгаан	2020-I		2020-II		2020-III		2020-IV	
	Хот	Хөдөө	Хот	Хөдөө	Хот	Хөдөө	Хот	Хөдөө
Өмнөх ажил хайлтын үр дүнг хүлээж байна	1.7	1.2	1.3	0.2	0.7	1.1	0.0	0.0
Өмнөх ажлаас утасдахыг хүлээж байгаа	1.9	2.6	1.9	0.0	6.1	0.0	1.4	0.0
Улирлаас шалтгаалаад эхлэхийг нь хүлээж байгаа	3.1	6.1	4.1	2.4	0.0	0.0	3.8	5.8
Ажил хайгаад залхсан ажлын байр байхгүй гэж бодож байна	15.2	13.3	6.2	4.3	3.1	10.5	9.0	6.7
Ур чадварт тохирох ажил байхгүй туршлага байхгүй	7.1	3.9	2.6	4.1	4.2	5.5	2.0	8.5
Ажил олгогчдын зүгээс хэтэрхий залуу, хөгшин байна гэж үздэг	3.2	10.3	8.7	4.9	6.0	10.5	6.8	15.8
Суралцаж байсан сургалтад хамрагдаж байгаа	8.9	5.5	13.1	6.0	6.2	4.5	7.9	8.8
Гэр бүлийн шалтгаанаар	18.7	19.5	24.8	21.3	38.1	20.6	35.3	34.6
Өрхийн хэрэгцээний ХАА-н болон загас үржүүлгийн ажилд туслахаар	0.0	22.2	0.4	46.2	0.0	33.0	0.0	0.0
Өвчтөн хөгжлийн бэрхшээлтэй	9.2	6.2	8.2	3.1	12.4	4.7	13.6	6.3
Бусад орлогын эх үүсвэртэй	0.0	1.1	0.0	0.0	0.0	0.0	0.8	1.9
Үүсээд байгаа цар тахлын улмаас	27.9	2.3	25.1	4.7	17.3	6.6	16.7	4.7
Бусад	3.1	5.8	3.5	2.8	5.8	2.9	2.8	6.9
Нийт	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0

Судалгааны улирлаарх үр дүнг харахад хөдөлмөр эрхлээгүй шалтгааны хувьд системтэй өөрчлөлт бага ажиглагдаж байна. Ерөнхийдөө ажилгүй хүн болон боломжит ажиллах хүчний хувьд ажлаас халагдсан хүмүүсийн тоо 3-р улиралд хамгийн бага байгаа нь хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн улирлын хандлагатай нийцэж байна. Нийт хөдөлмөр эрхлээгүй хүн амыг авч үзвэл өөрийн хүслээр ажлаас гарсан тохиолдол жилийн туршид тодорхой хэмжээгээр гарч байсан нь зарим талаараа ажилгүй хүн болон боломжит ажиллах хүчинд хамрагдаж байгаа хүмүүсийн хөдөлгөөнөөс үүдэлтэй байна. Урьд нь ажил хийж байсан туршлагагүй, хөдөлмөрийн зах зээлд анх орж ирж буй хүмүүсийн хувийн жин 1-р улиралд харьцангуй өндөр байгаа бөгөөд цаг хугацаа өнгөрөхийн хэрээр бага зэрэг буурч байна. Энд нэг анхаарах асуулт гарч ирж байна. Хөдөлмөрийн зах зээлд анх хөл тавьж буй хүмүүс хаачих вэ? Тэд ажил олж чадах уу, эсвэл итгэл алдарч ажил хайхаа зогсоох уу? Нэгдсэн түвшний тоо мэдээлэлд суурилсан дүн шинжилгээгээр хувь хүний түвшинд тохирох хариулт өгөх боломжгүй. Хөдөлмөрийн зах зээлийн төлөвүүд хоорондын өөрчлөлт хөдөлгөөнийг илүү сайн ойлгохын тулд илүү нарийвчилсан тоо мэдээлэл шаардлагатай. Энэ тайлангийн 3-р бүлэгт энэ талаар илүү дэлгэрэнгүй авч үзсэн.

## VIII. ЭДИЙН ЗАСГИЙН БУС ҮЙЛ АЖИЛЛАГАА

Өөрийн хэрэгцээний бүтээгдэхүүн  
үйлдвэрлэгч, хүйс, дүнд эзлэх хувиар



- Ажиллагч
- Ажилгүй хүн
- Ажиллах хүчнээс гадуур хүн ам

Ажиллах хүчний судалгааны асуулгад 2019 оноос эхлэн хүн амын эдийн засгийн бус үйл ажиллагаанд хэчнээн цагийг зарцуулсан эсэхийг хэмжих үүднээс өрхийн гишүүдийн өөрийн хэрэгцээний үйлдвэрлэл болон өрхийн гишүүдийн цалин хөлсгүй ажил, үйлчилгээнд зарцуулсан цагийг асуусан асуултыг нэмэлт бүлэг болгон оруулсан болно.

### 8.1. ӨӨРИЙН ХЭРЭГЦЭЭНИЙ БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭГЧ

Судалгааны дүнгээр 15 ба түүнээс дээш хүн амын 1122.9 (52.2%) мянга нь өөрийн хэрэгцээний бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн үйл ажиллагаануудын аль алиныг эсвэл аль нэгийг нь эрхэлсэн байна.


Хүснэгт 8.1 Өөрийн хэрэгцээний бүтээгдэхүүн үйлдвэрлэл эрхэлсэн хүн ам, үйл ажиллагааны төрлөөр, давхардсан дүнгээр, хүйсээр, 7 хоногийн дундаж цагаар

Үйлдвэрлэл	Нийт			Эрэгтэй			Эмэгтэй		
	Хүний тоо	Хувь	Дундаж цаг	Хүний тоо	Хувь	Дундаж цаг	Хүний тоо	Хувь	Дундаж цаг
Өрхийн хэрэгцээний газар тариалан, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл	42 826	2.1	51	22 813	2.0	54	20 013	2.4	47
Өрхийн хэрэгцээний хоол хүнс бэлтгэн, хадгалах үйл ажиллагаа	136 330	6.8	4	54 005	4.7	3	82 325	9.7	4
Өрхийн хэрэгцээний ус зөөх, авах үйл ажиллагаа	853 488	42.7	2	535 114	46.3	2	318 374	37.6	2
Өрхийн хэрэгцээний түлээ, түлш бэлтгэх үйл ажиллагаа	772 366	38.6	3	443 631	38.4	3	328 735	38.9	3
Өөрийн хэрэгцээний бусад бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн үйл ажиллагаа	154 569	7.7	3	71 940	6.2	3	82 628	9.8	4
Өөрийн хэрэгцээний орон сууц, байшин барих, засварлах үйл ажиллагаа	41 548	2.1	5	27 811	2.4	6	13 737	1.6	5
Дүн		100.0			100.0			100.0	

### ӨРХИЙН ХЭРЭГЦЭЭНИЙ ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭГЧ

Өөрийн хэрэгцээний хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгч буюу өөрийн хэрэгцээний газар тариалан, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эсвэл өрхийн хэрэгцээний хоол хүнс бэлтгэн, хадгалах үйл ажиллагаа эрхлэгчид давхардаагүй дүнгээрээ 170.0 мянган хүн байгаагийн 115.7 (68.0%) мянга нь ажиллагч, 45.7 (26.9%) мянга нь ажиллах хүчнээс гадуурх хүн ам, 8.6 (5.1%) мянга нь ажилгүй хүн байна.


Зураг 8.1. Өөрийн хэрэгцээний хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгч, хүйс, дүнд эзлэх хувиар






Өөрийн хэрэгцээний хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгчээс 42.8 мянга нь газар тариалан, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхэлсэн байна. Эдгээр хүмүүсийн 53.3% нь эрэгтэйчүүд, 47.7% эмэгтэйчүүд байна. Насны бүлгээр авч үзэхэд 30-54 насны 27.5 (64.5%) мянган хүн байна.

Зураг 8.2 Өрхийн хэрэгцээний газар тариалан, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчид насны бүлэг, хүйс, мянган хүнээр



Өрхийн хэрэгцээний газар тариалан, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийг бүсээр нь авч үзвэл Хангайн бүсэд хамгийн их буюу 31.0 (72.4%) мянган хүн байна. Харин Улаанбаатарт хамгийн бага буюу 0.2 (0.5%) мянган хүн байна.

Зураг 8.3. Өрхийн хэрэгцээний газар тариалан, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчид, бүс, хүйс, нийт дүнд эзлэх хувиар




Хүснэгт 8.2. Өрхийн хэрэгцээний газар тариалан, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд зарцуулсан цаг, насны бүлэг, бүс, хүйсээр

Насны бүлэг	7 хоногт зарцуулсан дундаж цаг		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Бүгд	51	54	47
15-19	51	52	46
20-24	51	53	48
25-29	52	56	47
30-34	52	55	48
35-39	52	57	48
40-44	50	54	45
45-49	49	54	44
50-54	52	52	52
55-59	53	58	42
60-64	48	52	46
65+	40	37	44

Өрхийн хэрэгцээний газар тариалан, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд зарцуулсан цагийг насны бүлгээр авч үзэхэд 35-39, 50-59 насныхан хамгийн их буюу 52 цаг, 65-с дээш насныхан хамгийн бага буюу 38 цагийг зарцуулдаг байна. Хүйсээр авч үзэхэд, уг үйл ажиллагааг эрхэлсэн эрэгтэйчүүд 7 хоногт дунджаар 54 цаг, эмэгтэйчүүд 47 цаг зарцуулсан байна.


Өрхийн хэрэгцээний хоол хүнс бэлтгэн, хадгалах үйл ажиллагаанд 136.3 мянган хүн оролцсоны 50.4 (36.9%) мянга нь Улаанбаатарт оршин суудаг, мөн 82.3 (60.4%) мянга нь эмэгтэйчүүд байна.

Зураг 8.4. Өрхийн хэрэгцээний хоол хүнс бэлтгэн, хадгалах үйл ажиллагаа эрхлэгчид, бүс, хүйс, нийт дүнд эзлэх хувиар



Өрхийн хэрэгцээний хоол хүнс бэлтгэн, хадгалах үйл ажиллагаанд оролцогчдыг насны бүлгээр авч үзвэл 25-49 насны 78.8 (57.8%) мянган хүн байна. Үүнээс 47.9 (60.8%) мянга нь эмэгтэйчүүд байна.

Зураг 8.5. Өрхийн хэрэгцээний хоол хүнс бэлтгэн, хадгалах үйл ажиллагаа эрхлэгчид, насны бүлэг, хүйс, мянган хүнээр



Өрхийн хэрэгцээний хоол хүнс бэлтгэн, хадгалах үйл ажиллагааг зарцуулсан цагаар нь авч үзэхэд Хангай болон Төвийн бүст хамгийн их буюу 5.3-5.5 цаг зарцуулсан байна. Насны бүлгийн хувьд 30-44 насныхан хамгийн их буюу 3.9 цаг, 20-24 насныхан хамгийн бага буюу 2.9 цаг зарцуулжээ.

Хүснэгт 8.3. Өрхийн хэрэгцээний хоол хүнс бэлтгэн, хадгалах үйл ажиллагаанд зарцуулсан цаг насны бүлэг, бүс, хүйсээр


Насны бүлэг	7 хоногт зарцуулсан дундаж цаг		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Бүгд	4	3	4
15-19	3	4	3
20-24	3	2	3
25-29	4	3	4
30-34	4	4	4
35-39	4	4	4
40-44	4	3	4
45-49	3	3	4
50-54	4	3	4
55-59	4	3	4
60-64	4	4	4
65+	4	3	4

### ӨРХИЙН ХЭРЭГЦЭЭНИЙ БУСАД БАРАА БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭГЧ

Өрхийн хэрэгцээний ус зөөх үйл ажиллагаанд 853.5 мянган хүн оролцсоны 535.1 (62.7%) мянга нь эрэгтэйчүүд байна. Түлээ түлш бэлтгэх үйл ажиллагаанд 772.4 мянган хүн оролцсоны 443.6 (57.4%) мянга нь эрэгтэйчүүд байна. Орон сууц, байшин барих, засварлах үйл ажиллагаанд 41.6 мянган хүн оролцсоны 27.8 (66.9%) мянга нь эрэгтэйчүүд байна. Бусад

бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэлд 154.6 мянган хүн оролцсоны 82.6 (53.5%) нь эмэгтэйчүүд байна. Эдгээр үйл ажиллагаанд 7 хоногт зарцуулсан дундаж цагийн хувьд, ус зөөх, авах үйл ажиллагаанд 2 цаг (хүйсийн хувьд ялгаагүй), түлээ, түлш бэлтгэх үйл ажиллагаанд 3 цаг (хүйсийн хувьд ялгаагүй), орон сууц, байшин барих, засварлах үйл ажиллагаанд 5 цаг (эрэгтэйчүүд 6, эмэгтэйчүүд 5), бусад бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд 3 цаг (эрэгтэйчүүд 3, эмэгтэйчүүд 4) зарцуулсан байна.

Зураг 8.6. Өрхийн хэрэгцээний бусад бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэл үйл ажиллагаа эрхлэгчид, хүйсээр, нийт дүнд эзлэх хувиар



## 8.2. ӨРХИЙН ГИШҮҮДИЙН ЦАЛИН ХӨЛСГҮЙ АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭНД ЗАРЦУУЛСАН ЦАГ

Хөдөлмөрийн насны хүн амын 1.8 сая нь гэр цэвэрлэх, хувцас угаах, тухайн өдрийн үндсэн хоол хийх, өрхийн хэрэгцээт зүйлсийг худалдаж авах, дэлгүүр явах үйл ажиллагаанд оролцож, 7 хоногт дунджаар 8 цаг зарцуулсан байна.

Зураг 8.7. Хөдөлмөрийн насны хүн амын цалин хөлсгүй ажил, дундаж цаг, хүйс, байршлаар





## IX. ЖИЛИЙН ХАРЬЦУУЛАЛТ

Үндэсний Статистикийн хороо нь олон улсын нийтлэг жишиг аргачлалын дагуу 2006 оноос эхлэн “Ажиллах хүчний түүвэр судалгаа” (АХС) -г улирлаар явуулж байна.

Энэхүү судалгааны зорилго нь хөдөлмөрийн зах зээлийн хэмжээ, бүтэц, тэдгээрт гарч буй өөрчлөлтийг тухайн хугацаа буюу сүүлийн 7 хоногоор тодорхойлж, дүн шинжилгээ хийх тоон мэдээллийн багцыг бий болгоход оршино.

Судалгааг 2006-2018 онуудад Олон улсын хөдөлмөрийн статистикчдын 1982 оны 13-р бага хурлын тогтоолын дагуу боловсруулагдсан Монгол Улсын хөдөлмөрийн статистикийн аргачлал, арга зүйн дагуу явуулж байсан. Харин 2019 оноос эхлэн шинэ аргачлал, ойлголт тодорхойлолтын дагуу явуулж байна. Олон улсын хөдөлмөрийн статистикчдын 2013 онд болсон 19-р бага хурлаар 1982 оны 13-р бага хурлаас баталсан аргачлал нь хөдөлмөрийн зах зээлийн бодит дүр зургийг төдийлөн илэрхийлж чадахгүй, хөдөлмөр эрхлэлтийн бодлогыг тодорхойлоход дутагдалтай байгааг онцолж, аргачлалыг шинэчлэх шийдвэр гаргасан юм. Тухайлбал, ажилгүйдлийн түвшин дангаараа ажиллах хүчний дутуу ашиглалтыг бүрэн харуулж чадахгүй байгаа тул ихэнх орнуудын ажиллах хүч, ажилгүйдлийн түвшнийг тооцоход ашиглаж байгаа эдийн засгийн идэвхтэй хүн ам, хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдэл, бүрэн бус ажил эрхлэлтийн үзүүлэлтүүдийг тооцох аргачлалыг шинэчлэхийг чухалчилсан.

Маш хурдацтай өөрчлөгдөж буй хөдөлмөрийн зах зээлийн нөхцөл байдлыг бодитоор харуулахын тулд бид олон улсын шинэ аргачлалыг өөрийн орны онцлогт тусган нэвтрүүлж, Үндэсний Статистикийн хорооны дарга, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2019 оны А-09/08 тоот хамтарсан тушаалаар “Хөдөлмөр эрхлэлтийн статистикийн үзүүлэлтийг тооцох шинэчилсэн аргачлал”-ыг батлан 2019 оны 1 дүгээр сараас эхлэн мөрдөж байна. Хөдөлмөрийн статистикийн аргачлалыг шинэчилснээр хөдөлмөрийн зах зээлийн нөхцөл байдлын талаарх илүү нарийвчилсан мэдээлэл, түүнчлэн хөдөлмөрийн дутуу ашиглалтыг бүрэн харуулах статистикийн үзүүлэлтийг шинээр бий болгож, бодлого боловсруулагчдыг зохих мэдээллээр хангах юм.

Энэхүү бүлэгт Ажиллах хүчний 2019-2021 оны судалгааны үр дүнг улсын түвшинд харьцуулан, танилцуулав.

### 9.1. ХӨДӨЛМӨРИЙН НАСНЫ ХҮН АМ

Улс орны ажиллах хүчний бүтэц, тэдгээрт гарч буй өөрчлөлт нь хүн ам зүйн өөрчлөлттэй нягт уялдаатай бөгөөд уг өөрчлөлтийг дэлгэрэнгүй судлах нь улс орны нийгэм, эдийн засаг ялангуяа ажиллах хүчний бодлого боловсруулахад суурь мэдээлэл болдог. Иймд энэхүү бүлгийн эхэнд хөдөлмөрийн насны хүн ам болон хүн ам зүйн талаар авч үзлээ.

Монгол Улсын Хөдөлмөрийн тухай, Төрийн албаны тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тэтгэмжийн тухай хууль тогтоомжоор “ажилтан 60 нас хүрч өндөр насны тэтгэвэр авах эрх үүсэх” бөгөөд “эмэгтэй ажилтан өөрөө хүсвэл 55 наснаас өндөр насны тэтгэвэр авч болно” гэж заасан. Мөн Хөдөлмөрийн тухай хуульд “тэтгэвэр авагч ахмад настан хөдөлмөр эрхэлж болно” гэж заасан. Гэхдээ олон улсын хөдөлмөрийн статистикийн ойлголтын дагуу, олон улсын түвшинд харьцуулахуйц байдлыг хангах үүднээс хөдөлмөрийн насыг 15 ба түүнээс дээш насаар авч байна.


2021 оны эцэст Монгол Улсын суурин хүн амын 2.2 сая (67.3%) нь хөдөлмөрийн насны буюу 15 ба түүнээс дээш насны хүн ам байгаа нь өмнөх оноос 32.9 мянган хүнээр нэмэгдсэн байна. Хэдийгээр сүүлийн жилүүдэд хөдөлмөрийн насны хүн ам өссөн ч бүтцийн хувьд томоохон өөрчлөлтүүд ажиглагдаж байна. Жишээлбэл, ерөнхий ажиллах хүчний бүлэг

болох 25-54 насны хүн амын нийт хөдөлмөрийн насны хүн амд эзлэх хувийн жин 2021 онд өмнөх оноос 0.3 нэгж хувиар буурч, тэтгэвэрт гарах насныхан болон өндөр настнуудын эзлэх хувь 0.6 нэгж хувиар өссөн байна.

Хүн амын насны бүтцийн өөрчлөлтийг илүү харуулж чадах үзүүлэлт бол хүн ам зүйн ачаалал. Хүн ам зүйн ачаалал нь 15-64 насны 100 хүнд ногдох тэжээлгэгчийн тоо (15-аас доош, 65 ба түүнээс дээш насны хүн ам) буюу хүүхэд, хөгшдийн нийгэмд үзүүлж буй ачааллыг хүн амын насны бүлгийн бүтцээр илэрхийлнэ. Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуульд ажилтан 60 нас хүрч өндөр насны тэтгэвэр авах эрх үүснэ гэж заасан хэдий ч олон улсын түвшинд харьцуулахуйц байдлыг хангах үүднээс хүүхдэд 0-14, өндөр настанд 65 ба түүнээс дээш настай хүн амыг хамруулж хүн ам зүйн ачааллыг тооцсон.

Манай улсын хувьд хүн ам зүйн ачаалал 2021 онд 59.5 болж өмнөх оноос 0.9 нэгж хувиар өссөн байна. Өөрөөр хэлбэл, хөдөлмөрийн насны 5 хүн тутамд хөдөлмөрийн бус насны 3 хүн ногдож байна. Мөн 0-14 насны хүүхдийн ачаалал 2021 онд 52.2 болж өмнөх оноос 0.6 нэгж хувиар, 65-аас дээш насны хөгшдийнх 7.3 болж 0.3 нэгж хувиар нэмэгдсэн нь нийт хүн амд 15-64 насны хүн амын эзлэх хувийн жин буурч, хүүхэд, хөгшдийн эзлэх хувийн жин өссөнийг илэрхийлж байна.

Зураг 9.1. Хүн ам зүйн ачаалал, хувиар



Монгол Улсын 0-14 насны хүүхдийн тоо 1990-2006 онд дунджаар 1.1 хувиар бууралттай байсан бол 2007 оноос эхлэн аажмаар нэмэгдэж дунджаар 2.7 хувийн өсөлттэй байна. Үүнээс шалтгаалан 2021 онд хөдөлмөрийн зах зээлд шинээр орж ирж байгаа 15-24 насны залуучууд өмнөх оноос 1.6 (0.4%) мянгаар өссөн байна.

Хүснэгт 9.1. Монгол Улсын хөдөлмөрийн насны хүн ам, оны эцэст


Насны бүлэг	2020 оны эцэст	2021 оны эцэст	Зөрүү	
			Тоо	%
Бүгд	2 194 799	2 227 674	32 875	1.5
15-24	436 921	438 525	1 604	0.4
25-54	1 367 052	1 379 882	12 830	0.9
55-59	142 018	147 936	5 918	4.2
60+	248 808	261 331	12 523	5.0

Эх үүсвэр: Хүн амын статистик, <https://beta.1212.mn/>

15 ба түүнээс дээш насны хүн амыг хөдөлмөрийн зах зээл дэх оролцооных нь хувьд ажиллах хүч (ажиллагчид болон ажилгүй хүн), ажиллах хүчнээс гадуурх (боломжит ажиллах хүч болон өргөтгөсөн ажиллах хүчнээс гадуурх хүн ам) хүн ам гэж ангилна.

Зураг 9.2. 15, түүнээс дээш насны хүн амын хөдөлмөрийн зах зээл дэх оролцоо, сүүлийн 3 жилээр

Ажиллах хүчний 2021 оны судалгааны үр дүнгээр Монгол Улсын 15 ба түүнээс дээш насны хүн амын 56.9 хувь нь ажиллах хүчин байгаа нь 2019 оноос 3.6 нэгж хувиар, 2020 оноос 1.9 нэгж хувиар буурсан байна.



9.2. 15, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛ ДЭХ ОРОЛЦОО

Судалгааны үр дүнгээр 2021 онд ажиллах хүчин 1225.4 мянга болж өмнөх оныхоос 2.0 нэгж хувиар буурахад ажиллагчдын тооны бууралт нөлөөлжээ. 2019 онтой харьцуулахад ажиллах хүч 48.5 мянга буюу 3.8 нэгж хувиар буурсан байна.

Хүснэгт 9.2. Хөдөлмөрийн үндсэн үзүүлэлтүүд, сүүлийн 3 жилээр

Үзүүлэлтүүд	2019	2020	2021	$\frac{2021}{2019}$ %	$\frac{2021}{2020}$ %
Ажиллах хүч, мянган хүн	1273.9	1250.6	1225.4	96.2	98.0
Ажиллагчид, мянган хүн	1146.2	1162.9	1125.6	98.2	96.8
ЦХХББХЭ, мянган хүн	15.1	5.2	6.1	40.4	118.2
Ажилгүй хүн, мянган хүн	127.7	87.7	99.8	78.1	113.8
Ажиллах хүчнээс гадуурх хүн ам, мянган хүн	832.2	877.5	926.8	111.4	105.6
Боломжит ажиллах хүч	58.8	70.7	71.4	121.4	101.0
Бусад ажиллах хүчнээс гадуурх хүн ам	773.4	806.8	855.4	110.6	106.0
Ажиллах хүчний оролцооны түвшин, %	60.5	58.8	56.9	-3.6	-1.9
Хөдөлмөр эрхлэлтийн түвшин, %	54.4	54.6	52.3	-2.1	-2.3
Хөдөлмөрийн дутуу ашиглалтын нийлмэл түвшин, %	15.1	12.4	13.7	-1.4	1.3
Ажилгүйдлийн түвшин, %	10.0	7.0	8.1	-1.9	1.1
ЦХХББХЭ болон ажилгүйдлийн нэгдсэн түвшин, %	11.2	7.4	8.6	-2.6	1.2
Ажилгүй хүн болон БАХ-ний нэгдсэн түвшин, %	14.0	12.0	13.2	-0.8	1.2


Тайлбар: ЦХХББХЭ – Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгч.

Хүйсээр ажиллах хүчний оролцооны түвшний хувьд, эрэгтэйчүүдийнх 2021 онд 65.2 хувь болж, 2020 оныхоос 1.6 нэгж хувиар, 2019 оныхоос 3.1 нэгж хувиар буурсан бол эмэгтэйчүүдийнх өмнөх оныхоос 1.9 нэгж хувиар, 2019 оныхоос 3.5 нэгж хувиар буурч 49.9 хувь болжээ. Уг бууралтад ажиллах хүчнээс гадуурх хүн амын тоо нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.

Судалгааны сүүлийн гурван жилийн үр дүнгээс харахад эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин дунджаар 15.1 нэгж хувиар зөрүүтэй байна.




Зураг 9.3. Ажиллах хүчний оролцооны түвшин, хүйсээр, хувиар, сүүлийн 3 жилээр



2021 оны ажиллах хүчний оролцооны түвшнийг насны бүлгээр 2019 онтой харьцуулахад бүх насны бүлэгт буурсан байна. Тухайлбал, 20-24 насны хүн амынх хамгийн их буюу 11.3 нэгж хувиар, 40-49, 55-64 насны хүн амынх 4.4-4.7 нэгж хувиар, 15-19, 25-39, 50-54 насны хүн амынх 1.3-2.8 нэгж хувиар, хамгийн бага нь 65 ба түүнээ дээш насны хүн амынх 0.9 нэгж хувиар тус тус буурсан байна. Харин 2020 онтой харьцуулахад 30-44 насны хүн амын ажиллах хүчний оролцооны түвшин 0.4-1.1 нэгж хувиар өссөн бол 20-24 насных 7.6 нэгж хувиар, 25-29, 45-49 насных 2.2-2.7 нэгж хувиар, 15-19, 55-64 насных 1.0-1.9 нэгж хувиар, 50-54, 65 ба түүнээс дээш насных 0.2-0.7 нэгж хувиар тус тус буурсан байна.

Зураг 9.4. Ажиллах хүчний оролцооны түвшин, насны бүлгээр, хувиар, сүүлийн 3 жилээр



Ажиллах хүчний 2019-2020 оны судалгааны үр дүнгээс харахад, ажиллах хүчний оролцооны түвшин нь боловсролын түвшингээс эерэг хамааралтай болох нь ажиглагдаж байгаа ч 2021 онд боловсролгүй болон бага боловсролтой хүн амын ажиллах хүчний оролцооны түвшин өссөн байгаа нь анхаарал татаж байна. 2021 оны байдлаар магистр ба түүнээс дээш боловсролтой иргэдийн хувьд ажиллах хүчний оролцооны түвшин хамгийн өндөр буюу 79.6 хувьтай байна.

Хүснэгт 9.3. Боловсролын түвшин дэх ажиллах хүчний оролцооны түвшин, хувиар, сүүлийн 3 жилээр

Боловсролын түвшин	2019	2020	2021	$\frac{2021}{2019}$	$\frac{2021}{2020}$
Боловсролгүй	55.7	48.8	63.4	7.7	14.7
Бага	49.7	55.4	56.5	6.7	1.1
Суурь	45.7	43.3	42.3	-3.4	-1.0
Бүрэн дунд	53.4	53.3	47.2	-6.2	-6.1
Техникийн болон мэргэжлийн	66.9	64.1	59.6	-7.3	-4.5
Тусгай мэргэжлийн дунд	54.9	53.1	48.0	-7.0	-5.2
Дипломын дээд болон бакалавр	71.0	71.3	69.3	-1.7	-2.0
Магистр ба түүнээс дээш	80.1	80.5	79.6	-0.6	-0.9
Улсын дүн	60.5	58.8	56.9	-3.5	-1.8

Ажиллах хүчний оролцооны түвшнийг гэрлэлтийн байдлаар авч үзэхэд огт гэрлээгүй хүн амынх 2019 оныхоос 18.0 нэгж хувиар, 2020 оныхоос 16.8 нэгж хувиар буурсан нь хамгийн их өөрчлөлттэй байна. Мөн 2019 онтой харьцуулахад, бэлэвсэн, 2020 онтой харьцуулахад бэлэвсэн болон гэрлэлтээ батлуулсан хүн амын ажиллах хүчний оролцоотой түвшин 0.4-0.8 нэгж хувийн өсөлттэй байна.

Хүснэгт 9.4. Гэрлэлтийн байдлаар ажиллах хүчний оролцооны түвшин, хувиар, сүүлийн 3 жилээр

Гэрлэлтийн байдал	2019	2020	2021	<u>2021</u> 2019	<u>2021</u> 2020
Огт гэрлээгүй	56.8	55.6	38.8	-18.0	-16.8
Гэрлэсэн- Батлуулсан	71.6	69.1	67.4	-4.2	-1.7
Гэрлэсэн- Батлуулаагүй	71.6	67.9	68.4	-3.2	0.5
Тусгаарласан	72.2	74.1	68.4	-3.8	-5.7
Цуцалсан	73.4	71.9	65.9	-7.5	-6.0
Бэлэвсэн	26.6	26.2	27.0	0.4	0.8
Улсын дүн	60.5	58.8	56.9	-3.5	-1.8

Ажиллах хүчний оролцоо нь эдийн засаг, нийгэмд чухал ач холбогдолтой бөгөөд ажиллах хүчний оролцооны хэв маяг нь хүн ам зүй, нийгмийн өөрчлөлттэй нягт холбоотой байдаг тул хүн амын идэвхгүй байдлын түвшнийг судаллаа. Өөрөөр хэлбэл, хөдөлмөр эрхэлдэггүй, ажил хайгаагүй, хийхэд бэлэн биш хүн ам буюу ажиллах хүчнээс гадуурх хүн ам нь хөдөлмөрийн нийлүүлэлтийг онол, тооны хувьд бүрдүүлдэггүй. Тиймээс ажиллах хүчин дэх хүмүүсийн оролцоо нь эдийн засгийн өсөлтийн гол түлхүүр бөгөөд ажиллах хүчний оролцооны чиг хандлага, хэв маягийг хянаж, ойлгох, идэвхгүй байдлын түвшин, ажиллах хүчнээс гадуурх хүн амын бүтэц, шалтгааныг судлах нь зүйтэй.


Хөдөлмөрийн насны хүн амд ажиллах хүчнээс гадуурх хүн амын эзлэх хувь буюу хөдөлмөрийн насны хүн амын идэвхгүй байдлын түвшин 2021 онд 43.1 хувь байгаа нь 2019 оноос 3.5 нэгж хувиар, 2020 оноос 1.8 нэгж хувиар тус тус өссөн байна. Уг өсөлтийг насны бүлгээр авч үзэхэд, 20-24 насны бүлэгт өндөр өсөлттэй байна. Мөн 2021 онд өмнөх онтой харьцуулахад, 30-34, 40-44 насны бүлэгт идэхгүй байдлын түвшин буурсан үзүүлэлттэй байна.

Хүснэгт 9.5. Идэвхгүй байдлын түвшин, байршил, насны бүлгээр, хувиар, сүүлийн 3 жилээр

Байршил, насны бүлэг	2019	2020	2021	<u>2021</u> 2019	<u>2021</u> 2020
Улсын дүн	39.5	41.2	43.1	3.5	1.8
Хот	43.2	44.6	46.9	3.6	2.3
Хөдөө	29.0	31.7	32.7	3.6	1.0
15-19	88.5	88.0	89.9	1.4	1.9
20-24	42.8	46.5	54.1	11.4	7.6
25-29	23.7	22.8	25.0	1.4	2.3
30-34	20.0	23.4	22.4	2.4	-1.0
35-39	16.9	20.1	19.7	2.8	-0.5
40-44	15.2	20.7	19.6	4.4	-1.0
45-49	17.7	19.5	22.2	4.5	2.7
50-54	26.0	27.1	27.3	1.3	0.2
55-59	50.6	53.3	55.1	4.4	1.8
60-64	73.8	77.5	78.5	4.7	1.1
65+	89.4	89.6	90.3	0.9	0.6

Ихэвчлэн ажиллах хүчнээс гадуурх хүмүүст оюутнууд, цалингүй дадлагажигч, өөрийн хэрэгцээний үйлдвэрлэлийн ажил, сайн дурын ажил эрхэлдэг хүмүүс, тэтгэвэрт гарсан хүмүүс багтдаг. Харамсалтай нь манайд ажиллах хүчнээс гадуурх хүмүүсийг хувийн хэрэгцээний үйлдвэрлэл, сайн дурын болон цалингүй дадлагажигч ажилд татан оролцуулах талаар судлах хангалттай мэдээлэл байхгүй байна. Гэхдээ бидэнд ажиллах хүчнээс гадуурх хүн амын бүтцийг боломжит ажиллах хүч, өргөтгөсөн ажиллах хүч гэж салган судлах, тэдгээр бүлгийн гол шинж чанаруудын талаарх мэдээлэл бий. Боломжит ажиллах хүчний шинж чанарыг судалж, ажил хайхад тулгарч буй бэрхшээлийг илрүүлдэг тул энэ талаар хөдөлмөрийн дутуу ашиглалтын хэсэгт дэлгэрэнгүй авч үзсэн.

Зураг 9.5. Ажиллах хүчнээс гадуурх хүн ам, бүтэц, дүнд эзлэх хувиар, сүүлийн 3 жилээр



Нийт ажиллах хүчнээс гадуурх хүн амын ихэнх хувь буюу 36.7 хувийг өндөр настан, тэтгэвэрт гарсан хүн ам, 26.5 хувийг суралцагсад, 12.2 хувийг жирэмсэн эхчүүд, хүүхдээ асарч байгаа эцэг, эхчүүд эзэлж байна. Харин цар тахлын улмаас идэвхгүй байгаа хүн ам 26.8 мянга буюу 2.9 хувийг эзэлж байна. Өмнөх онтой харьцуулахад, өндөр настан, тэтгэвэрт гарсан хүн амын эзлэх хувь 2.0 нэгж хувиар, суралцагсдынх 0.1 нэгж хувиар, цар тахлын улмаас шалтгаалан идэвхгүй байгаа хүн ам 2.2 нэгж хувиар өссөн байна.

Зураг 9.6. Ажиллах хүчнээс гадуурх хүн ам, шалтгаанаар, дүнд эзлэх хувиар, сүүлийн 2 жилээр



Тайлбар: Бүлэг 2-т ажиллах хүчнээс гадуурх хүн амын бүтэц тус бүрийн хувьд шалтгаанаар нь харуулсан.

### 9.3. АЖИЛЛАГЧИД

Ажиллагчид өмнөх онтой харьцуулахад 3.2 нэгж хувиар буурч, 1125.6 мянгад хүрчээ. Уг бууралт хүйсийн хувьд адил байгаа бол байршлын хувьд ялгаатай байдал ажиглагдаж байна. Тухайлбал, хот, суурин газарт ажиллагчид 5.9 хувиар буурсан бол хөдөөд 2.8 хувиар өссөн байна.

Ажиллагчдын эрхэлсэн эдийн засгийн үйл ажиллагааны салбарын хувьд, хөдөө аж ахуйн салбар 5.5 хувиар, барилга аж үйлдвэрийн салбар 3.2 хувиар өссөн бол үйлчилгээний салбар 9.3 хувиар буурсан байна.

Хөдөлмөр эрхлэлтийн статусын хувьд, цалин хөлстэй дагалдан ажилтан, мэргэшиж буй дадлагажигч ажилтан, дагалдан дадлагажигч 2020 оноос 17.4 дахин өсөж 4.7 мянгад хүрсэн нь 2019 оноос 2 дахин өссөн байна. Зураг 9.8-д нийт ажиллагчдыг хөдөлмөр эрхлэлтийн статусаар, дүнд эзлэх хувийн жингээр, өмнөх онтой харьцуулан харуулав.


Хүснэгт 9.6. 15, түүнээс дээш насны ажиллагчид, хөдөлмөр эрхлэлтийн үзүүлэлтээр, сүүлийн 3 жилээр

	2019	2020	2021	$\frac{2021}{2019}$	%	$\frac{2021}{2020}$	%
Бүгд	1 146 160	1 162 912	1 125 591	98.2		96.8	
Эрэгтэй	606 814	611 807	592 805	97.7		96.9	
Эмэгтэй	539 346	551 105	532 786	98.8		96.7	
Хот	774 968	805 385	758 227	97.8		94.1	
Хөдөө	371 192	357 527	367 364	99.0		102.8	
Эдийн засгийн үйл ажиллагааны үндсэн салбараар:							
Хөдөө аж ахуй	290 160	276 455	291 678	100.5		105.5	
Аж үйлдвэр, барилга	247 282	241 270	248 988	100.7		103.2	
Үйлчилгээ	608 718	645 187	584 925	96.1		90.7	
Хөдөлмөр эрхлэлтийн статусаар:							
Аж ахуйн нэгж, байгууллагын ажил олгогч	14 155	14 416	21 093	149.0		146.3	
Зах зээлд чиглэсэн өрхийн аж ахуйн нэгжийн ажил олгогч	21 982	18 424	20 714	94.2		112.4	
Цалин хөлстэй ажиллагчгүй аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаа эрхлэгч	15 966	16 664	10 510	65.8		63.1	
Цалин хөлстэй ажиллагчгүй, зах зээлд чиглэсэн өрхийн аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгч	359 209	384 779	381 181	106.1		99.1	
Гүйцэтгэх гэрээлэгч	14 147	1 396	2 961	20.9		2.1*	
Цалин хөлстэй байнгын ажиллагч	307 592	317 301	362 540	117.9		114.3	
Цалин хөлстэй түр ажиллагч	292 662	317 124	267 894	91.5		84.5	
Цалин хөлстэй тохиолдлын ажиллагч	76 983	58 334	32 000	41.6		54.9	
Цалин хөлстэй дагалдан ажилтан, мэргэшиж буй дадлагажигч ажилтан, дагалдан дадлагажигч	2 476	272	4 723	190.8		17.4*	
Хувь нэмрээ оруулагч гэр бүлийн гишүүн	36 259	30 770	16 912	46.6		55.0	
Эдгээр статуст хамрагдаагүй ажиллагчид	4 729	3 432	5 063	107.1		147.5	

Тайлбар: \* - Дахин.


2021 оны байдлаар хөдөө аж ахуйн салбарт ажиллагчдын эзлэх хувь 2020 оныхоос 2.1 нэгж хувиар, 2019 оныхоос 0.6 нэгж хувиар, аж үйлдвэр, барилгын салбарт ажиллагчдын эзлэх хувь 2020 оныхоос 1.4 нэгж хувиар, 2019 оныхоос 0.5 нэгж хувиар тус тус өссөн бол үйлчилгээний салбарт ажиллагчдын эзлэх хувь 2020 оныхоос 3.5 нэгж хувиар, 2019 оныхоос 1.1 нэгж хувиар буурсан байна.

Зураг 9.7. Ажиллагчдын эрхэлж буй эдийн засгийн үйл ажиллагааны салбарын бүтэц, дүнд эзлэх хувиар, сүүлийн 3 жилээр




Ажиллах хүчний сүүлийн хоёр оны судалгааны дүнг харьцуулж үзэхэд 2021 оны байдлаар нийт ажиллагчдын дотор цалин хөлстэй байнгын ажиллагч 4.9 нэгж хувиар өссөн бол цалин хөлстэй түр ажиллагч 3.5 нэгж хувиар, цалин хөлстэй тохиолдлын ажиллагч 2.2 нэгж хувиар буурсан байна.

Зураг 9.8. Ажиллагчдын хөдөлмөр эрхлэлтийн байдлын бүтэц, дүнд эзлэх хувиар, сүүлийн 3 жилийн байдлаар



Зураг 9.9. Хөдөлмөр эрхлэлтийн түвшин, хувиар, байршлаар



Хөдөлмөр эрхлэлтийн түвшин 52.3 хувь болж 2019 оноос 2.1 нэгж хувиар, 2020 оноос 2.3 нэгж хувиар буурсан байна. Байршлын хувьд хот, суурин газрын хүн амын хөдөлмөр эрхлэлтийн түвшин өмнөх оныхоос 17.1 нэгж хувиар буурч 48.1 хувь, хөдөө орон нутгийнх 12.8 нэгж хувиар өсөж 63.8 хувь болсон байна.


2021 онд нийт ажиллагчдын 74.7 (6.6%) мянга нь сүүлийн 7 хоногт ажиллаагүй ч буцаж хийхээр хүлээгдэж байгаа /тогтмол хийдэг/ цалин хөлс, орлого олох ажилтай, тэдгээрийн 41.4 (55.4%) мянга нь үүсээд байгаа цар тахалтай холбоотой гэж хариулсан нь өмнөх оноос 1.3 мянган хүнээр буурсан ч сүүлийн 7 хоногт ажиллаагүй ч хөдөлмөр эрхэлж байгаа хүмүүсийн дүнд эзлэх хувь нь 1.7 нэгж хувиар өссөн байна.

Зураг 9.10. Сүүлийн 7 хоногт ажиллаагүй ч буцаж хийхээр хүлээгдэж байгаа цалин хөлс, орлого олох ажилтай ажиллагчид, ажиллаагүй шалтгаанаар, сүүлийн 3 жилээр



Цар тахлын үед хүмүүсийн гэр бүлийнхээ өмнө хүлээх үүрэг хариуцлага нэмэгдэн хөл хорионы дэглэм сахисан, хөл хорионы үед ихэнх ажил, үйлчилгээ зогссон, засгийн газраас зорилтот бүлгийн өрхүүдэд орлогын дэмжлэг үзүүлсэн зэргээс шалтгаалан 2020 оны 4-р улиралд үүсээд байгаа цар тахалтай холбоотойгоор түр буюу тухайн хугацаанд ажиллаагүй ажиллагчид өссөн байна.

Зураг 9.11. Цар тахлын улмаас хөдөлмөр эрхлээгүй ч хүлээгдэж байгаа ажилтай ажиллагчид, улирлаар, мянган хүнээр



#### 9.4. ХӨДӨЛМӨРИЙН ДУТУУ АШИГЛАЛТ


Улсын хэмжээнд хөдөлмөрийн дутуу ашиглалт 2021 онд 177.3 мянгад хүрч 2019 оноос 24.3 (12.1%) мянгаар буурч, 2020 оноос 13.7 (8.4%) мянгаар өссөн байна. Өмнөх оноос өсөхөд ажилгүй хүн 12.1 (13.8%) мянгаар өссөн нь голлон нөлөөлсөн байна. Түүнчлэн боломжит ажиллах хүчний тоо цар тахал эхэлснээс хойш эрчимтэй өсөж, өндөр түвшинд хэвээр байна. Эдгээр чиг хандлага нь цар тахлын үеийн нөхцөл байдалтай холбоотой.

Зураг 9.12. Хөдөлмөрийн дутуу ашиглалтын үзүүлэлтүүд, мянган хүнээр



Улсын хэмжээнд 2021 онд хөдөлмөрийн дутуу ашиглалтын түвшин өмнөх оноос 1.3 нэгж хувиар өсөж 13.7 хувь, боломжит ажиллах хүч болон ажилгүй хүний нэгдсэн түвшин 1.2 нэгж хувиар өсөж 13.2 хувь, цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэлт болон ажилгүйдлийн нэгдсэн түвшин 1.2 нэгж хувиар өсөж 8.6 хувь, ажилгүйдлийн түвшин 1.1 нэгж хувиар өсөж 8.1 хувьд хүрсэн байна. Уг өсөлтөд ажиллах хүч 2021 оны байдлаар өмнөх оноос 25.2 (2.0%) мянгаар буурч, ажилгүй хүн 12.1 (13.8%) мянгаар өсөж 99.8 мянга, ажиллах хүчнээс гадуурх хүн амын бүлэг болох боломжит ажиллах хүч 0.7 (1.0%) мянгаар өсөж 71.4 мянгад хүрсэн нь нөлөөлсөн байна.

Зураг 9.13. Хөдөлмөрийн дутуу ашиглалтын түвшнүүд, хувиар, улирлаар





# ХАВСРАЛТ А. АЖИЛЛАХ ХҮЧНИЙ СУДАЛГААНЫ ТАНИЛЦУУЛГА

## 1. НИЙТЛЭГ ЗҮЙЛ

Монгол Улсад АХС-г 2002-2003 онд хөдөлмөрийн статистикийг боловсронгуй болгох зорилгоор олон улсын нийтлэг жишиг аргачлалын дагуу улирлаар явуулсан нь хөдөлмөрийн зах зээл дэх улирлын хэлбэлзлийг тусгасан хүн амын хөдөлмөр эрхлэлтийн үндэсний хэмжээний суурь судалгаа болсон билээ. Уг судалгааны үр дүнд үндэслэн ажилгүйдэл, бүрэн бус хөдөлмөр эрхлэлтийг бууруулахад чиглэсэн хөдөлмөр эрхлэлтийн бодлого, хөтөлбөрийг боловсруулах, үр дүнг дүгнэхэд шаардлагатай статистикийн суурь мэдээллийг өргөжүүлэн баяжуулах, мэдээллийн давтамжийг тогтмолжуулах цаашлаад хөдөлмөрийн статистикийн системийг боловсронгуй болгох шаардлага зүй ёсоор тавигдсан. Энэхүү шаардлагын үүднээс олон улсын нийтлэг аргачлалын дагуу АХС-г улирлаар тогтмол явуулж байх нь зүйтэй гэж үзэн 2004 оны 4-р сарын 23-нд Монгол Улсын “Статистикийн тухай” хуульд нэмэлт өөрчлөлт оруулж, 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн ё-д “Хүн амын ажил эрхлэлтийн түүвэр судалгааг улирал тутам явуулж байх”-аар заасан. Иймд 2006 оноос эхлэн АХС-г улирлаар явуулж, үр дүнг нэгтгэн статистикийн бюллетень, танилцуулгад улирлаар, эмхэтгэлд жилээр оруулахаас гадна судалгааны тусгайлсан тайланг жил бүр тархааж байна.

## 2. СУДАЛГААНЫ ЗОРИЛГО

АХС нь эдийн засаг, нийгмийн төлөвлөлт, хяналтыг хэрэгжүүлэхэд шаардагдах албан ёсны хөдөлмөрийн статистикийг бий болгох зорилготой улсын болон нийслэл, аймгийн түвшинд төлөөлөх чадвартай судалгаа юм.

АХС нь хөдөлмөрийн зах зээлийн хэмжээ, бүтэц, тэдгээрт гарч буй өөрчлөлтийг богино хугацаанд тодорхойлох мэдээллийн гол эх үүсвэр бөгөөд дүн шинжилгээ хийхэд ашиглагдах ажиллах хүч, ажиллагчид, тэдгээрийн хөдөлмөрийн нөхцөл, зохистой хөдөлмөр эрхлэлт, албан бус хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн дутуу ашиглалтын үзүүлэлтүүд гэх мэт дэлгэрэнгүй мэдээллийн багцыг бий болгодог ач холбогдолтой.

Мөн АХС нь “Тогтвортой хөгжил -2030 хөтөлбөр”-ийн 8-р зорилго (Тогтвортой, хүртээмжтэй эдийн засгийн өсөлт, бүрэн, бүтээмжтэй ажил эрхлэлт, зохистой хөдөлмөрийг хөхүүлэн дэмжих), 5-р зорилго (Тогтвортой, хүртээмжтэй эдийн засгийн өсөлт, бүрэн, бүтээмжтэй ажил эрхлэлт, зохистой хөдөлмөрийг хөхүүлэн дэмжих)-ын хэрэгжилтийг хянах шалгуур үзүүлэлтүүдийн мэдээллийн анхдагч эх үүсвэр юм.

## 3. АРГАЧЛАЛ, АРГА ЗҮЙ

Ажиллах хүчний судалгааны ойлголт, тодорхойлолт нь олон улсын статистикийн аргачлал, стандарт, Олон улсын хөдөлмөрийн байгууллагын зөвлөмжид суурилсан байдаг.

Дэлхий дахинд Хөдөлмөрийн зах зээл маш хурдацтай өөрчлөгдөж буй өнөөгийн цаг үетэй хөл нийлүүлэн, нөхцөл байдлыг бодитоор харахын тулд 2013 онд болсон ОУХС-ын бага хурлаар 1982 онд гарсан “Эдийн засгийн идэвхтэй хүн ам, хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдэл болон бүрэн бус хөдөлмөр эрхлэлтийн талаарх” аргачлалын тогтоолыг шинэчлэн “Ажил, хөдөлмөр эрхлэлт болон хөдөлмөрийн дутуу ашиглалт”-ын аргачлал бүхий тогтоол гаргасан.

Иймд Монгол Улсад 2019 оны 1 дүгээр сараас эхлэн Үндэсний статистикийн хорооны дарга, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын хамтарсан тушаалаар батлагдсан “Хөдөлмөр эрхлэлтийн статистикийн үзүүлэлтийг тооцох шинэ аргачлал”-ыг мөрдөж байгаа бөгөөд судалгаа уг аргачлалын дагуу явагдсан.

**Гол шинэчлэлт:**

- Хөдөлмөрийн насны дээд хязгаарыг тогтоож өгөөгүй бөгөөд, 15 ба түүнээс дээш болгосон. Ингэснээрээ, тэтгэвэр тогтоолгосон ч хөдөлмөр эрхэлж байгаа эсвэл хөдөлмөрлөх хүсэл зорилготой байгаа тэтгэврийн насны хүн амыг хөдөлмөрийн зах зээлд бүрэн хамруулах боломжтой юм (нийгэмд тэтгэврийн насны хүн жолооч, оёдолчин гэх мэт энгийн ажил мэргэжлээс эхлээд тодорхой ур чадвар шаардсан дотоодын зөвлөхөөр ч ажиллаж, мөн ажиллах хүсэл сонирхолтой байна).
- Өмнөх аргачлалд цалин хөлсгүй дадлагажигч ажилтан, сайн дурын ажилтан нь ажиллагчдын бүлэгт хамрагдаж байсан бол шинэ аргачлалаар ажиллагчдын бүлэгт эдгээр хүн ам хамрагдахгүй буюу зөвхөн цалин, ашгийн төлөө ажиллаж байгаа хүнийг хамааруулсан.
- Давхар хөдөлмөр эрхэлж байгаа ажиллагчийн хувьд үндсэн ажлыг тодорхойлох шалгуур нь хуучнаар хамгийн их цалин хөлс, орлого олдог ажил нь байсан бол шинэ аргачлалын дагуу цалин, орлогоос үл хамааран хамгийн их цаг зарцуулдаг ажлыг үндсэн ажил гэж тодорхойлсон.
- Хуучин аргачлалаар хөдөлмөр эрхлэлтийн хэрэгцээ нь хангагдахгүй байгаа хөдөлмөрийн насны хүн амыг зөвхөн ажилгүй хүний хүрээнд хэмждэг байсан бол шинэ аргачлалаар өргөн хүрээнд авч үзэн, Хөдөлмөрийн дутуу ашиглалтын үзүүлэлтүүд болох ажилгүй хүн + боломжит ажиллах хүч + цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгч гэсэн 3 бүлэг хүн амаар хэмжих болсон. Мөн ажилгүй хүний шалгуур хуучнаар “ажиллагч биш, ажил хайсан **эсвэл** ажил хийхэд бэлэн” гэсэн шалгуур байсан бол шинэ аргачлалаар “ажиллагч биш, ажил хайсан **болон** ажил хийхэд бэлэн” болж өөрчлөгдсөн.

#### Гол ач холбогдол:

Хөдөлмөрийн дутуу ашиглалтын шинэ үзүүлэлтийг бий болгосон нь гол ач холбогдол юм. Учир нь ажиллагч хэдий ч ажлын цаг нь долоо хоногт 40 цагаас бага, нэмэлт ажил хайж, хийхэд бэлэн байгаа “Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгч” болон ажлын байр, ажил олгогчийн шалгуур, мэргэжил, ур чадвар гэх мэт нөхцөл нь бүрдвэл хөдөлмөр эрхлэхэд бэлэн байгаа “Боломжит ажиллах хүчин” нь хөдөлмөрийн зах зээлд “Ажилгүй хүн”-тэй адил хөдөлмөр эрхлэлтийн хэрэгцээ нь хангагдахгүй байгаа хүн ам юм.

#### 4. СУДАЛГААНЫ АСУУЛГЫН ХУУДАС

Судалгааны зорилго, хамрах хүрээг Судалгааны асуулга нь 10 бүлэг бүхий “өрхийн гишүүдийн ерөнхий мэдээлэл, боловсрол, эрүүл мэнд, шилжих хөдөлгөөн, хөдөлмөр эрхлэлт ба түр хугацааны ажилгүйдэл, хөдөө аж ахуйн ажил ба зах зээл дэх оролцоо, үндсэн хөдөлмөр эрхлэлтийн шинж байдал, ажиллагчдын цалин, орлого, ажлын цаг, ажил хайгчдын шинж байдал, ажилгүй байгаа шалтгаан, өмнөх үеийн хөдөлмөр эрхлэлт, өрхийн гишүүдийн цалин хөлсгүй ажил”-ын талаар асуусан 192 асуултаас бүрдсэн.

#### 5. СУДАЛГААНЫ ТҮҮВЭРЛЭЛТ

ҮСХ-ноос түүврийн дизайныг шинэчлэх туршилтын судалгааг 2018 онд явуулж, 2019 оноос “Ажиллах хүчний судалгаа” /АХС/-ны түүврийн дизайныг шинэчлэн **хагас панел буюу ротациональ** судалгааны дизайнд шилжсэн. Судалгаанд нийт 13280 өрх, улирал тутам 3320 өрх судалгаанд хамруулсан.

#### Түүврийн хүрээ:

Судалгаанд Монгол Улсын 2018 оны нийт өрх, хүн ам буюу ҮСХ-ны Хүн ам, өрхийн мэдээллийн санд бүртгэлтэй өрх, хүн амын жагсаалтыг түүврийн хүрээ болгон ашигласан.

Мөн баг, хорооны түвшинд 15 ба түүнээс дээш насны хүн амыг нэмэлт мэдээлэл болгон авсан.

Судалгаа нь өрхөд суурилсан судалгаа бөгөөд цэргийн хуаран, дотуур байр, засан хүмүүжүүлэх газар, сүм хийд болон нийтийн байранд түр амьдрагчид, байнгын орон гэргүй хүн амыг хамруулахгүй болно. Өрхийн ам бүлийн тоонд тухайн өрхөд 6 сараас илүү хугацаагаар эзгүй байгаа (хугацаат цэргийн албан хаагч, оюутан сурагчид, гадаадад ажиллаж амьдарч байгаа болон цагдан хоригдож байгаа) хүнийг өрхийн гишүүнд тооцохгүй.

### Түүврийн үе шат:

Түүвэрлэлт хийх үйл ажиллагаа нь 2 үе шаттай бөгөөд сүүлийн шатанд сонгогдсон өрхийг төлөөлүүлэн мэдээлэл цуглуулалтын үйл ажиллагааг гүйцэтгэнэ.

Эхний үе шатанд Монгол Улсын бүх аймаг, дүүргийн нийт баг, хэсгийн жагсаалтаас харгалзах тооны түүврийн анхан шатны нэгж/ТАШН/ буюу кластеруудыг хот, хөдөөгөөр нь эрэмбэлэн бүлгүүдэд хуваасны дараа систем түүврийн арга ашиглан сонголтыг хийж гүйцэтгэнэ. Энд судалгааны ТАШН нь аймгийн түвшинд баг, нийслэл дүүргийн түвшинд хэсэг байна.

Хоёрдугаар шатанд сонгогдсон ТАШН-ийн өрхийн жагсаалтыг холбогдох мэдээллийн хамт бэлтгэж, энгийн санамсаргүй түүврийн аргыг ашиглан кластер бүрээс 10 өрхийг сонгоно.

### Түүврийн хэмжээ:

Тодорхой нэг нутаг дэвсгэр эсвэл хүн амын тодорхой бүлгийн хувьд 2 үе шаттай түүвэр судалгааны түүврийн хэмжээг дараах томъёоллын дагуу тооцно. Үүнд:

$$n = \frac{Z^2 \times P_0 \times (1 - P_0)}{e^2} * deff \quad (1)$$

z – 95 хувийн ач холбогдлын түвшин дэх t статистикийн тархалтын утга **1.96**

$P_0$  – түлхүүр үзүүлэлтийн хувийн жин. (Орхон аймагт хамгийн их буюу ойролцоогоор **0.25**)

e – таамаглаж байгаа алдааны хязгаарыг аль болох бага хэмжээтэйгээр авах бөгөөд практикт 5-15 хувийн харьцангуй алдаатай байхад судалгааны үр дүнг ашиглаж болдог. (буюу абсолют алдаа **0.05** хувь)

deff – тооцох боломжгүй бөгөөд бид **2.0**-той тэнцүү байна гэж таамагласан.

Улсын хэмжээнд нийт түүврийн хэмжээ нь 13280 буюу ТАШН-ийн тоо 1328 болсон.

### Түүврийн ротаци хуваарилалт:

Улирлаар ТАШН-д ротаци хийхдээ 25 хувийг нь шинээр сонгож, 75 хувийг нь өмнөх улирлынхыг хэвээр үлдээсэн. Түүврийн ротаци хийх хуваарийг дараах хүснэгтээр харуулж байна.

Жилийн эцэст нийт 581=83\*7 ТАШН-ээс судалгаа авсан байна.

Кластерын сонголт хийхийн өмнө нийт баг/хэсгүүдийг тодорхой бүлгүүдэд хувааж **пропорционалиар** хуваарилна.

Түүврийн ротаци хийх хуваарь

I улирал	II улирал	III улирал	IV улирал
PSU1			
PSU2	PSU2		
PSU3	PSU3	PSU3	
PSU4	PSU4	PSU4	PSU4
	PSU 5	PSU 5	PSU 5
		PSU 6	PSU 6
			PSU 7

ТАШН болон ТХШН-ийн тоо, улирлаар

I улирал	II улирал	III улирал	IV улирал
83 PSU – 830 НН			
83 PSU – 830 НН	83 PSU – 830 НН		
83 PSU – 830 НН	83 PSU – 830 НН	83 PSU – 830 НН	
83 PSU – 830 НН	83 PSU – 830 НН	83 PSU – 830 НН	83 PSU – 830 НН
	83 PSU – 830 НН	83 PSU – 830 НН	83 PSU – 830 НН
		83 PSU – 830 НН	83 PSU – 830 НН
			83 PSU – 830 НН

**Түүврийн жин:**

Өрхийн жин нь аймгийн түвшинд сум сонгогдох магадлалын урвуу харьцаа, сумын түвшинд ТАШН (баг, хороо) сонгогдох магадлалын урвуу харьцаа, ТАШН-ийн түвшинд өрх сонгогдох магадлалын урвуу харьцаануудын үржвэр байна.

ТХШН-ийн түвшинд жингийн томьёо:

$$w_i = \frac{H_i}{h_i} \quad (2)$$

Үүнд:  $H_i$  –  $i$  дугаар кластерт байгаа нийт өрхийн тоо

$h_i$  –  $i$  дугаар кластераас сонгосон түүвэр өрхийн тоо (10 эсвэл ямар нэгэн шалтгаанаар татгалзсан судалгаанд хамрагдаагүй бол 10-аас бага байна)

ТАШН-ийн түвшинд жингийн томьёо:

$$w = \frac{N}{n} \quad (3)$$

Үүнд:  $N$  - домэйнд байгаа бүх ТАШН-ийн тоо

$n$  - домэйнд байгаа бүх түүвэр ТАШН-ийн тоо

Эндээс  $i$  дугаар кластерын  $j$  дугаар өрхийн суурь жин нь

$$w_{ij} = \frac{N H_i}{n h_i} \quad \text{байна} \quad (4)$$

Нэг ТАШН-д байгаа өрхүүдийн түүврийн жин тэнцүү буюу ижил байна.

Судалгаанд 13290 өрх 100 хувь хамрагдсан бөгөөд түүврийн жин улс, бүс, аймаг, дүүргийн түвшинд төлөөлөх чадвартайд тооцогдсон.

**Вариаци болон стандарт алдаа:**

Улсын хэмжээнд тодорхойлогдсон тооллогын нэгж бүрийн хувьд сонгосон түүврийн нэгжээс судалгаа авч үр дүнг тооцсонтой холбоотойгоор судалгааны үр дүн бодит утгаасаа ямархуу хэлбэлзэлтэй, төлөөлөх чадвартай байхыг вариацийн утга болон түүврийн алдаа илэрхийлнэ.

Судалгааны мэдээлэл боловсруулахад SPSS программыг ашигласан бөгөөд түүврийн алдааг тооцохдоо уг программын Analyze/Compare Means/Means цэсээр гүйцэтгэсэн. Ингэхдээ тоон утга болон хувиар илэрхийлэгдэх үзүүлэлт тус бүрийн хувьд дараах үр дүнг гаргасан. Үүнд:

- Ерөнхий олонлогийн үзүүлэлтийн тооцооны утга
- Тооцоо хийхэд ашиглагдсан ажиглалтын тоо
- Стандарт алдаа
- Вариацийн коэффициент
- 95 хувийн итгэмжлэгдэх интервал

Түүвэрлэлтийн алдааг судалгааны үндсэн үзүүлэлтийн хувьд улс, хот, хөдөө, хүйс, бүс нутаг, аймгийн түвшинд тооцсон.

## ХАВСРАЛТ Б. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТИЙГ ТООЦОХ АРГАЧЛАЛ

ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ ДАРГА,  
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙДЫН  
ХАМТАРСАН ТУШААЛ

2019 оны 1 дүгээр  
сарын 17-ны өдөр

Дугаар А/09 / А/08

Улаанбаатар  
хот

Хөдөлмөр эрхлэлтийн статистикийн үзүүлэлтүүдийг  
тооцох аргачлалыг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 3.3.2 дахь зорилтын 2 дахь арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Статистикийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3.4, 12.3.7, 15 дугаар зүйлийн 15.1.1 дэх хэсэг, заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Хөдөлмөр эрхлэлтийн статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлалыг хавсралтаар шинэчлэн баталж, 2019 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдүүлсүгэй.

2. Хөдөлмөр эрхлэлтийн статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлалыг улсын хэмжээнд мөрдүүлж ажиллахыг Үндэсний статистикийн хорооны Хүн ам, нийгмийн статистикийн газар /А.Амарбал/, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Ц.Амартөгс/-т тус тус үүрэг болгосугай.

3. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Үндэсний статистикийн хорооны Тамгын газар /Ч.Цэвэгдорж/, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн захиргааны удирдлагын газар /Ц.Нямсүрэн/-т тус тус даалгасугай.

4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан "Хөдөлмөр эрхлэлт, ажиллах хүчний статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал батлах тухай" Үндэсний статистикийн хорооны дарга, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2009 оны 01-68/94 дугаар хамтарсан тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН  
ХОРООНЫ ДАРГА



А.АРИУНЗАЯА

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН  
ХАМГААЛЛЫН САЙД



С.ЧИНЗОРИГ

## НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Хөдөлмөрийн статистикийн олон улсын стандартыг тогтоох механизм нь 5 жил тутам зохион байгуулж буй Хөдөлмөрийн статистикчдын олон улсын бага хурал(ХСОУБХ) юм. Сүүлийн жилүүдэд 1982 оны 13-р бага хурлаас баталсан хөдөлмөр эрхлэлтийн статистикийн аргачлал нь дэлхий дахинд хурдацтай өөрчлөгдөж буй хөдөлмөрийн зах зээлийн өнөөгийн дүр зургийг бодит байдалд нийцүүлэн гаргаж чадахгүй, улмаар хөдөлмөр эрхлэлтийн бодлогод төдийлөн үр дүнтэй ашиглагдаж чадахгүй байна гэж үзсэн. Иймд Хөдөлмөрийн статистикчдын олон улсын 19-р бага хурлаар ажиллах хүч, ажилгүйдлийн түвшинг тооцоход ашиглаж байсан “Эдийн засгийн идэвхтэй хүн ам, хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдэл, бүрэн бус хөдөлмөр эрхлэлтийн үзүүлэлтүүдийг тооцох аргачлал”-ыг шинэчлэн “Ажил, хөдөлмөр эрхлэлт болон хөдөлмөрийн дутуу ашиглалт”-ын талаарх аргачлал бүхий тогтоол гаргасан. Уг шинэчлэгдсэн стандарт ойлголт, тодорхойлолтод нийцүүлэн, өөрийн орны онцлогийг тусган энэхүү аргачлалыг боловсруулав.

Улсын хэмжээнд хүн амын хөдөлмөр эрхлэлтийн статистикийн талаарх мэдээлэл гаргаж, судалгаа явуулан, холбогдох үндсэн үзүүлэлтийг тооцоход энэхүү аргачлалыг ашиглана.

### ЗОРИЛГО, АЧ ХОЛБОГДОЛ

Хөдөлмөрийн статистикийн мэдээллийг бий болгох зорилго нь хөдөлмөрийн зах зээлийн хэмжээ, бүтэц, тэдгээрт гарч буй өөрчлөлтийг тодорхойлох, дүн шинжилгээ хийхэд ашигладаг тоон мэдээллийн багцыг бий болгоход оршино.

Энэхүү аргачлалыг мөрдлөг болгосноор хөдөлмөрийн зах зээлийн нөхцөл байдлын талаарх илүү нарийвчилсан мэдээлэл, түүнчлэн хөдөлмөрийн дутуу ашиглалтыг бүрэн харуулах статистикийн үзүүлэлтийг бий болгож, бодлого боловсруулагчдыг зохих мэдээллээр хангах юм.

### ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсын Статистикийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 6 –д “статистикийн үзүүлэлт, арга зүй нь олон улсын статистикийн стандарт, арга зүйтэй нийцсэн байх”, 12 дугаар зүйлийн 7 –д “статистикийн үзүүлэлт, аргачлалыг олон улсын ангилал, аргачлал, стандартын жишигт нийцүүлэн гаргаж мөрдүүлэх” гэж заасан, мөн Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 3.3.2 дахь зорилтын 2 дахь арга хэмжээнд “Хөдөлмөр эрхлэлт, ажиллах хүчний статистик үзүүлэлтийг тооцох аргачлалыг шинэчлэх гэж тус тус заасан нь энэхүү аргачлалыг боловсруулах хууль эрх зүйн үндэслэл юм. Хөдөлмөрийн статистикчдын олон улсын 19-р бага хурлаар “Ажил, хөдөлмөр эрхлэлт болон хөдөлмөрийн дутуу ашиглалт” олон улсын статистикийн стандарт арга зүйн баримт бичгийг баталж, улс орнуудад мөрдөхийг зөвлөмж болгосон.

## ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

### АЖИЛ, ТҮҮНИЙ ХЭЛБЭР, АЖЛЫН БАЙР

**Ажил** гэж аль ч нас, хүйсийн хүн амын бусдын эсвэл өөрийн хэрэглээнд зориулж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэх албан ёсны болон албан бус бүхий л үйл ажиллагааг ойлгоно. Ажил гэсэн ойлголтод бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэхээс өөр үйлдэл (гуйлга гуйх, хулгай хийх), өөрийн биеийг арчлах (хувийн ариун цэвэр сахих, арьс арчилгаа хийх, өөрийгөө сувилах) болон тухайн хүний өмнөөс өөр хүн гүйцэтгэж үл чадах үйл ажиллагаа (унтах, суралцах, өөрийгөө хөгжүүлэх, амрах) хамаарахгүй (заалт 6, ХСОУ-ын 19-р бага хурлын тогтоол-1).

**Ажлын хэлбэр** гэж харилцан ялгаатай зорилгоор хийж гүйцэтгэдэг, өөр хоорондоо адилгүй олон төрлийн ажлыг үйлдвэрлэлийнх нь зориулалтаар (өөрийн эцсийн хэрэглээ болон бусдын хэрэглээнд), үйл ажиллагааных нь зорилгоос нь (цалин хөлстэй, орлого олох эсэх) хамаарч тус тусад нь хэмжихийг ойлгоно (заалт 7, ХСОУ-ын 19-р бага хурлын тогтоол-1).

**Өөрийн хэрэглээний үйлдвэрлэлийн ажил** гэж ихэвчлэн өөрийн эцсийн хэрэглээнд зориулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаа юм (заалт 7a, ХСОУ-ын 19-р бага хурлын тогтоол-1).

**Хөдөлмөр эрхлэлт** гэж цалин хөлс, орлого олох зорилгоор бусдын хэрэглээнд зориулан бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаа юм. Хөдөлмөр эрхлэлт гэсэн ажлын хэлбэр нь ажиллах хүчний статистикийн хамрах хүрээг тогтооно (заалт 7b, 11, ХСОУ-ын 19-р бага хурлын тогтоол-1).

**Цалин хөлсгүй дадлагажих ажил** гэж ажлын байрны болон мэргэжлийн хувьд дадлага, туршлага, ур чадвар эзэмших зорилгоор цалин хөлсгүйгээр бусдын хэрэглээнд зориулан бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаа юм (заалт 7c, ХСОУ-ын 19-р бага хурлын тогтоол-1).

**Сайн дурын ажил** гэж заавал хийж гүйцэтгэх үүрэг хүлээгээгүй ч бусдын хэрэглээнд зориулан цалин хөлс, орлого олох зорилгогүйгээр бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэх албадлагын бус шинжтэй үйл ажиллагаа юм (заалт 7d, ХСОУ-ын 19-р бага хурлын тогтоол-1).

**Бусад ажил** гэж цалин хөлсгүй нийтийг хамарсан ажил, шүүх, түүнтэй адилтгах эрх мэдэл бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэрээр цалин хөлсгүйгээр хийж гүйцэтгэх хоригдлуудын ажил, цэрэг, цагдаагийн байгууллагаас цалин хөлсгүй гүйцэтгүүлж буй ажил (бусад хөлсгүй хийж өгсөн албадлагын шинж чанартай ажил) юм (заалт 8, ХСОУ-ын 19-р бага хурлын тогтоол-1).

**Ажлын байр** гэж цалин хөлс, орлого олох зорилгоор бусдын хэрэглээнд зориулан хийж гүйцэтгэх ажил, үүрэг, албан тушаалыг хэлнэ. Тэгэхээр энэ үзүүлэлт нь зөвхөн ажиллагчид буюу хөдөлмөр эрхлэлтийн ажлын хэлбэрийн хүрээний ойлголт юм. Бусад ажлын хэлбэрийн хувьд **ажлын үйл ажиллагаа** гэж үзнэ (заалт 12.b, ХСОУ-ын 19-р бага хурлын тогтоол-1).

**Үндсэн ажлын байр** гэж тухайн хүн цалин хөлс, орлого олох зорилгоор хоёр болон түүнээс дээш ажлын байранд хөдөлмөр эрхэлж байгаа тохиолдолд тухайн хугацаанд хамгийн их цаг зарцуулсан ажил юм (заалт 12b, ХСОУ-ын 19-р бага хурлын тогтоол-1).

**Шинэ ажлын байр** гэж үйлдвэрлэл, үйлчилгээг бий болгох болон өргөтгөх замаар эдийн засгийн нэгж дэх албан ба албан бус салбарт шинээр бий болсон ажил, үүрэг, албан тушаалыг хэлнэ. Харин ажиллагчдын шилжилт хөдөлгөөн, тухайлбал ажиллагч тэтгэвэрт гарсны дараа орных нь хүнийг авах, эхийн чөлөөтэй байгаа хүний ажлын байран дээр хүн

авч ажиллуулах, орон тоо шилжих, нэгтгэн зохион байгуулах зэрэг тохиолдлыг шинэ ажлын байранд тооцохгүй.

**Эдийн засгийн үйл ажиллагаа** гэж зах зээлд зориулж үйлдвэрлэсэн бараа, үйлчилгээ юм. Өөрөөр хэлбэл, үндэсний тооцооны системийн хүрээнд бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд худалдах, солилцох эсвэл өөрийн хэрэглээндээ зориулан өрхөд үйлдвэрлэж байгаа бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг хамруулна. Харин өөрийн хэрэглээндээ зориулсан үйлчилгээ болон бусдын хэрэгцээнд зориулсан сайн дурын үйлчилгээг хамруулахгүй.

**Эдийн засгийн бус үйл ажиллагаа** гэж Үндэсний тооцооны системийн хүрээнээс гаднах хүүхэд, өндөр настан асрах, гэр цэвэрлэх, хоол унд бэлтгэх зэрэг цалин хөлс, орлого олох зорилгогүйгээр өөрийн хэрэглээний болон бусдын хэрэглээнд зориулж сайн дураар хийж гүйцэтгэсэн үйлчилгээ юм.

## ХӨДӨЛМӨРИЙН НАСНЫ ХҮН АМ

**Хөдөлмөрийн насны хүн ам** гэж 15, түүнээс дээш насны хүн амыг хэлнэ. Хөдөлмөрийн насны хүн амыг ажиллах хүч болон ажиллах хүчнээс гадуурх хүн ам гэж ангилна (заалт 15, 65, ХСОУ-ын 19-р бага хурлын тогтоол-1).

**Ажиллах хүч** гэж тухайн хугацаанд зөвхөн хөдөлмөр эрхлэлтийн ажлын хэлбэрийн хүрээнд, цалин хөлс, орлого олох зорилгоор бусдын хэрэглээнд зориулан бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэхэд хүч хөдөлмөрөө нийлүүлж байгаа ажиллагчид болон нийлүүлэхэд бэлэн байгаа ажилгүй хүн юм (заалт 11, 16, ХСОУ-ын 19-р бага хурлын тогтоол-1).

**Ажиллах хүчнээс гадуурх хүн ам** гэж сургуульд суралцаж байгаа, гэрийн ажилтай, өндөр настан, өндөр насны тэтгэвэр тогтоолгосон, хөгжлийн бэрхшээлтэй болон ажил хайх итгэл алдарсан зэрэг шалтгаанаар тухайн хугацаанд ажиллах хүчинд хамаарахгүй хөдөлмөрийн насны хүн амыг ойлгоно. Ажиллах хүчнээс гадуурх хүн амаас **боломжит ажиллах хүчин** (тодорхойлолт 2.16.3)-ийг тодорхойлно. Мөн ажиллах хүч болон боломжит ажиллах хүч хоёрын нийлбэрээр **өргөтгөсөн ажиллах хүч** илэрхийлэгдэнэ (заалт 16,55, ХСОУ-ын 19-р бага хурлын тогтоол-1).

## АЖЛЫН ХЭЛБЭРҮҮД ДЭХ ХҮНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА

**Өөрийн хэрэглээнд зориулж бүтээгдэхүүн үйлдвэрлэж, үйлчилгээ үзүүлдэг хүн** гэж тухайн хугацаанд ихэвчлэн өөрийн эцсийн хэрэглээндээ зориулан бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой үйл ажиллагаа эрхэлсэн хүнийг ойлгоно (заалт 22, ОУХС-ын 19-р бага хурлын тогтоол-1).

**Өөрийн эцсийн хэрэглээ** гэдэг нь хөрөнгийн хуримтлал бий болгоход зориулан үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээ эсвэл өөрийн болон өрхийн гишүүдийн, мөн өөр өрхөд амьдарч буй гэр бүлийн холбоотой (эцэг, эх, ах, дүү гэх мэт) хүмүүсийн эцсийн хэрэглээнд зориулан үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээ юм (заалт 22d, ХСОУ-ын 19-р бага хурлын тогтоол-1).

**Цалин хөлсгүй дадлагажигч** гэж тухайн хугацаанд ажлын байран дээрээ ажил, мэргэжлийн туршлага олж авах, ур чадвар эзэмших зорилгоор бусдын хэрэглээнд зориулан, цалин хөлсгүйгээр бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой үйл ажиллагаа эрхэлсэн хүнийг ойлгоно (заалт 33, ОУХС-ын 19-р бага хурлын тогтоол-1).

**Цалин хөлсгүй** гэдэг нь хийж гүйцэтгэсэн ажил буюу ажилласан цагтаа мөнгөн болон мөнгөн бус хэлбэрээр цалин хөлс авахгүй байхыг хэлнэ. Гэхдээ сургалтын тэтгэлэг болон зарим тохиолдолд мөнгөн болон мөнгөн бусаар дэмжлэг (жишээ нь хоол, унд) авдаг байж болно (заалт 33c, ХСОУ-ын 19-р бага хурлын тогтоол-1).



**Бусдын хэрэглээнд зориулж** гэдэг нь өөрийн өрх, өрхийн гишүүдэд хамааралгүй хүмүүсийн хэрэглээнд зориулж зах зээлийн болон зах зээлийн бус нэгжид хийж гүйцэтгэсэн ажил юм (заалт 33d, ХСОУ-ын 19-р бага хурлын тогтоол-1).

**Ажлын байран дээрх дадлага, туршлага, ур чадвар эзэмших** гэдэг нь тодорхой мэргэшил, мэргэжлийн үнэмлэх олгодог эсэхээс үл хамааран уламжлалт арга хэлбэрээр, албан болон албан бус хэлбэрээр ажлын байран дээрээ туршлага, ур чадвараа дээшлүүлэхийг ойлгоно (заалт 33e, ХСОУ-ын 19-р бага хурлын тогтоол-1).

Цалин хөлсгүй дадлагажигч гэдэгт дараах хүмүүс хамаарна (заалт 34, ХСОУ-ын 19-р бага хурлын тогтоол-1). Үүнд:

- а. Цалин хөлсгүйгээр эдийн засгийн үйл ажиллагаанд оролцож байгаа дагалдан ажилтан, мэргэшиж буй дадлагажигч ажилтан, дагалдан дадлагажигчид болон үндэсний нөхцөл байдлын дагуу хэрэгжиж байгаа хөтөлбөрт заасан бусад төрлийн ажилчид;
- б. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулагдсан ур чадвар, давтан сургалтын хөтөлбөрт хамрагдан эдийн засгийн үйл ажиллагаанд цалин хөлсгүй оролцож буй хүн.

Цалин хөлсгүй дадлагажигч гэдэгт дараах хүмүүс хамрагдахгүй (заалт 35, ХСОУ-ын 19-р бага хурлын тогтоол-1). Үүнд:

- а. Ажилд анхлан авахтай холбогдон, туршилтын хугацаанд ажиллаж буй хүн;
- б. Өрх, өрхийн гишүүдийнхээ эзэмшдэг зах зээлийн болон зах зээлийн бус нэгжид хөдөлмөр эрхлэх явцдаа ажлын байран дахь сургалт эсвэл амьдралын турш дахь үйл ажиллагаанаасаа туршлагажиж буй хүн;
- в. Сайн дурын ажил хийж байх үеийн ажлын чиг баримжаа олгох сургалт болон танилцуулгад хамрагдаж буй хүн;
- г. Өөрийн хэрэглээнд зориулсан үйлдвэрлэл явуулахтай холбоотой суралцаж буй хүн.

**Сайн дурын ажил хийж байгаа хүн** гэж тухайн хугацаанд заавал хийх үүрэг хүлээгээгүй, дагаж мөрдөхөөр зохицуулагдаагүй ч бусдын хэрэглээнд зориулан цалин хөлс, орлого олох зорилгогүйгээр бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой үйл ажиллагаа эрхэлсэн хүнийг ойлгоно (заалт 37, ОУХС-ын 19-р бага хурлын тогтоол-1).

**Цалин хөлсгүй** гэдэг нь хийж гүйцэтгэсэн ажил буюу ажилласан цагтаа мөнгөн болон мөнгөн бус хэлбэрээр цалин хөлс авахгүй байхыг ойлгоно. Гэхдээ тухайн үйл ажиллагааг явуулахтай холбоотой амьжиргааны зардал, халаасны зардал, унаа, хоол, бэлэг дурсгалын зүйл зэрэг дэмжлэг, тэтгэмжийг тухайн орон нутгийн дундаж цалин хөлсний гуравны нэгээс доош хэмжээгээр, мөнгөн болон мөнгөн бус хэлбэрээр авч болно (заалт 37b, ХСОУ-ын 19-р бага хурлын тогтоол-1).

**Заавал хийх үүрэг хүлээгээгүй** гэдэг нь иргэний, хууль, эрх зүйн, захиргааны зохицуулалтгүйгээр хийсэн ажил бөгөөд тэдгээр нь хамт олны, соёлын, шашны шинж чанартай болон нийгмийн хариуцлагаа биелүүлэхээс ялгаатай (заалт 37c, ХСОУ-ын 19-р бага хурлын тогтоол-1).

Сайн дурын ажил хийж байгаа хүнд дараах хүмүүс хамаарахгүй (заалт 38, ХСОУ-ын 19-р бага хурлын тогтоол). Үүнд:

- а. Шүүх болон түүнтэй адилтгах эрх бүхий байгууллагын шийдвэрээр нийгэмд үзүүлэх үйл ажиллагааг эрхэлж буй хоригдлууд эсвэл заавал дагаж мөрдөх цэргийн алба буюу түүнийг орлуулахуйц иргэний үйл ажиллагаа эрхэлж буй хүн;
- б. Боловсрол, сургалтын хөтөлбөрийн нэг хэсэг болгон зохион байгуулагддаг цалин хөлсгүй ажилд хамрагдаж буй хүн (цалин хөлсгүй дадлагажигч);

- в. Цалин хөлс, орлого олж буй эдийн засгийн нэгжийнхээ үйл ажиллагааны хүрээнд, ажлын цагийн үеэр бусдад зориулан хийж гүйцэтгэсэн эсвэл ажлын бус цагаар ажил олгогчоос олгосон цалин хөлс, орлого олж буй ажлыг гүйцэтгэсэн хүн.

**Ажиллагч** гэж зөвхөн хөдөлмөр эрхлэлтийн ажлын хэлбэрийн хүрээнд, **цалин хөлс, орлого олох зорилгоор** бүтээгдэхүүн үйлдвэрлэж, үйлчилгээ үзүүлж буй хөдөлмөрийн насны хүнийг хэлнэ. Хөдөлмөр эрхлэгчдийг ажлын байрандаа байгаа болон түр эзгүй байгаа гэж хоёр бүлэгт хувааж авч үзнэ (заалт 27, ОУХС-ын 19-р бага хурлын тогтоол-1).

**Ажлын байрандаа байгаа ажиллагч** гэж тухайн хугацаанд цалин хөлс, орлого олох зорилгоор нэгээс дээш цагаар ажилласан хүн юм. Мөн улирлын шинж чанартай ажлынхаа улирлын үйл ажиллагаанаас хамааралгүйгээр, сул зогсолтын үеэр ч тогтмол ажилладаг ажиллагчдыг хамруулна (заалт 27, 30е ОУХС-ын 19-р бага хурлын тогтоол-1).

**Ажлын байрандаа түр эзгүй байгаа ажиллагч** гэж хүндэтгэн үзэх болон сургалтад хамрагдах шалтгааны улмаас түр хугацаагаар чөлөөтэй байсан, ээлжийн ажилтай, амралтын цагаа нөхөж авах шалтгааны улмаас амарч байгаа, жирэмсний болон амаржсаны, жилийн ээлжийн амралттай байсан, нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдээр амарч байсан, ажил хаялт, ажлын байр түр хаалт, ажлын түр зогсолттой байсан учир тухайн хугацаанд “ажлын байрандаа байгаагүй” боловч эзгүй үед нь ажлын байр нь хадгалагдаж байгаа ажиллагчдыг хамруулна (заалт 27, 29 ОУХС-ын 19-р бага хурлын тогтоол-1).

Ажиллагчдад дараах хүмүүсийг хамааруулна (заалт 30, ОУХС-ын 19-р бага хурлын тогтоол).

Үүнд:

- а. Ур чадвараа нэмэгдүүлэх зорилгоор салбар болон системийн хүрээнд өөр ажил хийж байгаа эсвэл сургалтад хамрагдаж байгаа хүн;
- б. Цалинтай ажиллаж байгаа дагалдан ажилтан, мэргэшиж буй дадлагажигч ажилтан, дагалдан дадлагажигчид;
- в. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн дагуу цалин хөлс, орлого олох зорилгоор ажиллаж байгаа хүн;
- г. Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийх нь зарим хэсгийг өрх, гэр бүл нь хэрэглэдэг ч голчлон худалдах буюу солилцох зорилгоор бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг өөрийн эдийн засгийн нэгждээ ажилладаг хүн;
- д. Бүтээгдэхүүн үйлдвэрлэлээ ихэвчлэн өөрийн хэрэглээнд /өрх, гэр бүл/ зориулан үйлдвэрлэдэг хэдий ч зарим тохиолдолд бага хэмжээгээр зах зээлд борлуулснаас олсон орлого нь тухайн хүн, өрхийн орлогын ихэнх хувийг бүрдүүлдэг өөрийн эдийн засгийн нэгждээ ажилладаг хүн;
- е. Улирлын чанартай ажлынхаа сул зогсолтын үеэр цалин хөлс, орлого олох эсэхээс үл хамааран хуулийн болон захиргааны эрх үүрэг (татвар төлөх), даалгаврыг үргэлжлүүлэн гүйцэтгэж байгаа хүн;
- ё. Өөрийн өрхийн гишүүн болон өөр өрхөд амьдардаг гэр бүлийн холбоотой хүний зах зээлийн нэгжид ажилладаг хүн эсвэл тэдний цалинтай ажилд туслан, ажил үүргийг гүйцэтгэдэг хүн;
- ж. Зэвсэгт хүчний байгууллагад тогтмол ажилладаг хүмүүс, мөнгөн болон мөнгөн бусаар цалин хөлс авдаг цэргийн болон иргэний үйлчилгээний байгууллагад ажиллаж буй хүн.

Ажиллагчдад дараах хүмүүс хамааруулахгүй (заалт 31, ОУХС-ын 19-р бага хурлын тогтоол).

Үүнд:

- а. Мөнгөн болон мөнгөн бус хэлбэрээр цалин хөлс авдаггүй дагалдан ажилтан, мэргэшиж буй дадлагажигч ажилтан, дагалдан дадлагажигчид;
- б. Эдийн засгийн үйл ажиллагаанд оролцолгүйгээр хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд ур чадварын сургалт, давтан сургалтад хамрагдаж байгаа хүн;
- в. Ажилгүйдлийн даатгал, тэтгэвэр гэх мэт төр засгийн нийгмийн хамгааллын тэтгэмжийг үргэлжлүүлэн авах нөхцөлөөр цалин хөлсгүйгээр ажиллаж байгаа хүн;
- г. Тухайн эдийн засгийн нэгжийн үйл ажиллагаанд оролцдоггүй бөгөөд үйл ажиллагааны ашиг, орлогоос мөнгөн болон мөнгөн бус хэлбэрээр орлого авдаг хүн;
- д. Тухайн хугацаанд хөдөлмөр эрхлэхгүй байгаа, тогтмол ажлын байргүй улирлын чанартай хөдөлмөр эрхэлдэг хүн;
- е. Өөрийн ажиллаж байсан эдийн засгийн нэгждээ эргэж ажилд орох эрхтэй боловч ажлаас завсардах босго хугацааг давуулсан бөгөөд цалин хөлсөө авах шалгуурт тэнцээгүй ажлаасаа завсардсан хүн;
- ё. Ажиллаж байсан эдийн засгийн нэгждээ эргэж ажиллах эсэх нь баталгаагүй ажлаас чөлөөлөгдсөн хүн.

### ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН СТАТУС

**Хөдөлмөр эрхлэлтийн статус** гэж эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж байгаа тухайн ажиллагчийг ажиллаж байгаа эдийн засгийн нэгж (хувь хүн, аж ахуйн нэгж, байгууллага эсэх) болон эрх мэдэл, ажил үүргээр нь ангилахыг ойлгоно.

**Ажил олгогч** гэж ашиг олох зорилгоор тогтмол хугацаанд нэг буюу түүнээс дээш хүнийг “цалин хөлстэй ажиллагч”-аар ажиллуулдаг хувиараа хөдөлмөр эрхэлж буй ажиллагчийг ойлгоно. Цалин хөлсөөр ажиллаж буй ажиллагч гэдэгт ажлын байрандаа түр эзгүй байгаа ажиллагчийг оруулна, харин үйл ажиллагаатай холбоотой шийдвэрийг хамтран гаргадаг бизнесийн хамтрагч болон өрхийн бусад туслагчдыг оруулахгүй. Ажил олгогчдыг дотор нь аж ахуйн нэгж байгууллагын ажил олгогч (захирал, менежер) болон өрхийн зах зээлийн аж ахуйн нэгжийн ажил олгогч гэж хоёр ангилна.

**Аж ахуйн нэгж, байгууллагын ажил олгогч** гэж ашиг олох зорилгоор аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагааг бие даан эсвэл нэг болон хэд хэдэн хувь нийлүүлэгч бүхий бизнесийн хамтрагчтайгаа хамтран эрхэлж, тухайн үйл ажиллагаандаа нэг буюу түүнээс дээш хүнийг тогтмол “цалин хөлстэй ажиллагч”-аар ажиллуулан, хувийн бизнесийнхээ үйл ажиллагаанд оролцуулж байгаа байгууллагын эзэн бүхий ажиллагч юм. Цалин хөлсөөр ажиллаж буй ажиллагчид ажлын байрандаа түр эзгүй байгаа ажиллагчийг оруулна, харин үйл ажиллагаатай холбоотой шийдвэрийг хамтран гаргадаг бизнесийн хамтрагч болон өрхийн бусад туслагчдыг оруулахгүй.

**Зах зээлд чиглэсэн өрхийн аж ахуйн нэгжийн ажил олгогч** гэж ашиг олох зорилгоор аж ахуйн нэгж байгууллага бус зах зээлийн аж ахуйн нэгжийг бие даан эсвэл нэг болон хэд хэдэн хувь нийлүүлэгч бүхий бизнесийн хамтрагчтайгаа хамтран эрхэлж, тухайн үйл ажиллагаандаа нэг буюу түүнээс дээш хүнийг тогтмол “цалин хөлстэй ажиллагч”-аар ажиллуулж байгаа ажиллагч юм. Цалин хөлсөөр ажиллаж буй ажиллагчид ажлын байрандаа түр эзгүй байгаа ажиллагчийг оруулна, харин үйл ажиллагаатай холбоотой шийдвэрийг хамтран гаргадаг бизнесийн хамтрагч болон өрхийн бусад туслагчдыг оруулахгүй.

**Цалин хөлстэй ажилтангүй бие даасан ажиллагч** гэж өөрийн хөрөнгөөрөө бие даан, эсвэл бусадтай хамтран эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж, тухайн хугацаанд ямар нэгэн цалин хөлстэй ажилтан авч ажиллуулаагүй хувиараа хөдөлмөр эрхэлж буй ажиллагчийг ойлгоно. Ямар нэгэн цалин хөлстэй ажилтан авч ажиллуулаагүй гэдэг нь өөрөөсөө, бизнесийн

хамтрагч, хувь нэмэр оруулагч гэр бүлийн гишүүнээсээ өөр нэг ч хүн ажилчнаар авч ажиллуулаагүй байхыг ойлгоно. Эдгээр хөдөлмөр эрхлэгчдийг дотор нь цалин хөлстэй ажилтангүй аж ахуй нэгж, байгууллагын үйл ажиллагаа эрхлэгч болон цалин хөлстэй ажиллагчгүй зах зээлд чиглэсэн өрхийн аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгч гэж хоёр ангилна.

**Цалин хөлстэй ажилтангүй аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаа эрхлэгч** гэж ямар нэгэн цалин хөлстэй ажилтан авч ажиллуулахгүйгээр, бие даан эсвэл хувь эзэмшигч, бизнесийн хамтрагч, хувь нэмэр оруулагч гэр бүлийн гишүүдтэйгээ хамтран аж ахуйн нэгж, байгууллагын (хязгаарлагдмал хариуцлагатай компани, нөхөрлөл, хоршоо) үйл ажиллагааг эрхэлж буй ажилч юм.

**Цалин хөлстэй ажилтангүй, зах зээлд чиглэсэн өрхийн аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгч** гэж ямар нэгэн цалин хөлстэй ажилтан авч ажиллуулахгүйгээр, бие даан эсвэл бизнесийн хамтрагч, хувь нэмэр оруулагч гэр бүлийн гишүүдтэйгээ хамтран аж ахуйн нэгж байгууллага бус зах зээлийн аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг эрхэлж явуулдаг ажилч юм.

**Гүйцэтгэх гэрээлэгч** гэж эдийн засгийн өөр нэг нэгжид, эсвэл уг нэгжээр дамжуулаад бүтээгдэхүүн, үйлчилгээг нийлүүлэх зорилгоор арилжааны шинжтэй гэрээ (хөдөлмөрийн бус) байгуулан ажиллаж буй ажиллагч юм. Эдгээр ажиллагч нь тухайн эдийн засгийн нэгжийн цалин хөлстэй ажиллагч биш боловч ажлын төлөвлөлт, зохион байгуулалт, гүйцэтгэл, орлого болон зах зээлд гарах боломж зэрэг нь уг эдийн засгийн нэгжээс хамаардаг. Мөн эдгээр ажиллагч нь тэдний үйлдвэрлэлийн (бүтээмжтэй) үйл ажиллагаанд хяналт тавьж, хийж гүйцэтгэсэн ажлынх нь үр шимийг шууд хүртдэг эдийн засгийн өөр нэгжээс хараат, ашгийн төлөө ажиллагч юм.

**Цалин хөлстэй ажиллагч** гэж ажиллаж буй эдийн засгийн нэгжээ эзэмшдэггүй, үйл ажиллагааны шийдвэрт оролцохгүйгээр тухайн нэгжид албан болон албан бусаар хөдөлмөр эрхлэн, ажилласан цаг, хийж гүйцэтгэсэн ажлынхаа (зарим тохиолдолд хийж гүйцэтгэсэн ажлынхаа үйл ажиллагаа тус бүрт) эсвэл худалдаа, үйлчилгээ (тоо хэмээ, захиалгын тоогоор) үзүүлснийхээ төлбөр болгон мөнгөн болон мөнгөн бус хэлбэрээр цалин хөлс авдаг ажиллагч юм. Цалинтай ажиллагчдыг хөдөлмөр эрхлэлтийн гэрээний нөхцөл, хөдөлмөрийн харилцааны зохицуулалтаас нь хамаарч 4 ангилна.

**Цалин хөлстэй байнгын ажиллагч** гэж ажлын цагийн доод хэмжээгээр ажиллах нь хүлээн зөвшөөрөгдсөн, байнгын буюу тухайн эдийн засгийн нэгжид ажиллах насны дээд хязгаар, тэтгэвэрт гарах нас зэргээс бусад хөдөлмөр эрхлэлтийг зогсоох тодорхой хугацаа, нөхцөл заагдаагүйгээр хөдөлмөр эрхэлдэг ажиллагч юм. Эдгээр ажиллагчид нь албан болон албан бус ажлын байранд бүтэн эсвэл хагас цагаар ажиллагч байж болно. Мөн ажилд ороод удаагүй, туршилтын хугацаандаа ажиллаж байгаа боловч цаашид үргэлжлүүлээд байнгын хугацаагаар ажиллуулахаар хүлээгдэж байгаа ажиллагч орно.

**Цалин хөлстэй түр ажиллагч** гэж хөдөлмөр эрхлэх хугацаа нь 3 ба түүнээс дээш сараар хязгаарлагдсан буюу тодорхой хугацаатай хөдөлмөр эрхэлж буй ажиллагч юм. Эдгээр ажиллагчид нь албан болон албан бус ажлын байранд бүтэн эсвэл хагас цагаар ажиллагч байж болно.

**Цалин хөлстэй тохиолдлын ажиллагч** гэж ажлын тогтсон цаггүй, хөдөлмөр эрхлэлт нь 3 сар хүртэлх хугацаагаар хязгаарлагдсан буюу богино хугацаатай хөдөлмөр эрхэлж буй ажиллагч юм.

**Цалин хөлстэй дагалдан ажилтан, мэргэшиж буй дадлагажигч ажилтан, дагалдан дадлагажигчид** гэж цалин хөлстэйгөөр, ажлын байрны болон мэргэжлийн хувьд

дадлага, туршлага, ур чадвар эзэмших зорилгоор бусдын хэрэглээнд зориулан бүтээгдэхүүн үйлдвэрлэж, үйлчилгээ үзүүлж буй ажиллагч юм.

**Гэр бүлийн гишүүдэд хувь нэмрээ оруулагч** гэж өрхийн гишүүд, мөн өөр өрхөд амьдарч буй гэр бүлийн холбоотой (эцэг, эх, ах, дүү гэх мэт) хүмүүсийн эрхэлж буй зах зээлд чиглэсэн өрхийн аж ахуйн нэгжийн ажилд, эсвэл тэдгээрийн цалинтай ажил болон гүйцэтгэх гэрээлэгчээр ажиллаж буй ажилд нь тусалж байгаа ажиллагчийг хэлнэ. Тэд эдийн засгийн нэгжийн үйл ажиллагаанд нь нөлөөлөх шийдвэр гаргадаггүй, үүрэг хүлээдэггүй бөгөөд цалин хөлсгүйгээр оролцож, үйл ажиллагаанаас олсон орлогоос өрх дотроо ашиг хүртдэг.

## ХӨДӨЛМӨРИЙН ДУТУУ АШИГЛАЛТ

**Хөдөлмөрийн дутуу ашиглалт** гэж хөдөлмөрийн нийлүүлэлт болон эрэлтийн зөрүү буюу хөдөлмөрийн насны хүн амын хөдөлмөр эрхлэлтийн хэрэгцээ хангагдахгүй байхыг ойлгоно (заалт 40, 42 ХСОУ-ын 19-р бага хурлын тогтоол). Хөдөлмөрийн дутуу ашиглалтыг дараах үзүүлэлтээр хэмжинэ. Үүнд:

**Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгч** гэж тухайн хугацаанд хөдөлмөр эрхэлж буй ажиллагчийн бүх ажлынх нь ажлын цаг нь үндэсний хууль тогтоомжид заасан босго цагаас бага бөгөөд өөр ажил хийх хүсэлтэй, нэмэлт цагаар ажиллахад бэлэн байгаа хүнийг ойлгоно. Босго цаг гэдгийг Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу 7 хоногийн ажлын 40 цагаар авч үзнэ (заалт 43 ХСОУ-ын 19-р бага хурлын тогтоол).

**Ажилгүй хүн** гэж сүүлийн 7 хоногт хөдөлмөр эрхлээгүй, хөдөлмөр эрхлэх зорилгоор ажил хайж байгаа болон ажил хийхэд бэлэн байгаа хөдөлмөрийн насны хүн юм (заалт 47 ХСОУ-ын 19-р бага хурлын тогтоол).

**а. хөдөлмөр эрхлээгүй** гэж тухайн хугацаанд буюу сүүлийн 7 хоногт цалин хөлс, орлого олох зорилгоор ямар нэгэн ажил хийгээгүй, ажиллагч гэдэг тодорхойлолтод хамаарахгүй байхыг;

**б. ажил хийхэд бэлэн** гэж тухайн хугацаанд буюу сүүлийн 7 хоногт эсвэл тухайн хугацаанаас хойш ирэх хоёр долоо хоногт ажил хийж эхлэхэд бэлэн байхыг;

**в. ажил хайж байгаа** гэж сүүлийн дөрвөн долоо хоногт цалин хөлс, орлого олох зорилгоор ямар нэгэн хэлбэрээр ажил хайсан эсвэл хувийн бизнес эхлүүлэх оролдлого хийсэн хүн юм. Ажил хайх гэдгийг ажилд зуучлах төрийн болон хувийн байгууллагад бүртгүүлэх, ажлын байрны талаар мэдээлэл авч ажил олгогчтой холбогдсон, ажлын зар, цахим хуудсаар ажил олгогчид хандах, нийтийн үйлчилгээний газруудын мэдээллийн самбар, хэвлэл мэдээллийн хэрэгсэлд зар тавих гэх мэт ажил олох оролдлого идэвхтэй хийхийг ойлгоно. Харин ажлын байрны талаар мэдээлэл авсан ч ажил олгогчид хандаагүй бол идэвхтэй оролдлого хийсэн гэж үзэхгүй.

**Боломжит ажиллах хүч** гэж цалин хөлс, орлого олох зорилгоор хөдөлмөр эрхлэхийг сонирхож байгаа боловч тодорхой нөхцөл байдлын улмаас ажил хайх оролдлого нь хязгаарлагдсан эсвэл шууд ажил хийх боломжгүй байгаа, тухайн хугацаанд хөдөлмөр эрхлээгүй хүн юм (заалт 40с, 51, ХСОУ-ын 19-р бага хурлын тогтоол). Боломжит ажиллах хүчинд дараах хүмүүсийг хамааруулна. Үүнд:

**а. Ажил хийхэд бэлэн биш байгаа ажил хайгч** буюу ажил хайх оролдлого хийж байсан ч тухайн хугацаанд ажил хийхэд бэлэн биш, боломжгүй байгаа хүн;

**б. Ажил хайгаагүй ч ажил хийх боломжтой хүн** буюу ажил хайх оролдлого хийгээгүй ч ажил хийх хүсэлтэй, ажил хийхэд бэлэн байгаа хүн.

**Итгэл алдарсан ажил хайгч** гэж ажил хайгаагүй ч ажил хийх боломжтой байгаа хүн ам (тодорхойлолт 2.16.б)-аас хөдөлмөрийн зах зээлтэй холбоотой буюу мэргэжил, туршлага байхгүйгээс тохирох ажлын байр олж авч чадахгүй байгаагаас эсвэл хэтэрхий залуу, хөгшин байна гэсэн шалтгаанаар ажил олгогчдын шаардлагад нийцэхгүй байгаагаас ажлын байр хайж олох найдвараа алдан, ажил хайгаагүй байгаа хөдөлмөрийн насны хүн ам юм (заалт 51b, 52, 80b, ХСОУ-ын 19-р бага хурлын тогтоол).

### АЛБАН БУС ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

**Албан бус салбар** гэж хөдөө аж ахуйн бус салбарт орлого олох зорилготойгоор зах зээлд бүтээгдэхүүн, үйлчилгээгээ борлуулдаг өрхийн хоршоологдоогүй аж ахуй нэгжийг ойлгоно. Тэд ямар нэгэн бүрэн хөтөлсөн данс тооцоогүй, албан ёсны бүртгэлийг дагаж мөрддөггүй буюу аж ахуйн зохион байгуулалтын хэлбэрт ороогүй, орлогын албан татварын талаарх мэдээлэлд бүрэн хамрагдаагүй байдаг (заалт 5, 6, 7, ХСОУ-ын 15 бага хурлын тогтоол).

**Албан салбар** гэж төрийн байгууллага, төрийн өмчит аж ахуйн тогтолцоотой үйлдвэрийн газар буюу зах зээлийн бус хуулийн этгээдүүд болон зах зээлд борлуулах зорилгоор бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг эрхэлж буй албан ёсны бүртгэлд бүрэн хамрагдсан хуулийн этгээд, хуулийн этгээдийн хяналт дор (орлогын албан татварын талаарх мэдээлэлд бүрэн хамрагдсан) үйл ажиллагаа явуулж буй хувь хүн, өрхийн аж ахуйн үйл ажиллагаа юм.

**Албан бус хөдөлмөр эрхлэгч** гэж албан бус ажлын байранд хөдөлмөр эрхэлж буй ажиллагч юм. Албан бус хөдөлмөр эрхлэгчид дараах хүмүүсийг хамааруулна. Үүнд:

- а. Тухайн хугацаанд хөдөлмөрийн харилцаа нь хууль эрх зүйн хүрээнд бүрэн зохицуулагдаагүй, орлогын албан татвар, өвчтэй байсны тэтгэмж, ээлжийн амралт олгодоггүй, нийгмийн хамгааллын бусад асуудал хангагдаагүй нөхцөлд ажиллаж буй цалин хөлстэй ажиллагч;
- б. Албан бус салбарт ажиллаж буй зах зээлд чиглэсэн өрхийн аж ахуйн нэгжийн ажил олгогч болон цалин хөлстэй ажиллагчгүй бие даасан ажиллагч;
- г. Зөвхөн өөрийн эцсийн хэрэглээнд зориулан бүтээгдэхүүн үйлдвэрлэж буй өрхөд цалин хөлстэй ажиллагч;
- д. Хувь нэмэр оруулагч гэр бүлийн гишүүд орно.

**Албан бус салбарт ажиллагч** гэж хөдөлмөр эрхлэлтийн статусаас үл хамааран, тухайн хугацаанд наад зах нь нэг албан бус салбар дахь эдийн засгийн нэгжид ажиллаж байгаа ажиллагч юм.

**Албан салбарт албан бус хөдөлмөр эрхлэгч** гэж албан салбар дахь албан бус ажлын байр (тодорхойлолт 2.20.а)-нд хөдөлмөр эрхэлж буй ажиллагч юм.

**Албан бус эдийн засагт ажиллагч** гэж албан бус салбарт болон албан салбар дахь албан бус ажлын байранд хөдөлмөр эрхэлж буй ажиллагч юм.

### ХҮҮХДИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

**Хүүхэд** гэж НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцын 1 дүгээр зүйл болон ОУХБ-ын Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийн тухай 182 дугаар конвенцын 2 дугаар зүйлд зааснаар 18 насанд хүрээгүй хүнийг хүүхэд гэж тодорхойлно. Хүүхдийн хөдөлмөрийг хэмжих зорилтод хүн ам нь 5-17 насны бүлэгт багтах бүх хүүхэд байх бөгөөд хүүхдийн насыг түүний хамгийн сүүлчийн төрсөн өдрөөр тасалбар болгох буюу бүтэн насаар тодорхойлно (заалт 8, 9, ХСОУ-ын 18 бага хурлын II тогтоол энэ 20-р өөрчлөгдөөгүй).

**Хүүхдийн ажил эрхлэлт** гэж хүүхдийн хөдөлмөрийг хэмжихтэй холбоотой хамгийн өргөн хүрээтэй ойлголт бөгөөд ҮТС-2008-д тодорхойлсноор ҮТС-ын үйл ажиллагааны ерөнхий

хүрээнд хамаарч буй бусдын эсвэл өөрийн хэрэглээнд зориулж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэх аливаа үйл ажиллагааг тухайн хугацаанд нэг цагаас доошгүй эрхэлсэн 5-17 насны хүүхдийн үйл ажиллагаа юм. Өөрөөр хэлбэл, өөрийн хэрэглээний үйлчилгээ эрхэлж байгаа болон өрхийн хэрэгцээнд зориулан сайн дураар үйлчилгээ үзүүлж буй хүүхдийн үйл ажиллагааг ҮТС-ийн үйлдвэрлэлийн хүрээнээс гадуурх ажлын хэлбэр гэж үзэх ч үйлдвэрлэлийн ерөнхий хүрээн доторх үйл ажиллагаа эрхэлж буй хүүхэд гэж үзнэ (заалт 11, 13 ХСОУ-ын 18 бага хурлын II тогтоолын шинэчилсэн төсөл).

**Хүүхдийн хөдөлмөр эрхлэх насны доод хязгаар** гэж ОУХБ-ын Ажилд авах насны доод хязгаарын тухай 138 дугаар конвенцын 2 дугаар зүйлд зааснаар ажил, хөдөлмөр эрхлэх насны доод хязгаар нь заавал эзэмших боловсрол буюу суурь боловсрол эзэмших хүүхдийн нас байх бөгөөд энэ нь ямар ч тохиолдолд 15 наснаас доошгүй байна.

**Хөнгөн ажил** гэж ОУХБ-ын Ажилд авах насны доод хязгаарын тухай 138 дугаар конвенцын 7 дугаар зүйлд зааснаар доорх нөхцөл хангагдсан тохиолдолд ажил эрхэлж буй 13-17 насны хүүхдийн үйл ажиллагаа юм. Хангагдсан байх нөхцөлд:

- а. эрүүл мэнд, өсөлт хөгжилд хортой нөлөө үзүүлэхгүй байх;
- б. сургуульд суралцах, мэргэжлийн чиг баримжаа олгох, мэргэжилтэн бэлтгэх хөтөлбөрт хамрагдах болон олсон мэдлэгээ ашиглах явцад нь саад учруулахгүй байх шаардлагыг хангасан байх;
- в. хууль ёсны төлөөлөгч буюу эцэг, эх асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн зөвшөөрөлтэй байх ёстой.

**Хүүхдийн хөдөлмөр эрхлэлт** гэж дараах бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг эрхэлсэн 18 нас хүрээгүй хүүхдийн үйл ажиллагаа юм (заалт 12, 15, ХСОУ-ын 18 бага хурлын II тогтоолын шинэчилсэн төсөл). Үүнд:

- а. ажил эрхэлж буй хүүхэд (тодорхойлолт 22) болон хөнгөн ажил хийж болохуйц наснаас доош нас (5-12 нас)-ны хүүхдийн эрхэлж буй үйл ажиллагаа;
- б. ҮТС-ын үйлдвэрлэлийн хүрээнд хөнгөн ажлыг тогтмол эрхэлж байгаа 13-17 насны хүүхдийн үйл ажиллагаа;
- в. тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүд (тодорхойлолт 26) болон өрхөд цалин хөлсгүйгээр ажиллаж буй аюултай үйлчилгээг багтаасан аюултай ажил (тодорхойлолт 27) эрхэлж байгаа буй хүүхдийн үйл ажиллагаа орно.

Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэр гэдэгт:

- а. боолчлолын бүх хэлбэрүүд болон хүүхдийг худалдах, дамжуулан худалдах, өрийн төлөөс, хамжлагын албат болгох, хүчээр буюу албадан хөдөлмөрлүүлэх, түүний дотор зэвсэгт мөргөлдөөнд хүүхдийг хүчээр буюу албадан элсүүлэх зэрэг боолчлолтой төстэй үйл ажиллагаа;
- б. хүүхдийг бэлгийн мөлжлөгт өртүүлж буй үйл ажиллагаа, садар самууны сурталчилгаа болон садар самууны үзүүлбэрт хүүхдийг ашиглах, элсүүлэн авах эсвэл тийм үйл ажиллагаанд оролцохыг санал болгох;
- в. хүүхдийг мансууруулах бодис үйлдвэрлэх, нууцаар наймаалах зэрэг олон улсын холбогдох гэрээнүүдэд заагдсан хууль бус үйл ажиллагаанд оролцохыг санал болгох;
- г. мөн чанар, эсвэл хөдөлмөрийн нөхцөлөөрөө хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдал, ёс суртахуунд хохирол учруулахуйц ажлыг хамааруулна (заалт 17, ХСОУ-ын 18 бага хурлын II тогтоол).

**Хүүхдийн аюултай ажил** гэж хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдал, ёс суртахуун, хүмүүжилд сөргөөр нөлөөлөх аюултай шинж чанар бүхий (аюултай орчин, тоног төхөөрөмж, салбар, ажил мэргэжил) аливаа ажил, үйл ажиллагаа юм. Уртасгасан цагаар эсвэл шөнийн цагаар ажиллаж байгаа бол аюултай ажил эрхэлж байна гэж үзнэ (заалт 20, ХСОУ-ын 18 бага хурлын II тогтоол).

## АЖЛЫН ЦАГ

**Жинхэнэ ажилласан цаг** нь урт болон богино хугацааны туршид Үндэсний тооцооны системийн хүрээнд бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг тухайн хугацаанд гүйцэтгэхэд зарцуулсан цаг юм (заалт 11, ХСОУ-ын 18 бага хурлын I тогтоол). Жинхэнэ ажилласан цагт дараах үйл ажиллагаанд зарцуулсан цагийг оруулна. Үүнд:

**Шууд цаг** гэж байршил (ажлын байрандаа, гудамжинд, гэртээ)-аас үл хамааран, ажил үүргээ гүйцэтгэхэд зарцуулсан цаг юм. Үүнд илүү цагаар ажилласан цаг эсвэл ажил үүргээ гүйцэтгэхэд зориулагдаагүй (үдийн завсарлага болон ажилтай холбоотой зорчин явах) цагийг оруулна.

**Холбогдох цаг** гэж үйл ажиллагааг хэвийн байлгах, хөнгөвчлөх буюу нэмэгдүүлэхэд зарцуулсан цагийг ойлгох бөгөөд дараах үйл ажиллагаанд зарцуулсан цагийг оруулна. Үүнд:

- а. Багаж хэрэгсэл, машин техник, ажлын байраа цэвэрлэх, засварлах, бэлтгэх зэрэг үйл ажиллагаа, ажлын хувцсаа өмсөх;
- б. Үндсэн материалыг зах зээл, нийлүүлэгчээс худалдан авах, бараа материалаа хэрэглэгчдэд хүргэхтэй холбоотой тээвэрлэх;
- в. Бизнесийн түнш, хэрэглэгч, үйлчлүүлэгчдээ хүлээн авах, ажлын цагаар уулзалт хийх;
- г. Цалин хөлстэй эсэхээс үл хамааран дуудлагаар ажиллах (эрүүл мэндийн болон бусад чухал үйлчилгээ гэх мэт) эсвэл гэрээсээ ажлын байрандаа дуудагдан ажиллах;
- д. Ажлын байр хооронд явах, ажил үүргийн дагуу томилолтоор явах, хэрэглэгч болон үйлчлүүлэгчтэй уулзахаар явах;
- е. Ажлын байрандаа болон ажлын байрнаас гадуур мэргэжил дээшлүүлэх сургалтад байгууллагын болон бусад нэгжийн зардлаар хамрагдах.

**Ашиглаагүй цаг** гэж ажлын байрандаа байгаа боловч техникийн саатлаас тухайлбал, гэрэл тасрах, интернэтийн шугам тасрах, машин техник эвдрэх, осол гаргах зэрэг шалтгаанаар ажиллаж чадахгүй байх цагийг ойлгоно.

**Амрах цаг** гэж түр амс хийх, кофе цай уух, хүч сэлбэх зэрэг богино хугацааны амралтад зориулсан цагийг ойлгоно.

**Байнгын ажлын цаг** гэж богино хугацаанд буюу нэг долоо хоног, урт хугацаанд буюу сар, улирал, эсвэл жилийн турш тухайн ажилд ажилласан жинхэнэ ажлын цагийн дундаж утгыг ойлгоно (заалт 15, ХСОУ-ын 18 бага хурлын I тогтоол).

**Бүтэн цагаар ажиллагч** гэж Монгол Улсын “Хөдөлмөрийн тухай хууль”-д заасны дагуу долоо хоногийн ажлын цаг нь 40 хүртэл, ердийн ажлын өдрийн үргэлжлэл 8 хүртэл цаг, ажлын дараалсан 2 өдрийн хоорондох тасралтгүй амралт нь 12 цаг ба түүнээс дээш хугацаатай ажилладаг ажиллагч болон ээлжээр ажилладаг ажиллагчийг ойлгоно.

**Хагас цагаар ажиллагч** гэж хөдөлмөрийн болон ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах гэрээ байгуулан ажиллаж, хөдөлмөрийн харилцаа нь Хөдөлмөрийн тухай болон Иргэний хуулиар зохицуулагддаг боловч долоо хоногийн ажлын цаг, ердийн ажлын өдрийн үргэлжлэлээс бага хугацаагаар ажиллаж, цалин хөлс, орлого олдог, татвар, нийгмийн даатгалын



шимтгэлийг ажил олгогч болон өөрөө хариуцан төлдөг ажиллагчийг ойлгоно (үүнд цагийн ажил хийж буй хөдөлмөрийн насны суралцагчийг хамруулахгүй).

## БУСАД

**Урт хугацаагаар ажилгүй байгаа хүн** гэж 12 сар, түүнээс дээш хугацаагаар хөдөлмөр эрхлээгүй, тухайн хугацаанд ажил хайж байгаа болон ажил хийх боломжтой байгаа ажилгүй хүн юм (заалт 50, ХСОУ-ын 19-р бага хурлын тогтоол).

**Ажил хайгч** гэж ажилгүй хүн эсвэл ажиллагч боловч ажлын нөхцөлөө сайжруулах, нэмэлт орлого олох зорилгоор Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад ажил хайж бүртгүүлсэн хүн юм.

**Бүртгэлтэй ажилгүй хүн** гэж цалин хөлс, орлого олох зорилгоор хөдөлмөр эрхлээгүй, тухайн хугацаанд хөдөлмөр эрхлэхэд бэлэн болон Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад ажил хайж бүртгүүлсэн ажилгүй хүн юм.

**Хөдөлмөр эрхлээгүй болон боловсрол, сургалтад хамрагдаагүй байгаа залуучууд** гэж тухайн хугацаанд хөдөлмөр эрхлээгүй, албан боловсрол эзэмших сургуульд суралцаагүй, бүх шатны сургалтад хамрагдаагүй байгаа 15-24 насны ажилгүй болон ажиллах хүчнээс гадуурх залуучуудыг ойлгоно.

**Ажилтай ядуучууд** гэж ядуурлын шугамаас доогуур орлоготой буюу ядуу өрхөд амьдарч байгаа хөдөлмөр эрхэлж буй хүн юм.

## АЖЛЫН ХЭЛБЭРТ ТОХИРОХ ЖИШИГ ХУГАЦАА

Тухайн хэлбэрийн ажилд хэр хэмжээгээр оролцож байгаад үндэслэн тухайн хийж байгаа ажлын хэлбэрт нь тохирох стандарт хугацааг тогтооно (заалт 19, ХСОУ-ын 19-р бага хурлын тогтоол). Стандарт хугацаанд:

- (a) Өөрийн эцсийн хэрэглээний үйлчилгээний ажил, хөдөлмөр эрхлэлтийн ажлын хэлбэр дээр цалин хөлсгүй дадлагажиж ажил болон хөдөлмөр эрхлэлтийн ажлын хэлбэрийн хувьд лавлагаа хугацааг сүүлийн нэг долоо хоногоор;
- (b) Өөрийн эцсийн хэрэглээний үйлдвэрлэлийн ажил, өөрийн эцсийн хэрэглээний бараа, үйлчилгээ үйлдвэрлэх ажлын хэлбэр дээр цалин хөлсгүй дадлагажиж ажил болон сайн дурын ажлын хэлбэрийн хувьд лавлагаа хугацааг сүүлийн нэг сараар тогтооно.

Тухайн хэлбэрийн ажлын тохирох стандарт хугацаанд тухайн хүн наад зах нь нэг цаг оролцсон бол тухайн ажлыг гүйцэтгэсэн гэж тооцно. Энэ нэг цагийн шалгуурыг ашиглах нь түр зуурын, амь зуулгын, тохиолдлын үйл ажиллагаа, түүнчлэн үйлдвэрлэлд оруулсан хөдөлмөрийн нийлүүлэлт зэргийг бүхэлд нь тооцох зэргээр бүхий л үйл ажиллагааны хамрах хүрээг баталгаажуулна (заалт 22, ХСОУ-ын 19-р бага хурлын тогтоол).

## ТООЦОХ АРГА ЗҮЙ

Ажиллах хүчний статистикийн дараах үзүүлэлтийг тооцож гаргана. Үүнд:

**Ажиллах хүч:** Тухайн хугацаанд хөдөлмөрийн зах зээлд ажиллах хүчээ нийлүүлж байгаа ажиллагчид болон нийлүүлэхэд бэлэн байгаа ажилгүй хүний тооны нийлбэрээр тооцно.

$$\text{Ажиллах хүч} = \text{Ажиллагчид} + \text{Ажилгүй хүн} \quad (1)$$

**Өргөтгөсөн ажиллах хүч:** Ажиллах хүч болон боломжит ажиллах хүчний тооны нийлбэрээр тооцно.

Өргөтгөсөн ажиллах хүч = Ажиллах хүч + Боломжит ажиллах хүч (2)

**Ажиллах хүчний оролцооны түвшин:** Ажиллах хүчний тоог хөдөлмөрийн насны хүн амын тоонд харьцуулж тооцно.

$$\text{Ажиллах хүчний оролцооны түвшин} = \frac{\text{Ажиллах хүч}}{\text{Хөдөлмөрийн насны хүн ам}} * 100\% \quad (3)$$

**Хөдөлмөр эрхлэлтийн түвшин:** Ажиллагчдын тоог хөдөлмөрийн насны хүн амын тоонд харьцуулж тооцно.

$$\text{Хөдөлмөр эрхлэлтийн түвшин} = \frac{\text{Ажиллагчдын тоо}}{\text{Хөдөлмөрийн насны хүн ам}} * 100\% \quad (4)$$

**Хөдөлмөрийн дутуу ашиглалтын түвшин:**

**Ажилгүйдлийн түвшин:** Ажилгүй хүний тоог ажиллах хүчний тоонд харьцуулж тооцно (ХДАТ-1).

$$\text{ХДАТ}_1 = \frac{\text{Ажилгүй хүний тоо}}{\text{Ажиллах хүч}} * 100\% \quad (5)$$

**Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэлт болон ажилгүйдлийн нэгдсэн түвшин:** Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгчид болон ажилгүй хүний тооны нийлбэрийг ажиллах хүчний тоонд харьцуулж тооцно (ХДАТ-2).

$$\text{ХДАТ}_2 = \frac{\text{Ажилгүй хүний тоо} + \text{ЦХХББХЭ}}{\text{Ажиллах хүч}} * 100\% \quad (6)$$

**Ажилгүй хүн болон боломжит ажиллах хүчний нэгдсэн түвшин:** Боломжит ажиллах хүч болон ажилгүй хүний тооны нийлбэрийг өргөтгөсөн ажиллах хүчний тоонд харьцуулж тооцно (ХДА-3).

$$\text{ХДАТ}_3 = \frac{\text{Ажилгүй хүний тоо} + \text{боломжит ажиллах хүч}}{\text{Өргөтгөсөн ажиллах хүч}} * 100\% \quad (7)$$

**Хөдөлмөрийн дутуу ашиглалтын нийлмэл түвшин:** Хөдөлмөрийн дутуу ашиглалт буюу ажилгүй хүн, цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгч болон боломжит ажиллах хүчний тооны нийлбэрийг өргөтгөсөн ажиллах хүчний тоонд харьцуулж тооцно (ХДА-4).

$$\text{ХДАТ}_4 = \frac{\text{Ажилгүй хүн} + \text{ЦХХББХЭ} + \text{БАХах хүч}}{\text{Өргөтгөсөн ажиллах хүч}} * 100\% \quad (8)$$

**Залуучуудын ажилгүйдлийн түвшин:** 15-24 насны ажилгүй хүний тоог 15-24 насны ажиллах хүчний тоонд харьцуулж тооцно.

$$\text{Залуучуудын ажилгүйдлийн түвшин} = \frac{15 - 24 \text{ насны ажилгүй хүний тоо}}{15 - 24 \text{ насны ажиллах хүчний тоо}} * 100\% \quad (9)$$

**Урт хугацааны ажилгүйдлийн түвшин:** Урт хугацаагаар ажилгүй байгаа хүний тоог ажиллах хүчний тоонд харьцуулж тооцно.

$$\begin{aligned} &\text{Урт хугацааны ажилгүйдлийн түвшин} \\ &= \frac{\text{Урт хугацаагаар ажилгүй байгаа хүний тоо}}{\text{Ажиллах хүч}} * 100\% \quad (10) \end{aligned}$$

**Хөдөлмөр эрхлээгүй болон боловсрол, сургалтад хамрагдаагүй байгаа залуучууд:** Тухайн хугацаанд боловсрол, сургалтад хамрагдаагүй байгаа 15-24 насны ажилгүй хүн болон ажиллах хүчнээс гадуурх залуучуудын тооны нийлбэрээр тооцно.

Хөдөлмөр эрхлээгүй болон боловсрол, сургалтад хамрагдаагүй байгаа залуучууд =  
 (Ажилгүй залуучууд + Ажиллах хүчнээс гадуурх залуучууд) – (Боловсрол, сургалтад  
 хамрагдаж байгаа ажилгүй залуучууд + Боловсрол, сургалтад хамрагдаж байгаа ажиллах  
 хүчнээс гадуурх залуучууд) (11)

**Тогтвортой хөгжлийн зорилтын хөдөлмөр эрхлэлтийн статистикийн үзүүлэлтүүд:**

**Удирдах албан тушаалд ажиллаж буй эмэгтэйчүүдийн эзлэх хувь /5.5.2/:** Үндэсний ажил, мэргэжлийн ангилал ба тодорхойлолт -08 (YAMAT08)-ын дэд бүлэг 11 “Хууль тогтоогч, удирдах албан тушаалтан, гүйцэтгэх захирал”, дэд бүлэг 12 “Захиргааны, арилжааны менежер” болон дэд бүлэг 13 “Үйлдвэрлэл, төрөлжсөн үйлчилгээний менежер” гэсэн ангиллын дагуу нийт дээд болон дунд шатны удирдах түвшний хөдөлмөр эрхэлж буй ажиллагчдад уг түвшний хөдөлмөр эрхэлж буй эмэгтэйчүүдийн эзлэх хувиар илэрхийлнэ.

Удирдах албан тушаалд ажиллаж буй эмэгтэйчүүдийн эзлэх хувь =  

$$= \frac{\text{YAMAT08} - 11,12,13 \text{ дэд бүлэгт хөдөлмөр эрхэлж буй нийт эмэгтэй ажиллагчдын тоо}}{\text{YAMAT08} - 11,12,13 \text{ дэд бүлэгт хөдөлмөр эрхэлж буй нийт ажиллагчдын тоо}} * 100\% \quad (12)$$

**Хөдөө аж ахуйн салбарт албан бус хөдөлмөр эрхлэгчдийн эрхлэгчдийн эзлэх хувь /8.3.1/:** Нийт хөдөө аж ахуйн бус салбарт ажиллагчдад албан бус хөдөлмөр эрхлэгчдийн эзлэх хувиар илэрхийлнэ.

Хөдөө аж ахуйн бус салбарт албан бус хөдөлмөр эрхлэгчдийн эзлэх хувь =  

$$= \frac{\text{ХАА} - \text{н бус салбарт ажиллаж буй АБХЭ}}{\text{Нийт ХАА} - \text{н бус салбарт ажиллагчид}} * 100\% \quad (13)$$

**Цалин хөлстэй эмэгтэй, эрэгтэй ажиллагчдын цагийн дундаж цалин хөлс /8.5.1/:** Хүйсээрх цалин хөлсний ялгаатай байдлаар илэрхийлэгдэх бөгөөд нийт ажиллагчдаас зөвхөн цалин хөлстэй эрэгтэй болон эмэгтэй ажиллагчдын цагийн дундаж цалин хөлсний зөрүүг эрэгтэй ажиллагчдын цагийн дундаж цалинд харьцуулж тооцно.

Хүйсээрх цалин хөлсний ялгаа  

$$= \frac{\text{Цагийн дундаж цалин хөлс}_{\text{эрэгтэй}} - \text{Цагийн дундаж цалин хөлс}_{\text{эмэгтэй}}}{\text{Цагийн дундаж цалин хөлс}_{\text{эрэгтэй}}} * 100\% \quad (14)$$

**Хөдөлмөр эрхлээгүй болон боловсрол, сургалтад хамрагдаагүй байгаа залуучуудын эзлэх хувь /8.6.1/:** 15-24 насны хөдөлмөр эрхлээгүй болон боловсрол, сургалтад хамрагдаагүй байгаа залуучуудын тоог нийт 15-24 насны залуучуудын тоонд харьцуулж тооцно.

Хөдөлмөр эрхлээгүй болон боловсрол, сургалтад хамрагдаагүй байгаа залуучуудын эзлэх хувь =  

$$= \frac{\text{15-24 насны хөдөлмөр эрхлээгүй болон боловсрол, сургалтад хамрагдаагүй байгаа залуучуудын тоо}}{\text{нийт 15-24 насны залуучууд тоо}} * 100\% \quad (15)$$

**Хөдөлмөр эрхэлж буй 5-17 насны хүүхдийн эзлэх хувь /8.7.1/:** 5-17 насны хөдөлмөр эрхэлж буй хүүхдийн тоог нийт 5-17 насны хүүхдийн тоонд харьцуулж тооцно.


Хөдөлмөр эрхэлж буй 5 – 17 насны хүүхдийн эзлэх хувь =  

$$= \frac{\text{Хөдөлмөр эрхэлж буй 5 – 17 насны хүүхдийн тоо}}{\text{нийт 5 – 17 насны хүүхдийн тоо}} * 100\% \quad (16)$$


ХҮСНЭГТ Б.1. ҮНДЭСНИЙ ТООЦООНЫ СИСТЕМ БОЛОН АЖЛЫН ХЭЛБЭР

Үйлдвэрлэлийн зориулалт	Өөрийн эцсийн хэрэглээнд		Бусдын хэрэглээнд					
Ажлын хэлбэрүүд	Өөрийн хэрэгцээний үйлдвэрлэлийн ажил		Хөдөлмөр эрхлэлт (цалин хөлс, орлого олох зорилготой хийгдсэн)	Цалин хөлсгүй дадлагажих ажил	Бусад ажлын үйл ажиллагаа	Сайн дурын ажил		
	Үйлчилгээ	Бүтээгдэхүүн				Зах зээлийн болон зах зээлийн бус нэгжүүд	Өрхийн үйлдвэрлэл	
							Бүтээгдэхүүн	Үйлчилгээ
2008 оны ҮТС-тэй холбогдох нь			ҮТС-ийн үйлдвэрлэлийн хүрээн дэх үйл ажиллагаанууд ҮТС-ийн үйлдвэрлэлийн ерөнхий хүрээн дэх үйл ажиллагаанууд					


СХЕМ Б.2. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БОЛОН АЖИЛЛАХ ХҮЧНИЙ СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТИЙН ХҮРЭЭ




СХЕМ Б.3. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН СТАТУС



## СХЕМ Б.4. АЖИЛЛАГЧДЫГ ТОДОРХОЙЛОХ




СХЕМ Б.5. АЖЛЫН БАЙРАНДАА ТҮР ЭЗГҮЙ БАЙГАА АЖИЛЛАГЧДЫГ ТОДОРХОЙЛОХ





СХЕМ Б.6. АЖИЛГҮЙ ХҮН БОЛОН АЖИЛЛАХ ХҮЧНЭЭС ГАДУУРХ ХҮН АМ ТОДОРХОЙЛОХ

Н01а-д хариулсан бүх хүн ажиллагч биш.



## ХАВСРАЛТ В. ХӨДӨЛМӨРИЙН СТАТИСТИКИЙН СТАНДАРТ АЛДАА БА ИТГЭМЖЛЭЛТ ИНТЕРВАЛУУД

### ХҮСНЭГТ В.1. Ажиллах хүч

	Тооцооны утга	Ажиглалтын тоо	Стандарт алдаа	95% итгэмжлэгдэх магадлал		Вариацийн коэффициент
				Доод	Дээд	
НИЙТ	1 225 369	19 739	726.4	1 223 916	1 226 822	0.1
Байршлаар:						
Хот	837 553	6 208	626.5	836 300	838 806	0.1
Хөдөө	387 816	13 531	355.9	387 104	388 528	0.1
Хүйсээр:						
Эрэгтэй	647 995	10 624	475.2	647 045	648 945	0.1
Эмэгтэй	577 374	9 115	538.0	576 298	578 450	0.1
Бүсээр:						
Баруун	182 769	3 910	263.2	182 243	183 295	0.1
Хангай	240 367	4 522	292.6	239 782	240 952	0.1
Төв	187 599	5 572	280.3	187 038	188 160	0.1
Зүүн	97 731	2 793	178.4	97 374	98 088	0.2
Улаанбаатар	516 903	2 942	504.1	515 895	517 911	0.1
Аймгаар:						
Архангай	39 428	726	114.7	39 199	39 657	0.3
Баян-Өлгий	39 834	651	145.1	39 544	40 124	0.4
Баянхонгор	34 390	774	108.8	34 172	34 608	0.3
Булган	24 778	630	99.3	24 579	24 977	0.4
Говь-Алтай	23 946	773	90.0	23 766	24 126	0.4
Дорноговь	28 359	926	103.3	28 152	28 566	0.4
Дорнод	31 844	835	109.2	31 626	32 062	0.3
Дундговь	23 309	1 045	81.4	23 146	23 472	0.3
Завхан	29 837	711	101.0	29 635	30 039	0.3
Өвөрхангай	52 594	772	129.4	52 335	52 853	0.2
Өмнөговь	29 339	877	102.7	29 134	29 544	0.4
Сүхбаатар	28 839	964	93.6	28 652	29 026	0.3
Сэлэнгэ	28 866	539	128.2	28 610	29 122	0.4
Төв	36 375	939	115.7	36 144	36 606	0.3
Увс	49 532	936	117.9	49 296	49 768	0.2
Ховд	39 620	839	114.9	39 390	39 850	0.3
Хөвсгөл	52 576	755	137.8	52 300	52 852	0.3
Хэнтий	37 048	994	104.7	36 839	37 257	0.3
Дархан-Уул	33 487	768	125.0	33 237	33 737	0.4
Орхон	36 601	865	121.2	36 359	36 843	0.3
Говьсүмбэр	7 864	478	50.4	7 763	7 965	0.6

ХҮСНЭГТ В.2. Ажиллах хүчнээс гадуурх хүн ам

	Тооцооны утга	Ажиглалтын тоо	Стандарт алдаа	95% итгэмжлэгдэх магадлал		Вариацийн коэффициент
				Доод	Дээд	
НИЙТ	926 788	11 710	726.4	925 335	928 241	0.1
Байршлаар:						
Хот	738 746	5 262	626.5	737 493	739 999	0.1
Хөдөө	188 042	6 448	355.9	187 330	188 754	0.2
Хүйсээр:						
Эрэгтэй	346 542	4 491	475.2	345 592	347 492	0.1
Эмэгтэй	580 246	7 219	538.0	579 170	581 322	0.1
Бүсээр:						
Баруун	111 555	2 160	263.2	111 029	112 081	0.2
Хангай	133 032	2 140	292.6	132 447	133 617	0.2
Төв	135 210	3 337	280.3	134 649	135 771	0.2
Зүүн	47 199	1 209	178.4	46 842	47 556	0.4
Улаанбаатар	499 792	2 864	504.1	498 784	500 800	0.1
Аймгаар:						
Архангай	19 745	281	114.7	19 516	19 974	0.6
Баян-Өлгий	44 699	1 013	145.1	44 409	44 989	0.3
Баянхонгор	18 062	307	108.8	17 844	18 280	0.6
Булган	16 362	416	99.3	16 163	16 561	0.6
Говь-Алтай	12 222	278	90.0	12 042	12 402	0.7
Дорноговь	17 093	396	103.3	16 886	17 300	0.6
Дорнод	19 038	473	109.2	18 820	19 256	0.6
Дундговь	9 261	385	81.4	9 098	9 424	0.9
Завхан	15 493	241	101.0	15 291	15 695	0.7
Өвөрхангай	24 579	318	129.4	24 320	24 838	0.5
Өмнөговь	16 464	360	102.7	16 259	16 669	0.6
Сүхбаатар	12 591	387	93.6	12 404	12 778	0.7
Сэлэнгэ	38 103	918	128.2	37 847	38 359	0.3
Төв	21 193	398	115.7	20 962	21 424	0.5
Увс	19 324	228	117.9	19 088	19 560	0.6
Ховд	19 817	400	114.9	19 587	20 047	0.6
Хөвсгөл	29 736	300	137.8	29 460	30 012	0.5
Хэнтий	15 570	349	104.7	15 361	15 779	0.7
Дархан-Уул	29 336	647	125.0	29 086	29 586	0.4
Орхон	24 548	518	121.2	24 306	24 790	0.5
Говьсүмбэр	3 760	233	50.4	3 659	3 861	1.3

## ХҮСНЭГТ В.3. Ажиллагчид

	Тооцооны утга	Ажиглалт -ын тоо	Стандарт алдаа	95% итгэмжлэгдэх магадлал		Вариацийн коэффициент
				Доод	Дээд	
НИЙТ	1 125 591	18 388	732.7	1 124 126	1 127 056	0.1
Байршлаар:						
Хот	758 227	5 538	627.3	756 972	759 482	0.1
Хөдөө	367 364	12 850	364.7	366 635	368 093	0.1
Хүйсээр:						
Эрэгтэй	592 805	9 850	489.3	591 826	593 784	0.1
Эмэгтэй	532 786	8 538	536.3	531 713	533 859	0.1
Бүсээр:						
Баруун	166 889	3 628	268.8	166 351	167 427	0.2
Хангай	220 247	4 237	300.6	219 646	220 848	0.1
Төв	169 094	5 151	283.8	168 526	169 662	0.2
Зүүн	93 555	2 664	182.1	93 191	93 919	0.2
Улаанбаатар	475 806	2 708	503.1	474 800	476 812	0.1
Аймгаар:						
Архангай	38 312	701	116.2	38 080	38 544	0.3
Баян-Өлгий	34 275	541	142.8	33 989	34 561	0.4
Баянхонгор	29 066	709	113.8	28 838	29 294	0.4
Булган	23 950	613	100.0	23 750	24 150	0.4
Говь-Алтай	21 260	721	93.6	21 073	21 447	0.4
Дорноговь	27 582	918	104.1	27 374	27 790	0.4
Дорнод	29 797	760	111.1	29 575	30 019	0.4
Дундговь	21 966	994	84.6	21 797	22 135	0.4
Завхан	27 824	687	103.7	27 617	28 031	0.4
Өвөрхангай	50 616	747	132.0	50 352	50 880	0.3
Өмнөговь	27 300	835	105.0	27 090	27 510	0.4
Сүхбаатар	28 029	945	95.2	27 839	28 219	0.3
Сэлэнгэ	21 699	416	121.1	21 457	21 941	0.6
Төв	35 606	920	116.5	35 373	35 839	0.3
Увс	47 479	905	121.4	47 236	47 722	0.3
Ховд	36 051	774	119.1	35 813	36 289	0.3
Хөвсгөл	47 344	717	141.8	47 060	47 628	0.3
Хэнтий	35 729	959	107.1	35 515	35 943	0.3
Дархан-Уул	28 077	650	124.6	27 828	28 326	0.4
Орхон	30 959	750	123.6	30 712	31 206	0.4
Говьсүмбэр	6 864	418	53.0	6 758	6 970	0.8

ХҮСНЭГТ В.4. Хөдөлмөрийн дутуу ашиглалт

	Тооцооны утга	Ажиглалтын тоо	Стандарт алдаа	95% итгэмжлэгдэх магадлал		Вариацийн коэффициент
				Доод	Дээд	
НИЙТ	177 283	2 282	403.3	176 476	178 090	0.2
Байршлаар:						
Хот	140 190	1 075	357.4	139 475	140 905	0.3
Хөдөө	37 093	1 207	186.3	36 720	37 466	0.5
Хүйсээр:						
Эрэгтэй	93 315	1 219	290.8	92 733	93 897	0.3
Эмэгтэй	83 968	1 063	279.1	83 410	84 526	0.3
Бүсээр:						
Баруун	36 107	681	178.0	35 751	36 463	0.5
Хангай	23 991	351	149.8	23 691	24 291	0.6
Төв	24 515	556	150.5	24 214	24 816	0.6
Зүүн	8 331	203	88.6	8 154	8 508	1.1
Улаанбаатар	84 339	491	278.1	83 783	84 895	0.3
Аймгаар:						
Архангай	1 116	25	33.1	1 050	1 182	3.0
Баян-Өлгий	19 161	384	121.7	18 918	19 404	0.6
Баянхонгор	5 653	75	71.0	5 511	5 795	1.3
Булган	2 061	48	44.2	1 973	2 149	2.1
Говь-Алтай	2 867	58	51.4	2 764	2 970	1.8
Дорноговь	785	9	27.8	729	841	3.5
Дорнод	4 308	120	62.8	4 182	4 434	1.5
Дундговь	1 724	67	40.4	1 643	1 805	2.3
Завхан	4 281	83	62.3	4 156	4 406	1.5
Өвөрхангай	2 609	34	50.2	2 509	2 709	1.9
Өмнөговь	2 481	51	48.4	2 384	2 578	2.0
Сүхбаатар	1 569	34	38.9	1 491	1 647	2.5
Сэлэнгэ	10 424	188	93.8	10 236	10 612	0.9
Төв	2 397	47	47.9	2 301	2 493	2.0
Увс	3 457	45	57.3	3 342	3 572	1.7
Ховд	6 341	111	75.3	6 190	6 492	1.2
Хөвсгөл	6 601	48	77.9	6 445	6 757	1.2
Хэнтий	2 454	49	48.4	2 357	2 551	2.0
Дархан-Уул	5 505	120	70.9	5 363	5 647	1.3
Орхон	5 951	121	73.3	5 804	6 098	1.2
Говьсүмбэр	1 199	74	32.8	1 133	1 265	2.7

## ХҮСНЭГТ В.5. Ажилгүй хүн

	Тооцооны утга	Ажиглалтын тоо	Стандарт алдаа	95% итгэмжлэгдэх магадлал		Вариацийн коэффициент
				Доод	Дээд	
НИЙТ	99 778	1 351	308.5	99 161	100 395	0.3
Байршлаар:						
Хот	79 326	670	274.5	78 777	79 875	0.3
Хөдөө	20 452	681	140.5	20 171	20 733	0.7
Хүйсээр:						
Эрэгтэй	55 190	774	228.3	54 733	55 647	0.4
Эмэгтэй	44 588	577	207.1	44 174	45 002	0.5
Бүсээр:						
Баруун	15 880	282	122.6	15 635	16 125	0.8
Хангай	20 120	285	138.0	19 844	20 396	0.7
Төв	18 505	421	132.1	18 241	18 769	0.7
Зүүн	4 176	129	63.7	4 049	4 303	1.5
Улаанбаатар	41 097	234	198.6	40 700	41 494	0.5
Аймгаар:						
Архангай	1 116	25	33.1	1 050	1 182	3.0
Баян-Өлгий	5 559	110	72.1	5 415	5 703	1.3
Баянхонгор	5 324	65	69.2	5 186	5 462	1.3
Булган	828	17	28.5	771	885	3.4
Говь-Алтай	2 686	52	49.9	2 586	2 786	1.9
Дорноговь	777	8	27.6	722	832	3.6
Дорнод	2 047	75	44.3	1 958	2 136	2.2
Дундговь	1 343	51	35.9	1 271	1 415	2.7
Завхан	2 013	24	43.9	1 925	2 101	2.2
Өвөрхангай	1 978	25	43.9	1 890	2 066	2.2
Өмнөговь	2 039	42	44.1	1 951	2 127	2.2
Сүхбаатар	810	19	28.2	754	866	3.5
Сэлэнгэ	7 167	123	80.0	7 007	7 327	1.1
Төв	769	19	27.5	714	824	3.6
Увс	2 053	31	44.6	1 964	2 142	2.2
Ховд	3 569	65	57.9	3 453	3 685	1.6
Хөвсгөл	5 232	38	70.0	5 092	5 372	1.3
Хэнтий	1 319	35	35.9	1 247	1 391	2.7
Дархан-Уул	5 410	118	70.3	5 269	5 551	1.3
Орхон	5 642	115	71.6	5 499	5 785	1.3
Говьсүмбэр	1 000	60	30.2	940	1 060	3.0

ХҮСНЭГТ В.6. Боломжит ажиллах хүч

	Тооцооны утга	Ажиглалтын тоо	Стандарт алдаа	95% итгэмжлэгдэх магадлал		Вариацийн коэффициент
				Доод	Дээд	
НИЙТ	71 409	823	262.8	70 883	71 935	0.4
Байршлаар:						
Хот	57 230	376	234.8	56 760	57 700	0.4
Хөдөө	14 179	447	117.6	13 944	14 414	0.8
Хүйсээр:						
Эрэгтэй	34 978	396	183.7	34 611	35 345	0.5
Эмэгтэй	36 431	427	187.8	36 055	36 807	0.5
Бүсээр:						
Баруун	15 831	309	122.4	15 586	16 076	0.8
Хангай	3 740	64	60.8	3 618	3 862	1.6
Төв	5 773	127	75.3	5 622	5 924	1.3
Зүүн	3 972	73	62.2	3 848	4 096	1.6
Улаанбаатар	42 093	250	200.9	41 691	42 495	0.5
Аймгаар:						
Архангай	-	-	-	-	-	-
Баян-Өлгий	10 645	228	96.5	10 452	10 838	0.9
Баянхонгор	329	10	18.1	293	365	5.5
Булган	1 233	31	34.6	1 164	1 302	2.8
Говь-Алтай	148	3	12.2	124	172	8.2
Дорноговь	8	1	2.9	2	14	34.7
Дорнод	2 078	44	44.6	1 989	2 167	2.1
Дундговь	298	12	17.2	264	332	5.8
Завхан	969	22	30.8	907	1 031	3.2
Өвөрхангай	631	9	25.0	581	681	4.0
Өмнөговь	442	9	20.9	400	484	4.7
Сүхбаатар	759	15	27.3	704	814	3.6
Сэлэнгэ	3 257	65	55.7	3 146	3 368	1.7
Төв	1 515	27	38.4	1 438	1 592	2.5
Увс	1 297	10	35.7	1 226	1 368	2.8
Ховд	2 772	46	51.4	2 669	2 875	1.9
Хөвсгөл	1 238	8	34.9	1 168	1 308	2.8
Хэнтий	1 135	14	33.3	1 068	1 202	2.9
Дархан-Уул	95	2	9.7	76	114	10.3
Орхон	309	6	17.5	274	344	5.7
Говьсүмбэр	158	11	12.5	133	183	7.9

## ХҮСНЭГТ В.7. Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгч

	Тооцооны утга	Ажиглалтын тоо	Стандарт алдаа	95% итгэмжлэгдэх магадлал		Вариацийн коэффициент
				Доод	Дээд	
НИЙТ	6 096	108	78.0	5 940	6 252	1.3
Байршлаар:						
Хот	3 634	29	60.2	3 514	3 754	1.7
Хөдөө	2 462	79	49.5	2 363	2 561	2.0
Хүйсээр:						
Эрэгтэй	3 147	49	56.0	3 035	3 259	1.8
Эмэгтэй	2 949	59	54.2	2 841	3 057	1.8
Бүсээр:						
Баруун	4 396	90	65.8	4 264	4 528	1.5
Хангай	131	2	11.4	108	154	8.7
Төв	237	8	15.4	206	268	6.5
Зүүн	183	1	13.5	156	210	7.4
Улаанбаатар	1 149	7	33.9	1 081	1 217	2.9
Аймгаар:						
Архангай	-	-	-	-	-	-
Баян-Өлгий	2 957	46	53.4	2 850	3 064	1.8
Баянхонгор	-	-	-	-	-	-
Булган	-	-	-	-	-	-
Говь-Алтай	33	3	6	22	44	17
Дорноговь	-	-	-	-	-	-
Дорнод	183	1	13.5	156	210	7.4
Дундговь	83	4	9.1	65	101	10.9
Завхан	1 299	37	35.5	1 228	1 370	2.7
Өвөрхангай	-	-	-	-	-	-
Өмнөговь	-	-	-	-	-	-
Сүхбаатар	-	-	-	-	-	-
Сэлэнгэ	-	-	-	-	-	-
Төв	113	1	10.6	92	134	9.4
Увс	107	4	10.3	86	128	9.7
Ховд	-	-	-	-	-	-
Хөвсгөл	131	2	-	-	-	-
Хэнтий	-	-	-	-	-	-
Дархан-Уул	-	-	-	-	-	-
Орхон	-	-	-	-	-	-
Говьсүмбэр	41	3	6.4	28	54	15.6



ХҮСНЭГТ В.8. Ажиллах хүчний оролцооны түвшин

	Тооцооны утга	Стандарт алдаа	95% итгэмжлэгдэх магадлал		Вариацийн коэффициент
			Доод	Дээд	
НИЙТ	56.9	0.57	55.8	58.1	0.1
Байршлаар:					
Хот	53.1	0.53	52.1	54.2	0.1
Хөдөө	67.3	0.67	66.0	68.7	0.1
Хүйсээр:					
Эрэгтэй	65.2	0.65	63.9	66.5	0.1
Эмэгтэй	49.9	0.50	48.9	50.9	0.1
Бүсээр:					
Баруун	62.1	0.62	60.9	63.3	0.1
Хангай	64.4	0.64	63.1	65.7	0.1
Төв	58.1	0.58	57.0	59.3	0.1
Зүүн	67.4	0.67	66.1	68.8	0.2
Улаанбаатар	50.8	0.51	49.8	51.9	0.1
Аймгаар:					
Архангай	73.6	0.67	72.3	75.0	0.3
Баян-Өлгий	54.0	0.47	53.0	54.9	0.4
Баянхонгор	67.3	0.66	66.0	68.6	0.3
Булган	69.5	0.60	68.3	70.7	0.4
Говь-Алтай	75.8	0.66	74.4	77.1	0.4
Дорноговь	69.7	0.62	68.5	71.0	0.4
Дорнод	73.1	0.63	71.9	74.4	0.3
Дундговь	77.6	0.72	76.2	79.1	0.3
Завхан	69.8	0.66	68.4	71.1	0.3
Өвөрхангай	78.2	0.68	76.8	79.5	0.2
Өмнөговь	70.5	0.64	69.2	71.8	0.4
Сүхбаатар	77.4	0.70	76.0	78.8	0.3
Сэлэнгэ	47.0	0.43	46.2	47.9	0.4
Төв	75.2	0.63	74.0	76.5	0.3
Увс	75.1	0.72	73.7	76.5	0.2
Ховд	72.9	0.67	71.6	74.3	0.3
Хөвсгөл	73.3	0.64	72.1	74.6	0.3
Хэнтий	73.9	0.70	72.5	75.3	0.3
Дархан-Уул	62.9	0.53	61.8	64.0	0.4
Орхон	70.7	0.60	69.5	71.9	0.3
Говьсүмбэр	73.4	0.68	72.0	74.7	0.6

ХҮСНЭГТ В.9. Хөдөлмөр эрхлэлтийн түвшин

	Тооцооны утга	Стандарт алдаа	95% итгэмжлэгдэх магадлал		Вариацийн коэффициент
			Доод	Дээд	
НИЙТ	52.3	0.60	51.1	53.5	0.1
Байршлаар:					
Хот	48.1	0.48	47.1	49.1	0.1
Хөдөө	63.8	0.64	62.5	65.1	0.1
Хүйсээр:					
Эрэгтэй	59.6	0.09	59.4	59.8	0.3
Эмэгтэй	46.0	0.07	45.9	46.2	0.3
Бүсээр:					
Баруун	56.7	0.57	55.6	57.8	0.2
Хангай	59.0	0.59	57.8	60.2	0.1
Төв	52.4	0.52	51.3	53.4	0.2
Зүүн	64.6	0.65	63.3	65.8	0.2
Улаанбаатар	46.8	0.47	45.9	47.7	0.1
Аймгаар:					
Архангай	64.7	0.65	63.5	66.0	0.3
Баян-Өлгий	40.5	0.41	39.7	41.4	0.4
Баянхонгор	55.4	0.55	54.3	56.5	0.4
Булган	58.2	0.58	57.1	59.4	0.4
Говь-Алтай	58.8	0.59	57.6	60.0	0.4
Дорноговь	60.7	0.61	59.5	61.9	0.4
Дорнод	58.6	0.59	57.4	59.7	0.4
Дундговь	67.4	0.67	66.1	68.8	0.4
Завхан	61.4	0.61	60.2	62.6	0.4
Өвөрхангай	65.6	0.66	64.3	66.9	0.3
Өмнөговь	59.6	0.60	58.4	60.8	0.4
Сүхбаатар	67.7	0.68	66.3	69.0	0.3
Сэлэнгэ	32.4	0.32	31.8	33.0	0.6
Төв	61.9	0.62	60.6	63.1	0.3
Увс	69.0	0.69	67.6	70.3	0.3
Ховд	60.7	0.61	59.4	61.9	0.3
